

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ

ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН БАРИМТ БИЧИГ

Улаанбаатар хот
2017 он



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.09.28 № 4-1/5882

танай _____-ны № _____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ж.МӨНХБАТ ТАНАА

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу хуулийн төслүүдийн үзэл баримтлал, өргөн мэдүүлэх зөвшөөрөл болон холбогдох бусад материалын хамт хүргүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-т заасны дагуу хуулийн төслийг өргөн мэдүүлж өгнө үү.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



В.ЧОЙЖИЛСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С. Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74 68, <http://www.mof.gov.mn>

2017.09.28 № 4-1/5883

танай _____-ны № _____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ж.МӨНХБАТ ТАНАА

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон холбогдох бусад материалын хамт Улсын Их Хуралд өргөн мөдүүлэхийг зөвшөөрөв.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН





**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2017. 9. 28 № 1-1/3628
танай 2017. 9. 26 ны № 41/5622 -Т

**САНГИЙН САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЧОЙЖИЛСҮРЭН
ТАНАА**

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.8-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

С.БЯМБАЦОГТ



08 2367


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэлд:

“Ү.ХЭЛЭЛЦСЭН нь:

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛЫГ
ӨРГӨН МЭДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ТОВЪОЁГ**



- 1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2018-2019 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**
 - 1.1. Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал
 - 1.2. Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
 - 1.3. Монгол улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

- 2. МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**
 - 2.1. Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал
 - 2.2. Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
 - 2.3. Монгол улсын 2017 оны төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хавсралт
 - 2.3.1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
 - 2.3.2. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
 - 2.4. Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

- 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**
 - 3.1. Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал
 - 3.2. Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
 - 3.3. Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

- 4. ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД**

1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2018-2019 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2018-2019 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Эдийн засгийн өсөлт эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрэн сэргэж байна. Нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалын үнэ харьцангуй өндөр түвшинд хүрсэн нь уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарт өсөлт бий болж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт нэмэгдсэн зэрэг нь 2017 онд төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давж биелэхэд нөлөөлсөн байна.

ОУВС болон Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн эхний шатны үнэлгээг 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс 8 дугаар сарын 2-ны өдрийн хооронд ажлын хэсгийн түвшинд хийж зорилтод үзүүлэлтүүдийг шинэчлэн тохирсон. Хөтөлбөрийн хүрээнд тохирсны дагуу төсвийн давсан орлогын тодорхой хэсгийг дараахь үндэслэл, шаардлагын дагуу зарцуулах шаардлагатай байна. Тухайлбал,

1/ хүүхдийн мөнгө хөтөлбөрийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд нэмж шаардагдах зардлыг төсөвт тусгах;

2/ өсөн нэмэгдэж байгаа боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд нийцүүлж шаардагдах зардлыг тооцож төсөвт тусгах;

3/ 2018 он болон түүний дараагийн жилүүдэд төсөвт дарамт үзүүлэхгүй, нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий нэг удаагийн шинжтэй зардлыг тусган хэрэгжүүлэх;

4/ өмнөх жилүүдэд гэрээ нь хийгдсэн “Барих-Шилжүүлэх” концессын төслийн эргэн төлөлт, хөнгөлөлттэй зээлийн Монголын талын хариуцах санхүүжилт, шүүхийн шийдвэртэй болон бусад өр төлбөрүүдийг барагдуулах зэрэг зайлшгүй шаардлага үүсч байна.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тоон үзүүлэлтүүдийг хүснэгтээр батлах тухай гэсэн нэг зүйлтэй байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар ОУВС-ын хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн тохирсон зарим арга хэмжээ, 2017 оны төсөв батлагдсанаас хойш хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах болон цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хууль, тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар сарын ...-ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2018-2019 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

| Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | | Төсвийн хүрээний мэдэгдэл | Төсвийн төсөөлөл. | |
|-------------------------------|---|---------------------------|-------------------|----------|
| | | 2017 он | 2018 он | 2019 он |
| 1 | Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/ | 3.3 | 4.0 | 6.6 |
| 2 | Хэрэглээний үнийн индексийн түвшин | 7.7 | 8.6 | 8.0 |
| 3 | Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ | 6,537.1 | 7,218.0 | 8,217.5 |
| | -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 23.8 | 23.8 | 24.1 |
| 4 | Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ | 9,248.6 | 9,828.8 | 10,323.3 |
| | -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 33.7 | 32.4 | 30.3 |
| 5 | Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/ | -246.7 | 580.2 | 494.6 |
| | -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | -0.9 | 1.9 | 1.5 |
| 6 | Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ | -2,711.5 | -2,610.8 | -2,105.8 |
| | -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | -9.9 | -8.6 | -6.2 |
| 7 | Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/ | 1,887.8 | 2,102.3 | 1,979.4 |
| | -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 6.9 | 6.9 | 5.8 |
| 8 | Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/ | 23,322.3 | 24,272.8 | 25,556.3 |
| | -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 85.0 | 80.0 | 75.0 |
| 9 | Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/ | 583.1 | 606.7 | 648.6 |
| | -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 2.1 | 2.0 | 1.9 |

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2018-2019 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хууль Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар батлагдсан. Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар тус хуульд өөрчлөлт оруулсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг **6,035.7 тэрбум төгрөг** буюу ДНБ-ий **23.2 хувь**, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг **8,750.2 тэрбум төгрөг** буюу **ДНБ-ий 33.6 хувь**, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл **-2,714.4 тэрбум төгрөг**ийн алдагдалтай буюу **ДНБ-ий -10.4 хувь**тай байхаар тусгагдсан.

ОУВС болон Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн эхний шатны үнэлгээг 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс 8 дугаар сарын 2-ны өдрийн хооронд ажлын хэсгийн түвшинд хийсэн. ОУВС-ийн ажлын хэсгийн зүгээс хөтөлбөр сайн хэрэгжиж, бүх тоон зорилтууд хангагдсан болохыг мэдэгдсэн.

Эдийн засгийн өсөлт эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрэн сэргэж, нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалуудын үнэ харьцангуй өндөр түвшинд байгаа болон уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарын өсөлтөөс үүдэн бизнесийн орчин харьцангуй идэвхжиж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ онд төвлөрүүлэхээр төлөвлөсөн төсвийн орлого ихээхэн хэмжээгээр давахаар байна.



Давсан орлогын тодорхой хэсгийг нэг удаагийн шинж чанартай, ирэх жилүүдэд төсөвт ачаалал үүсгэхгүй байх ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, болзошгүй өр төлбөрийг барагдуулах болон цаг үеийн нөхцөл байдал, үүссэн бодит хэрэгцээ, шаардлагыг харгалзан зайлшгүй нэмэгдүүлэх чиглэлээр төсвийн зарлагад зарим өөрчлөлтүүдийг тусган төсөвт тодотгол хийх талаар ОУВС-ын хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний явцад тохирсон болно.

Хөтөлбөрийн эхний үнэлгээ болон Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголын төсөлтэй холбоотойгоор дунд хугацааны макро эдийн засгийн тооцоолол, төсвийн орлого, зарлагын төсөөлөл зэрэг үндсэн үзүүлэлтүүд

өөрчлөгдөхөөр байна. Энэ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн хэмжээг өөрчлөх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

--- оОо ---

**2. МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**



МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34.1.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх тохиолдолд тодотголын төслийг боловсруулна” гэж заасан нь Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах хууль эрх зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик шаардлага

Эдийн засгийн өсөлт эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрэн сэргэж байна. Нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалын үнэ харьцангуй өндөр түвшинд хүрсэн нь уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарт өсөлт бий болж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт нэмэгдсэн зэрэг нь 2017 онд төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давж биелэхэд нөлөөлсөн байна.

ОУВС болон Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн эхний шатны үнэлгээг 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс 8 дугаар сарын 2-ны өдрийн хооронд ажлын хэсгийн түвшинд хийж зорилтод үзүүлэлтүүдийг шинэчлэн тохирсон. Хөтөлбөрийн хүрээнд тохирсны дагуу төсвийн давсан орлогын тодорхой хэсгийг дараахь үндэслэл, шаардлагын дагуу зарцуулах шаардлагатай байна. Тухайлбал,

1/ хууль тогтоомжийн өөрчлөлт, нийгмийн хамгааллын бодлогод орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд нэмж шаардагдах зардлыг төсөвт тусгах;

2/ өсөн нэмэгдэж байгаа боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд нийцүүлж шаардагдах зардлыг тооцож төсөвт тусгах;

3/ 2018 он болон түүний дараагийн жилүүдэд төсөвт дарамт үзүүлэхгүй, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой дор дурдсан зориулалт бүхий нэг удаагийн шинжтэй зардлыг тусган хэрэгжүүлэх. Үүнд:

а. Өвөлжилт, цаг агаарын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгах;

б. 2015-2017 оны эхний хагас жилд тохиолдсон байгалийн аюулт үзэгдэл, мал, амьтны гоц халдварт өвчний улмаас учирсан хохирлыг барагдуулах;

в. Орон нутаг болон улсын төсвийн байгууллагуудад хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх;

г. Шүүхийн шийдвэрийн дагуу төрөөс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад олгох төлбөрийг барагдуулах;

д. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхэд төсвөөс дэмжлэг үзүүлэх.

4/ төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангах зарчимд нийцүүлэн төсвийн 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл, салбарын яамдаас бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг харгалзан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын батлагдсан төсөвт зарим зохицуулалтын шинжтэй өөрчлөлтийг төсвийн тодотголд тусгах;

5/ өмнөх жилүүдэд гэрээ нь хийгдсэн “Барих-Шилжүүлэх” концессын төслийн эргэн төлөлт, хөнгөлөлттэй зээлийн Монголын талын хариуцах санхүүжилт, шүүхийн шийдвэртэй болон бусад өр төлбөрүүдийг барагдуулах зайлшгүй шаардлага үүсэж байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 6 зүйлтэй байна.

1-рт Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 3, 5, 16, 17 дугаар зүйлүүдийг өөрчлөн найруулж, түүнтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын орлого, зарлагын хэмжээ, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг өөрчлөх;

2-рт Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт" хавсралтад өөрчлөлт оруулах;

3-рт Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт" хавсралтад өөрчлөлт оруулах;

4-рт хуульд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор тоон үзүүлэлтүүдийг өөрчлөн тусгах;

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар ОУВС-ын хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн тохирсон зарим арга хэмжээ, 2017 оны төсөв батлагдсанаас хойш хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах болон цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид бүрэн нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар сарын ... ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн дараахь зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/3 дугаар зүйл:

"3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

| Д/д | Төсвийн ерөнхийлөн захирагч | Дүн /сая төгрөгөөр/ |
|-----|--|---|
| 1 | Монгол Улсын Их Хурлын дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 2,717.8 2,717.8 |
| 2 | Монгол Улсын Ерөнхий аудитор Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 720.9 720.9 |
| 3 | Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 60.0 60.0 |
| 4 | Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 822.4 822.4 |
| 5 | Үндэсний статистикийн хорооны дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 985.6 979.6 6.0 |
| 6 | Монгол Улсын Ерөнхий сайд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 31,718.6 2,500.0 25,796.1 3,422.5 |
| 7 | Авлигатай тэмцэх газар Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 105.8 105.8 |
| 8 | Монгол Улсын Шадар сайд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Стандарт, хэмжил зүйн газар Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 11,956.0 2,600.0 2,486.0 2,080.9 4,789.1 |
| 9 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 895.5 753.0 142.5 |
| 10 | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 14,376.9 14,096.4 280.5 |
| 11 | Гадаад харилцааны сайд Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Дипломат төлөөлөгчийн газрууд Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 20,327.1 777.1 18,000.0 1,550.0 |
| 12 | Сангийн сайд Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд Ирээдүйн өв санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 4,366,835.3 2,318,513.7 242,417.9 333,345.1 1,897,248.8 16,529.3 121,427.0 9,796.9 3,319.5 |
| 13 | Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 62,733.1 18,000.0 3,487.5 20,600.7 4,100.7 16,544.1 |
| 14 | Батлан хамгаалахын сайд Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 59,006.0 4,871.5 54,134.5 |
| 15 | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 9,976.7 5,003.4 4,973.4 |
| 16 | Зам, тээврийн хөгжлийн сайд Иргэний нисэхийн ерөнхий газар Зам, тээврийн хөгжлийн яам | 148,016.0 144,921.0 190.0 |

| | | |
|-----------|--|------------------|
| | Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 1,004.3 |
| | Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,900.8 |
| 17 | Барилга, хот байгуулалтын сайд | 2,584.7 |
| | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар | 1,765.2 |
| | Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 819.4 |
| 18 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | 265,509.1 |
| | Ашигт малтмал, газрын тосны газар | 255,829.1 |
| | Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 1,352.3 |
| | Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 8,327.8 |
| 19 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | 161,278.3 |
| | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт | 52,000.0 |
| | Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 8,880.1 |
| | Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 100,398.2 |
| 20 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 77,664.1 |
| | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 600.0 |
| | Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого | 527.2 |
| | Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 11,078.9 |
| | Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 65,458.0 |
| 21 | Эрүүл мэндийн сайд | 224,322.2 |
| | Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого | 188,396.5 |
| | Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 11,253.3 |
| | Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 24,672.5 |
| 22 | Эрчим хүчний сайд | 3,065.9 |
| | Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 3,065.9 |

2/5 дугаар зүйл:

"5 дугаар зүйл. Монгол Улсын төсвөөс 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

| д/д | Төсвийн ерөнхийлөн захирагч | Дүн /сая төгрөгөөр/ |
|-----------|--|------------------------|
| 1 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга | 4,546.7 |
| | Урсгал зардал | 4,546.7 |
| 2 | Монгол Улсын Их Хурлын дарга | 33,928.4 |
| | Урсгал зардал | 29,522.6 |
| | Хөрөнгийн зардал | 1,688.0 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 2,717.8 |
| 3 | Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга | 1,585.4 |
| | Урсгал зардал | 1,585.4 |
| 4 | Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч | 4,051.9 |
| | Урсгал зардал | 4,051.9 |
| 5 | Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга | 46,295.1 |
| | Урсгал зардал | 46,295.1 |
| 6 | Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга | 791.8 |
| | Урсгал зардал | 791.8 |
| 7 | Улсын ерөнхий прокурор | 26,779.6 |
| | Урсгал зардал | 26,491.3 |
| | Хөрөнгийн зардал | 288.3 |
| 8 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга | 1,984.3 |
| | Урсгал зардал | 1,984.3 |
| 9 | Монгол Улсын Ерөнхий аудитор | 9,517.4 |
| | Урсгал зардал | 8,796.6 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 720.9 |
| 10 | Авлигатай тэмцэх газрын дарга | 10,351.2 |
| | Урсгал зардал | 9,394.0 |
| | Хөрөнгийн зардал | 851.4 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 105.8 |
| 11 | Санхүүгийн зохицуулах хорооны дарга | 2,514.7 |
| | Урсгал зардал | 2,514.7 |
| 12 | Төрийн албаны зөвлөлийн дарга | 725.8 |
| | Урсгал зардал | 725.8 |
| 13 | Үндэсний статистикийн хорооны дарга | 8,204.5 |
| | Урсгал зардал | 7,224.9 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 979.6 |
| 14 | Сонгуулийн ерөнхий хорооны дарга | 15,752.6 |
| | Урсгал зардал | 15,752.6 |
| 15 | Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга | 560.5 |
| | Урсгал зардал | 560.5 |
| 16 | Монгол Улсын Ерөнхий сайд | 306,770.3 |
| | Урсгал зардал | 85,188.1 |
| | Хөрөнгийн зардал | 221,582.2 |
| | Монгол Улсын Шадар сайд | 114,825.7 |

| | | |
|------------------|---|---------------------|
| 17 | Урсгал зардал | 91,867.7 |
| | Хөрөнгийн зардал | 19,526.4 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 3,431.7 |
| 18 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга | 24,032.5 |
| | Урсгал зардал | 12,300.4 |
| | Хөрөнгийн зардал | 5,763.3 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 5,968.8 |
| 19 | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | 68,080.2 |
| | Урсгал зардал | 43,851.1 |
| | Хөрөнгийн зардал | 10,132.7 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 14,096.4 |
| 20 | Гадаад харилцааны сайд | 65,192.1 |
| | Урсгал зардал | 62,896.8 |
| | Хөрөнгийн зардал | 1,518.2 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 777.1 |
| 21 | Сангийн сайд | 10,485,482.4 |
| | Урсгал зардал | 1,478,903.5 |
| | Дотоод эх үүсвэрээс олгох зээл | 143,529.4 |
| | Хөрөнгийн зардал | 14,639.7 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 96,351.4 |
| | Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт | 8,584,358.2 |
| | Засгийн газрын гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт | 167,700.3 |
| 22 | Хууль зүй, дотоод хэргийн сайд | 462,250.4 |
| | Урсгал зардал | 425,399.0 |
| | Хөрөнгийн зардал | 36,837.3 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 14.1 |
| 23 | Зам, тээврийн хөгжлийн сайд | 655,884.8 |
| | Урсгал зардал | 9,535.8 |
| | Хөрөнгийн зардал | 146,906.9 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 499,442.1 |
| 24 | Батлан хамгаалахын сайд | 246,839.2 |
| | Урсгал зардал | 222,011.2 |
| | Хөрөнгийн зардал | 24,828.0 |
| 25 | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд | 1,301,854.5 |
| | Урсгал зардал | 1,057,153.0 |
| | Үүнээс: Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг | 278,339.3 |
| | Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг | 592,008.5 |
| | Соёлын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг | 43,728.6 |
| | Нийтийн биеийн тамирын тусгай зориулалтын шилжүүлэг | 11,248.2 |
| | Дотоод эх үүсвэрээс олгох зээл | 63,114.7 |
| Хөрөнгийн зардал | 105,191.3 | |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 76,395.4 |
| 26 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | 27,425.7 |
| | Урсгал зардал | 9,889.3 |
| | Хөрөнгийн зардал | 16,184.1 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 1,352.3 |
| 27 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | 349,321.2 |
| | Урсгал зардал | 99,889.9 |
| | Дотоод эх үүсвэрээс олгох зээл | 185,659.0 |
| | Хөрөнгийн зардал | 49,384.6 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 14,387.7 |
| 28 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 1,145,082.3 |
| | Урсгал зардал | 1,096,816.6 |
| | Үүнээс: Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг | 6,166.9 |
| | Хөрөнгийн зардал | 7,810.8 |
| | Дотоод эх үүсвэрээс олгох зээл | 20,000.0 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 20,455.0 |
| 29 | Эрүүл мэндийн сайд | 686,643.9 |
| | Урсгал зардал | 585,489.4 |
| | Үүнээс: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг | 107,659.0 |
| | Хөрөнгийн зардал | 61,740.8 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 39,413.7 |
| 30 | Эрчим хүчний сайд | 239,360.4 |
| | Урсгал зардал | 19,855.1 |
| | Хөрөнгийн зардал | 115,215.6 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 104,289.8 |
| 31 | Барилга, хот байгуулалтын сайд | 116,871.6 |
| | Урсгал зардал | 12,020.0 |
| | Үүнээс: Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг | 7,171.8 |
| | Хөрөнгийн зардал | 80,372.5 |
| | Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал | 24,479.1 |

16 дугаар зүйл.Монгол Улсын 2017 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг доор дурдсанаар баталсугай:

| д/д | Аймаг | Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/ |
|-----------------|------------|--|
| 1 | Архангай | 12,501.8 |
| 2 | Баян-Өлгий | 11,934.4 |
| 3 | Баянхонгор | 12,027.3 |
| 4 | Говь-Алтай | 8,877.5 |
| 5 | Дорнод | 3,009.4 |
| 6 | Дундговь | 6,138.1 |
| 7 | Завхан | 10,369.2 |
| 8 | Өвөрхангай | 12,214.7 |
| 9 | Сүхбаатар | 5,658.7 |
| 10 | Сэлэнгэ | 3,612.9 |
| 11 | Төв | 8,529.4 |
| 12 | Увс | 12,148.2 |
| 13 | Ховд | 8,517.2 |
| 14 | Хөвсгөл | 18,341.5 |
| 15 | Хэнтий | 9,097.0 |
| Нийт дүн | | 142,977.3 |

17 дугаар зүйл.2017 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

| д/д | Аймаг | Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/ |
|-----------------|-------------|--|
| 1 | Булган | 367.8 |
| 2 | Дорноговь | 889.4 |
| 3 | Өмнөговь | 29,493.3 |
| 4 | Дархан-Уул | 328.5 |
| 5 | Улаанбаатар | 153,089.7 |
| 6 | Орхон | 13,632.3 |
| 7 | Говьсүмбэр | 176.9 |
| Нийт дүн | | 197,977.9 |

2 дугаар зүйл.Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралтаар өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл.Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар баталсан "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 2 дугаар хавсралтаар өөрчлөн найруулсугай.

4 дүгээр зүйл.Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "4,276,367.5" гэснийг

| | |
|---------------|---|
| " 4,729,627.7 | " гэж, 6 дугаар зүйлийн "6,959,661.7" гэснийг |
| " 7,517,421.0 | " гэж, 7 дугаар зүйлийн "492,850.8" гэснийг |
| " 644,315.7 | " гэж, 8 дугаар зүйлийн "70,933.7" гэснийг |
| " 210,299.8 | " гэж, 10 дугаар зүйлийн "208,800.7" гэснийг |
| " 242,417.9 | " гэж, 11 дүгээр зүйлийн "266,808.4" гэснийг |
| " 333,345.1 | " гэж, 13 дугаар зүйлийн "106,808.4" гэснийг |
| " 173,345.1 | " гэж тус тус өөрчилсүгэй. |

Гарын үсэг

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ,
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

/сая төгрөг/

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|----------------|---|---------|--------|-----------------|-----------------|
| | | Эхлэх | Дуусах | | |
| I | МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА | | | 1,688.0 | 1,688.0 |
| I.3 | III.Тоног төхөөрөмж | | | 1,688.0 | 1,688.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>1,688.0</i> | <i>1,688.0</i> |
| I.3.1 | Улсын их хурлын техник, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 2017 | 2017 | 1,688.0 | 1,688.0 |
| II | МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД | | | 8,273.3 | 2,951.3 |
| II.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 8,273.3 | 2,951.3 |
| | <i>Шилжих</i> | | | <i>8,273.3</i> | <i>2,951.3</i> |
| II.1.1 | Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжид хуримтлагдсан лагийг боловсруулах дамжлага нэмэх, ашиглалтад оруулах /Улаанбаатар/ | 2016 | 2017 | 8,100.0 | 2,778.0 |
| II.1.2 | Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шат /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 2017 | 2017 | 173.3 | 173.3 |
| III | МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД | | | 45,243.4 | 7,055.1 |
| III.1 | Онцгой байдлын ерөнхий газар | | | 36,706.9 | 6,435.0 |
| III.1.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 35,906.9 | 5,635.0 |
| | <i>Шилжих</i> | | | <i>35,906.9</i> | <i>5,635.0</i> |
| III.1.1.1 | Аврах гал унтраах ангийн барилга /Улаанбаатар, Багахангай дүүрэг/ | 2014 | 2018 | 1,250.0 | 383.6 |
| III.1.1.2 | Аврах гал унтраах ангийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ | 2013 | 2017 | 3,262.5 | 1,762.8 |
| III.1.1.3 | Аврах гал унтраах ангийн барилга /Дархан-Уул, Дархан сум/ | 2013 | 2017 | 3,302.5 | 630.1 |
| III.1.1.4 | Аврах гал унтраах ангийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/ | 2013 | 2017 | 3,302.5 | 1,042.8 |
| III.1.1.5 | Аврах гал унтраах ангийн барилга /Төв, Зуунмод сум/ | 2013 | 2017 | 2,700.0 | 1,096.8 |
| III.1.1.6 | Аврах гал унтраах ангийн барилга /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ | 2013 | 2017 | 2,089.4 | 685.2 |
| III.1.1.7 | Онцгой байдлын албаны командын байрын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 2015 | 2017 | 20,000.0 | 33.7 |
| III.1.3 | III.Тоног төхөөрөмж | | | 800.0 | 800.0 |
| | <i>Шилжих</i> | | | <i>800.0</i> | <i>800.0</i> |
| III.1.3.1 | Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн өргөтгөлийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 2016 | 2017 | 800.0 | 800.0 |
| III.2 | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | | | 1,316.5 | 495.2 |
| III.2.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 1,316.5 | 495.2 |
| | <i>Шилжих</i> | | | <i>1,316.5</i> | <i>495.2</i> |
| III.2.1.1 | Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум/ | 2012 | 2018 | 1,316.5 | 495.2 |
| III.3 | Алтанбулаг чөлөөт бүс | | | 7,220.0 | 124.9 |
| III.3.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 7,220.0 | 124.9 |
| | <i>Шилжих</i> | | | <i>7,220.0</i> | <i>124.9</i> |
| III.3.1.1 | Алтанбулаг чөлөөт бүсийн Сүхбаатар-Сэлэнгийн 25 км бохир усны шугам хоолойн ажил /Сэлэнгэ, Алтанбулаг сум/ | 2012 | 2017 | 7,220.0 | 124.9 |
| IV | ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА | | | 17,253.7 | 5,763.3 |
| IV.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 11,648.3 | 1,219.6 |
| | <i>Шилжих</i> | | | <i>11,648.3</i> | <i>1,219.6</i> |
| IV.1.1 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга /Дорнод, Хэрлэн сум/ | 2011 | 2018 | 6,541.0 | 932.5 |
| IV.1.2 | Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Булган сум/ | 2011 | 2017 | 4,137.5 | 153.9 |
| IV.1.3 | Сумын Засаг даргын Тамгын газрын барилга /Архангай, Хашаат сум/ | 2013 | 2017 | 969.8 | 133.2 |
| IV.2 | II.Их засвар | | | 3,700.0 | 2,638.3 |
| | <i>Шилжих</i> | | | <i>3,700.0</i> | <i>2,638.3</i> |
| IV.2.1 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын тоног төхөөрөмж ажлын үлдэгдэл, аймаг, сумдад хийгдэх их засвар /Улсын хэмжээнд/ | 2016 | 2017 | 135.0 | 135.0 |
| IV.2.2 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын тоног төхөөрөмж ажлын үлдэгдэл, Төрийн ордны тохижилт, их засварын ажил /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 2016 | 2017 | 3,565.0 | 2,503.3 |
| IV.3 | III.Тоног төхөөрөмж | | | 1,905.4 | 1,905.4 |
| | <i>Шинэ</i> | | | <i>1,905.4</i> | <i>1,905.4</i> |
| IV.3.1 | Засгийн газрын авто баазын парк шинэчлэлт /Улсын хэмжээнд/ | 2017 | 2017 | 1,905.4 | 1,905.4 |
| V | БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД | | | 2,593.5 | 824.3 |
| V.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 2,593.5 | 824.3 |
| | <i>Шилжих</i> | | | <i>2,593.5</i> | <i>824.3</i> |
| V.1.1 | Ойн ангийн конторын барилга /Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа, аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар/ | 2012 | 2017 | 725.8 | 196.8 |
| V.1.2 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын конторын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/ | 2012 | 2017 | 867.7 | 410.9 |
| V.1.3 | Хот суурин газрын ус хангамж, гидрогеологийн зураглалын судалгаа /Өвөрхангай, Гучин-Ус сум/ | 2015 | 2017 | 1,000.0 | 216.6 |
| VI | ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД | | | 5,978.2 | 1,518.2 |
| VI.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 5,160.0 | 700.0 |
| | <i>Шилжих</i> | | | <i>5,160.0</i> | <i>700.0</i> |
| VI.1.1 | Гадаад харилцааны яамны Ёслол хүндэтгэлийн өргөөний шинэчлэл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | 2013 | 2017 | 5,160.0 | 700.0 |
| VI.3 | III.Тоног төхөөрөмж | | | 818.2 | 818.2 |
| | <i>Шинэ</i> | | | <i>818.2</i> | <i>818.2</i> |
| VI.3.1 | Гадаад харилцааны яамны Ёслол хүндэтгэлийн өргөөний тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | 2017 | 2017 | 818.2 | 818.2 |
| VII | САНГИЙН САЙД | | | 68,377.8 | 14,639.7 |
| VII.1 | Сангийн яам | | | 57,047.8 | 6,429.7 |

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|-----------------|---|---------|--------|-----------------|-----------------|
| | | Эхлэх | Дуусах | | |
| VII.1.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 35,047.8 | 429.7 |
| | <i>Шилжих</i> | | | <i>35,047.8</i> | <i>429.7</i> |
| VII.1.1.1 | Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/ | 2013 | 2018 | 7,991.1 | 48.5 |
| VII.1.1.2 | Монгол Улсын хэмжээнд 2014-2017 оны хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил, зураг төсөл, хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/ | 2014 | 2017 | 27,056.7 | 381.2 |
| VII.1.4 | IV.Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв | | | 22,000.0 | 6,000.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>22,000.0</i> | <i>6,000.0</i> |
| VII.1.4.1 | Монгол Улсын хэмжээнд 2018-2020 онуудад хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил, зураг төсөл /Улсын хэмжээнд/ | 2017 | 2019 | 22,000.0 | 6,000.0 |
| VII.2 | Гаалийн ерөнхий газар | | | 1,400.0 | 1,400.0 |
| VII.2.3 | III.Тоног төхөөрөмж | | | 1,400.0 | 1,400.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>1,400.0</i> | <i>1,400.0</i> |
| VII.2.3.1 | Гаалийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ | 2017 | 2017 | 1,400.0 | 1,400.0 |
| VII.3 | Татварын ерөнхий газар | | | 1,500.0 | 1,500.0 |
| VII.3.3 | III.Тоног төхөөрөмж | | | 1,500.0 | 1,500.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>1,500.0</i> | <i>1,500.0</i> |
| VII.3.3.1 | Татварын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ | 2017 | 2017 | 1,500.0 | 1,500.0 |
| VII.4 | Монголын үндэсний олон нийтийн радио телевиз | | | 8,430.0 | 5,310.0 |
| VII.4.2 | II.Их засвар | | | 336.0 | 336.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>336.0</i> | <i>336.0</i> |
| VII.4.2.1 | Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 2017 | 2017 | 336.0 | 336.0 |
| VII.4.3 | III.Тоног төхөөрөмж | | | 8,094.0 | 4,974.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>8,094.0</i> | <i>4,974.0</i> |
| VII.4.3.1 | Монголын Үндэсний олон нийтийн радио телевизийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 2017 | 2017 | 8,094.0 | 4,974.0 |
| VIII | ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД | | | 78,333.1 | 36,837.3 |
| VIII.1 | Цагдаагийн ерөнхий газар | | | 7,366.7 | 5,487.9 |
| VIII.1.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 3,316.4 | 1,437.6 |
| | <i>Шилжих</i> | | | <i>3,316.4</i> | <i>1,437.6</i> |
| VIII.1.1.1 | Цагдаагийн хэлтсийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/ | 2016 | 2017 | 1,685.8 | 1,435.8 |
| VIII.1.1.2 | Орон нутгийн сумдын цагдаагийн байр, кобан /Улсын хэмжээнд/ | 2016 | 2017 | 1,630.6 | 1.8 |
| VIII.1.2 | II.Их засвар | | | 650.3 | 650.3 |
| | <i>Шинэ</i> | | | <i>650.3</i> | <i>650.3</i> |
| VIII.1.2.1 | Цагдаагийн хэлтсийн зарим өрөөг мэдүүлэг авах өрөө болгон засварлах /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | 2017 | 2017 | 650.3 | 650.3 |
| VIII.1.3 | III.Тоног төхөөрөмж | | | 3,400.0 | 3,400.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>3,400.0</i> | <i>3,400.0</i> |
| VIII.1.3.1 | Цагдаагийн ерөнхий газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | 2017 | 2017 | 3,400.0 | 3,400.0 |
| VIII.2 | Хил хамгаалах ерөнхий газар | | | 11,069.3 | 8,969.3 |
| VIII.2.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 11,069.3 | 8,969.3 |
| | <i>Шилжих</i> | | | <i>10,709.3</i> | <i>8,609.3</i> |
| VIII.2.1.1 | Хилийн 0168 дугаар ангийн нүүлгэн шилжүүлэлт, инженерийн байгууламжийн дуусгал /Дорноговь, Хатанбулаг сум/ | 2016 | 2017 | 10,709.3 | 8,609.3 |
| | <i>Шинэ</i> | | | <i>360.0</i> | <i>360.0</i> |
| VIII.2.1.2 | Гашуунсухайт боомтын шалгалтын кабин барих, тоног төхөөрөмжийн хамт /Өмнөговь, Ханбогд сум/ | 2017 | 2017 | 360.0 | 360.0 |
| VIII.3 | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | | | 3,500.0 | 3,500.0 |
| VIII.3.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 3,500.0 | 3,500.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>3,500.0</i> | <i>3,500.0</i> |
| VIII.3.1.1 | Үндэсний ой санамж хөтөлбөр /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 2017 | 2017 | 3,500.0 | 3,500.0 |
| VIII.4 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | | | 37,074.1 | 12,157.1 |
| VIII.4.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 37,074.1 | 12,157.1 |
| | <i>Шилжих</i> | | | <i>37,074.1</i> | <i>12,157.1</i> |
| VIII.4.1.1 | Нэгдсэн хорих анги, инженерийн байгууламж, 1500 хүн /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 2013 | 2017 | 37,074.1 | 12,157.1 |
| VIII.5 | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг | | | 19,323.0 | 6,723.0 |
| VIII.5.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 17,701.0 | 5,101.0 |
| | <i>Шилжих</i> | | | <i>17,701.0</i> | <i>5,101.0</i> |
| VIII.5.1.1 | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн барилга, инженерийн байгууламж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | 2010 | 2017 | 17,701.0 | 5,101.0 |
| VIII.5.3 | III.Тоног төхөөрөмж | | | 1,622.0 | 1,622.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>1,622.0</i> | <i>1,622.0</i> |
| VIII.5.3.1 | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | 2017 | 2017 | 1,622.0 | 1,622.0 |
| IX | ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЫН САЙД | | | 25,720.7 | 7,810.8 |
| IX.1 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэл | | | 10,026.3 | 2,454.6 |
| IX.1.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 10,026.3 | 2,454.6 |
| | <i>Шилжих</i> | | | <i>10,026.3</i> | <i>2,454.6</i> |
| IX.1.1.1 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр /Дорнод, Хэрлэн сум/ | 2013 | 2017 | 5,102.4 | 953.4 |
| IX.1.1.2 | Монгол-Солонгосын политехник коллежийн гадна шугам сүлжээний ажлын үлдэгдэл /Улаанбаатар, Хан-Уул/ | 2015 | 2017 | 1,400.0 | 45.7 |
| IX.1.1.3 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байр /Орхон, Баян-Өндөр сум/ | 2013 | 2017 | 3,473.9 | 1,435.9 |
| IX.1.1.4 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга /Төгсөгчдийг ажлын байраар хангах бичил нийтийн ахуйн үйлчилгээний төв/ /Баянхонгор, Баянхонгор сум/ | 2013 | 2017 | 50.0 | 19.6 |
| IX.2 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | | | 10,859.3 | 2,561.5 |
| IX.2.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 10,859.3 | 2,561.5 |
| | <i>Шилжих</i> | | | <i>10,859.3</i> | <i>2,561.5</i> |

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|----------------|---|---------|--------|------------------|-----------------|
| | | Эхлэх | Дуусах | | |
| IX.2.1.1 | Усан спорт цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ | 2014 | 2019 | 9,600.0 | 2,500.0 |
| IX.2.1.2 | Ахмадын ордны барилга /Завхан, Улиастай сум/ | 2015 | 2017 | 1,259.3 | 61.5 |
| IX.3 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | | | 2,288.0 | 2,288.0 |
| IX.3.2 | II.Их засвар | | | 2,000.0 | 2,000.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>2,000.0</i> | <i>2,000.0</i> |
| IX.3.2.1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их засвар /Улсын хэмжээнд/ | 2017 | 2017 | 2,000.0 | 2,000.0 |
| IX.3.3 | III.Тоног төхөөрөмж | | | 288.0 | 288.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>288.0</i> | <i>288.0</i> |
| IX.3.3.1 | Япон улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн тоног төхөөрөмж /Япон улс/ | 2017 | 2017 | 288.0 | 288.0 |
| IX.4 | Нийгмийн даатгал | | | 2,547.1 | 506.7 |
| IX.4.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 2,520.4 | 480.0 |
| | <i>Шилжих</i> | | | <i>2,520.4</i> | <i>480.0</i> |
| IX.4.1.1 | Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 2016 | 2017 | 1,700.0 | 300.0 |
| IX.4.1.2 | Нийгмийн даатгалын тасгийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | 2016 | 2017 | 820.4 | 180.0 |
| IX.4.4 | IV.Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв | | | 26.7 | 26.7 |
| IX.4.4.1 | Нийгмийн даатгалын байгууллагуудын барилга, байгууламжийн зураг төсөл /Улсын хэмжээнд/ | 2016 | 2017 | 26.7 | 26.7 |
| X | БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД | | | 69,910.5 | 24,828.0 |
| X.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 69,910.5 | 24,828.0 |
| | <i>Шилжих</i> | | | <i>49,979.4</i> | <i>4,896.9</i> |
| X.1.1 | Энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх /Улаанбаатар, Налайх дүүрэг/ | 2012 | 2018 | 16,582.9 | 2,000.0 |
| X.1.2 | Говийн бүсийн сургалтын төв /Өмнөговь, Даланзадгад сум/ | 2013 | 2017 | 7,500.0 | 667.4 |
| X.1.3 | Батлан хамгаалах их сургуулийн Биений тамирын цогцолборын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 2013 | 2017 | 6,213.9 | 25.7 |
| X.1.4 | Цэргийн эмнэлгийн төв цогцолбор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 2011 | 2017 | 19,682.6 | 2,203.8 |
| | <i>Шинэ</i> | | | <i>19,931.1</i> | <i>19,931.1</i> |
| X.1.5 | Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх/ | 2017 | 2017 | 19,931.1 | 19,931.1 |
| XI | БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД | | | 481,757.8 | 80,372.5 |
| XI.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 481,757.8 | 80,372.5 |
| | <i>Шилжих</i> | | | <i>479,157.8</i> | <i>77,972.5</i> |
| XI.1.1 | Улаанбаатар хотын бүсчлэлийн төлөвлөлт, инженер-геологийн судалгаа, газар хөдлөлийн мужлалын газар дээрх болон доорх зураглал хийж, мэдээллийн сан үүсгэх /Улаанбаатар/ | 2012 | 2017 | 8,957.3 | 1,099.7 |
| XI.1.2 | Аймаг, сум, суурин газрын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил /аймаг дундын/ | 2012 | 2017 | 2,997.7 | 495.5 |
| XI.1.3 | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Орон сууцны хороолол төслийн монголын талын хөрөнгө /Улаанбаатар/ | 2010 | 2017 | 25,094.5 | 306.0 |
| XI.1.4 | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн монголын талын хөрөнгө /Дорноговь, Замын-Үүд сум/ | 2011 | 2017 | 11,660.0 | 631.0 |
| XI.1.5 | Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн монголын талын хөрөнгө /Орхон, Баян-Өндөр сум/ | 2013 | 2017 | 9,224.8 | 345.7 |
| XI.1.6 | Хаягийн мэдээллийн систем байгуулах /Улсын хэмжээнд/ | 2013 | 2017 | 3,000.0 | 1,389.7 |
| XI.1.7 | Нийслэл, аймгийн төв, улсын чанартай авто замын дагуух Монгол Улсын иргэнд өмчлүүлэх боломжтой газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байр зүйн зураглал, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах /Улсын хэмжээнд/ | 2013 | 2017 | 4,780.0 | 1,208.1 |
| XI.1.8 | Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох /Архангай, Эрдэнэбулган сум/ | 2013 | 2017 | 3,970.0 | 178.9 |
| XI.1.9 | Газрын кадастрын мэдээллийн санг геодезийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх /Улсын хэмжээнд/ | 2013 | 2017 | 9,000.0 | 2,513.8 |
| XI.1.10 | Бүгд Найрамдах Чех Улсын хөрөнгө оруулалтаар эргэн төлөгдөх нөхцөлөөр хэрэгжих Евро Эко Төгөл төсөл /Орхон/ | 2013 | 2017 | 8,926.2 | 3,168.7 |
| XI.1.11 | Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголын дагуу бүсчлэл, инженер геологи, газар хөдлөлийн мужлалын нарийвчилсан зураг төсөл боловсруулах /Улаанбаатар/ | 2013 | 2017 | 1,000.0 | 103.4 |
| XI.1.12 | Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудыг түшиглэн хөгжих хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах /Улсын хэмжээнд/ | 2012 | 2017 | 1,210.0 | 121.0 |
| XI.1.13 | Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургуулийн барилга, 960 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/ | 2013 | 2017 | 4,122.7 | 544.8 |
| XI.1.14 | Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Өндөрхангай, Зүүнхангай, Тэс, Бөхмөрөн, Хяргас, Ховд, Малчин, Завхан, Баруунтуруун, Цагаанхайрхан сум/ | 2014 | 2017 | 2,000.0 | 60.0 |
| XI.1.15 | Үерээс хамгаалах далан, сувгийн байгууламж /Өвөрхангай, Хархорин сум/ | 2013 | 2017 | 2,800.0 | 534.0 |
| XI.1.16 | Шинээр барилгын материалын лаборатори байгуулах /Өмнөговь/ | 2013 | 2017 | 999.0 | 353.2 |
| XI.1.17 | Өндрийн сүлжээний давтан хэмжилт, 1 дүгээр ангийн нивелирдлэг хийх /Улсын хэмжээнд/ | 2013 | 2017 | 1,100.0 | 990.0 |
| XVII.1.18 | Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын дулааны 2 Ø 300/400 мм-ийн голчтой 1.1 км шугам, 1 ширхэг ус, дулаан дамжуулах төв, Ø 150 мм-ийн голчтой 137 метр шугам, бие даасан 9.3 Гкал чадалтай дулааны эх үүсвэр, гадна төв бохир усны Ø 500 мм-ийн 1235 метр шугам, бохир усны Ø 200-300 мм-ийн 1788 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ | 2014 | 2017 | 9,854.0 | 987.3 |
| XVII.1.19 | Шар хад, Амгалан орчмын бохир ус татан зайлуулах, ариутгах татуургын шугам сүлжээний ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 2014 | 2017 | 2,224.0 | 343.4 |
| XVII.1.20 | 220 кВ-ын Улаанбаатар дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станц хүртэлх 110 кВ-ын 9.7 км 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил | 2014 | 2017 | 938.4 | 311.9 |
| XVII.1.21 | 110 кВ-ын Баянгол дэд станцаас 110 кВ-ын Радио телевиз дэд станц хүртэлх 110 кВ-ын 24 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 2014 | 2017 | 814.9 | 394.1 |
| XVII.1.22 | 220 кВ-ын Сонгино дэд станцаас 110 кВ-ын Зайсан дэд станц хүртэлх 110 кВ-ын 50 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил | 2014 | 2017 | 2,139.7 | 583.9 |
| XVII.1.23 | 110/35/10 кВ-ын 2*40 МВА дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станцын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам хүртэлх 110 кВ-ын 2 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил | 2014 | 2017 | 2,100.0 | 753.1 |
| XVII.1.24 | Сонгино 220/110/35 кВ-ын 2х125 МВА дэд станц, 220 кВ-ын 10 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Улаанбаатар/ | 2014 | 2017 | 4,698.0 | 1,182.7 |
| XVII.1.25 | Баянголын амны Баянгол хорооллын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 2.2 км, дэд станц, 110/35/10 кВ, 2х40 МВА /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 2014 | 2017 | 2,291.0 | 1,067.5 |
| XVII.1.26 | Баянголын амны 4 дүгээр ээлжийн дулааны ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ | 2013 | 2017 | 2,925.8 | 126.7 |
| XVII.1.27 | Мардай-Чулуунхороот сумын 35 кВ-ын 160 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорнод/ | 2012 | 2017 | 4,397.4 | 346.5 |
| XVII.1.28 | Холбооны 2 яндантай 2100 метр сувагчлалын зураг төсөл, барилга угсралтын ажил | 2015 | 2017 | 252.0 | 59.0 |
| XVII.1.29 | Амгалан дулааны станцын ахуйн хэрэгцээний цэвэр усан хангамжийн угсралтын ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 2014 | 2017 | 228.0 | 9.9 |
| XVII.1.30 | БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төслийн монголын талын хөрөнгө /Орхон, Баян-Өндөр сум/ | 2017 | 2019 | 6,568.3 | 1,970.5 |
| XVII.1.31 | БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Улаанбаатар-Мандалговь чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийн монголын талын хөрөнгө /аймаг дундын/ | 2016 | 2019 | 15,089.2 | 4,526.8 |
| XVII.1.32 | Буман нарны гэрэл үндэсний хөтөлбөрийн хүрээнд нарны цахилгаан үүсгүүр нийлүүлэх ажлын үлдэгдэл санхүүжилт /Улсын хэмжээнд/ | 2007 | 2017 | 878.3 | 878.3 |
| | <i>Шинэ</i> | | | <i>39,500.0</i> | <i>39,500.0</i> |
| XVII.1.33 | Нийслэлийн гэр хорооллын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгө буюу 20.000 айл өрхийг 4.0 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх ажил | 2017 | 2018 | 39,500.0 | 39,500.0 |
| | <i>Дулааны цахилгаан станц, дулааны шугам, сүлжээ</i> | | | <i>36,385.6</i> | <i>29,406.1</i> |
| | <i>Шинэ</i> | | | <i>36,385.6</i> | <i>29,406.1</i> |
| XVII.1.34 | Нийслэлд одоо ажиллаж байгаа 68 ширхэг халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчдийг дулааны төвлөрсөн системд холбох | 2017 | 2018 | 22,900.0 | 18,920.5 |
| XVII.1.35 | Зарим аймгийн төвийн дулааны станцын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах | 2017 | 2017 | 3,547.5 | 3,547.5 |
| XVII.1.36 | "Дулаан-Шарын гол" ТӨХК-ийн Дулааны станцаас дулаан хуваарилах төв хүртэлх гадна дулааны 2.2 км төв шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажил /Дархан-Уул, Шарын гол сум/ | 2017 | 2017 | 3,898.1 | 3,898.1 |
| XVII.1.37 | "Эрдэнэтийн ДЦС"-ын үнсэн сан №2-ын үнсийг зөөж хоослох, даланг өндөрлөх ажил /Орхон, Баян-Өндөр сум/ | 2017 | 2018 | 6,040.0 | 3,040.0 |
| | <i>Гадаадын зээлээр хэрэгжих төслийн дотоод эх үүсвэр</i> | | | <i>10,600.0</i> | <i>3,450.0</i> |
| | <i>Шилжих</i> | | | <i>10,600.0</i> | <i>3,450.0</i> |
| XVII.1.38 | Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжих Дарханы дулааны цахилгаан станцын техникийн шинэчлэлийн монголын талын хөрөнгө /Дархан-Уул, Дархан сум/ | 2015 | 2017 | 10,600.0 | 3,450.0 |
| XVII.2 | II. Их засвар | | | 6,300.0 | 5,553.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>6,300.0</i> | <i>5,553.0</i> |

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|----------------|--|---------|--------|--------------------|------------------|
| | | Эхлэх | Дуусах | | |
| XVII.2.1 | Эрчим хүчний дулааны төв магистраль шугамын шинэчлэлт, их засвар, өргөтгөл /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | 2017 | 2017 | 6,300.0 | 5,553.0 |
| XVIII | АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР | | | 1,031.4 | 851.4 |
| XVIII.2 | II.Их засвар | | | 1,031.4 | 851.4 |
| | <i>Шилжих</i> | | | <i>1,031.4</i> | <i>851.4</i> |
| XVIII.2.1 | Авлигатай тэмцэх газрын "В" байрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 2016 | 2017 | 1,031.4 | 851.4 |
| XIX | УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР | | | 1,152.7 | 288.3 |
| XIX.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 952.7 | 88.3 |
| | <i>Шилжих</i> | | | <i>952.7</i> | <i>88.3</i> |
| XIX.1.1 | Улсын ерөнхий прокурорын газрын архивын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ | 2012 | 2017 | 952.7 | 88.3 |
| XIX.2 | II.Их засвар | | | 200.0 | 200.0 |
| | <i>Шинэ</i> | | | <i>200.0</i> | <i>200.0</i> |
| XIX.2.1 | Прокурорын газрын барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 2017 | 2017 | 200.0 | 200.0 |
| | НИЙТ | | | 2,570,348.3 | 644,315.7 |

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ “БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ” КОНЦЕССЫН ТӨРЛӨӨР
ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ЖАГСААЛТ**

/сая төгрөг/

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|----------------|--|---------|--------|------------------|------------------|
| | | Эхлэх | Дуусах | | |
| I | МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД | | | 478,889.8 | 210,299.8 |
| I.1 | Үндэсний хөгжлийн газар | | | 478,889.8 | 210,299.8 |
| | Концессын төслийн эргэн төлөлт | | | 478,889.8 | 210,299.8 |
| I.1.1 | I.Хөрөнгө оруулалт | | | 478,889.8 | 210,299.8 |
| | <i>Шилжих</i> | | | 447,386.1 | 196,765.9 |
| I.1.1.1 | Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам | 2015 | 2019 | 117,042.0 | 52,304.7 |
| I.1.1.2 | Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам | 2015 | 2019 | 176,405.4 | 78,825.3 |
| I.1.1.3 | Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумаас Улаанбаатар чиглэлийн олон улсын авто замын Дулаанхааны дөрвөн замын уулзвар хүртэл 95 км даацын хатуу хучилттай авто зам барих төсөл | 2016 | 2018 | 95,272.2 | 21,337.4 |
| I.1.1.4 | Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр сургууль/ | 2016 | 2017 | 10,787.0 | 10,787.0 |
| I.1.1.5 | Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 38 дугаар сургууль/ | 2015 | 2018 | 14,884.5 | 5,581.7 |
| I.1.1.6 | Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 73 дугаар сургууль/ | 2015 | 2018 | 10,736.3 | 7,515.4 |
| I.1.1.7 | Сургуулийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 32 дугаар сургууль/ | 2016 | 2017 | 5,800.0 | 5,800.0 |
| I.1.1.8 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор/ | 2016 | 2017 | 1,386.6 | 797.3 |
| I.1.1.9 | Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Жаргалант сум/ | 2016 | 2017 | 2,050.3 | 2,050.3 |
| I.1.1.10 | Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/ | 2016 | 2018 | 2,357.9 | 1,687.9 |
| I.1.1.11 | Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь гүүрийн барилгын ажил | 2016 | 2018 | 1,949.9 | 1,365.0 |
| I.1.1.12 | Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто замын ажил | 2015 | 2017 | 6,952.0 | 6,952.0 |
| I.1.1.13 | Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3,4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 авто машины зогсоол барих | 2016 | 2017 | 1,762.0 | 1,762.0 |
| | <i>Шинэ</i> | | | 31,503.7 | 13,533.8 |
| I.1.1.14 | Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22,2 км хатуу хучилттай авто зам | 2017 | 2019 | 26,640.0 | 9,057.6 |
| I.1.1.15 | Хөвсгөл аймгийн Галт сумын Идэрийн голын хөвдөг гүүрний барилгын ажил төсөл | 2017 | 2018 | 787.5 | 400.0 |
| I.1.1.16 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 6 дүгээр цэцэрлэг/ | 2017 | 2017 | 1,154.0 | 1,154.0 |
| I.1.1.17 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, Баян-Ойт 1 дүгээр цэцэрлэг/ | 2017 | 2017 | 1,154.0 | 1,154.0 |
| I.1.1.18 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Баянхонгор, Богд сум | 2017 | 2017 | 738.2 | 738.2 |
| I.1.1.19 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/ | 2017 | 2017 | 1,029.9 | 1,029.9 |
| | НИЙТ ДҮН | | | 478,889.8 | 210,299.8 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот

2017 он

1. ТӨСӨВТ ТОДОТГОЛ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

ОУВС болон Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн эхний шатны үнэлгээг 2017 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс 8 дугаар сарын 2-ны өдрийн хооронд ажлын хэсгийн түвшинд хийсэн. ОУВС-ийн ажлын хэсгийн зүгээс хөтөлбөр сайн хэрэгжиж, бүх тоон зорилтууд хангагдсан болохыг мэдэгдсэн.

Эдийн засгийн өсөлт эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрэн сэргэж байна. Нүүрсний экспорт эрчимтэй нэмэгдэж, голлох ашигт малтмалын үнэ харьцангуй өндөр түвшинд хүрсэн нь уул уурхайн салбар, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарт өсөлт бий болж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт нэмэгдсэн зэрэг нь 2017 онд төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давж биелэхэд нөлөөлсөн байна.

Эдийн засгийн өсөлт, төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулан ОУВС-ын хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний явцад тохирсон зарим арга хэмжээг хэрэгжүүлэх болон төсөв зайлшгүй тодотгол хийх дараах үндэслэл шаардлага байна. Үүнд:

1. Төсвийн давсан орлогоос 500 тэрбум хүртэл төгрөгийг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх чиглэлийн арга хэмжээ, түүний дотор сургууль, эмнэлэг, аймаг орон нутгийн засаг захиргааны барилгад засвар хийх, төлөгдөх ёстой өр төлбөрийг барагдуулах зэрэгт зарцуулахаар ОУВС-ын хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний явцад тохирсон болно. Энэ хүрээнд жижиг дунд үйлдвэрийг дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх, төв суурин газрын болон хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг хангах, байгалийн аюулт үзэгдэл, мал амьтны гоц халдварт өвчний улмаас учирсан хохирлыг барагдуулах, орон нутгийн болон улсын төсөвт хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, шүүхийн шийдвэрийн дагуу иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад олгох төлбөрийг барагдуулах зэрэг цаг үеийн тулгамдсан арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна. Эдгээр нь нэг удаагийн шинжтэй арга хэмжээ байх бөгөөд дараагийн төсвийн жилд зардлын нөлөөлөл үзүүлэхгүй юм.

2. Мөн давсан орлогын тодорхой хэсгийг хуримтлуулах, хуримтлалыг богино хугацаатай зээллэгийг бууруулах, өндөр өртөгтэй өрийг буцаан худалдан авах, мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэхэд ашиглахаар ОУВС-тай урьдчилан тохиролцсоны дагуу төсөвт тодотгол хийх шаардлага үүсэж байна.

3. Монгол Улсын 2017 оны төсөв батлагдсанаас хойш хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2017 онд бүх хүүхдэд олгох талаар гарсан Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 201 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусгах шаардлагатай болсон бөгөөд энэ талаар ОУВС-тай мөн тохирсон болно. Үүнтэй уялдуулан нийгмийн эмзэг ядуу өрхүүдэд олгох хүнс тэжээлийн хөтөлбөрт шаардагдах хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага үүсээд байна.

4. Өсөн нэмэгдэж байгаа боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд нийцүүлж шаардагдах зардлыг тооцож төсөвт тусгах шаардлагатай байна.

5. Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангах зарчимд нийцүүлэн төсвийн 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл, салбарын яамдаас бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг харгалзан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын батлагдсан төсөвт зарим зохицуулалтын шинжтэй өөрчлөлтийг төсвийн тодотголд тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

6. Өмнөх жилүүдэд гэрээ нь хийгдсэн “Барих-Шилжүүлэх” концессын төслийн эргэн төлөлт, хөнгөлөлттэй зээлийн Монголын талын хариуцах санхүүжилт болон шүүхийн шийдвэртэй болон бусад өр төлбөрүүдийг барагдуулах зайлшгүй шаардлага үүсэж байна.

7. Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу холбогдох өөрчлөлтүүдийг төсөвт тусгаснаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ДНБ-ийн 0.5 хувиар сайжирч ДНБ-ий -9.9 хувь болж сайжрахаар байна.

2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ


2.1. Макро эдийн засгийн 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Эдийн засагт үүссэн хүндрэлүүдийг арилгах, төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг үе шаттайгаар бууруулах замаар эдийн засгийг сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд 2017 он гарсаар эдийн засгийн өсөлт эрчимжиж, эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрээд байна. Засгийн газрын хэрэгжүүлж байгаа бодлого болон Дэлхийн эдийн засагт гарч байгаа эерэг өөрчлөлтүүд нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлжээ.

ДНБ-ий эрэлт талаас авч үзвэл 2017 оны эхний хагас жилийн байдлаар экспортын өсөлтөөс гадна бодит хөрөнгө оруулалтын өсөлт 30 хувьд хүрсэн нь эдийн засгийн өсөлтөд голлон нөлөөлөв. Дэлхийн эдийн засаг сэргэж, уул уурхайн бүтээгдэхүүний гадаад зах зээлийн эрэлт нэмэгдэж, түүхий эдийн үнэ өссөний зэрэгцээ хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлсэн зэрэг нь экспорт өсөхөд эергээр нөлөөлөв. Мөн уул уурхайн компаниуд олборлолт, тээвэрлэлтийн хүчин чадлаа нэмэгдүүлэхэд зориулж хөрөнгө оруулалт хийж байгаагаас энэ оны эхний 8 сарын байдлаар экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний экспортын орлого дөрөв дахин, төмрийн хүдрийн экспортын орлого 1.4 дахин нэмэгдээд байна.

Уул уурхайн салбарын дийлэнх бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж байгаа боловч Оюутолгойн зэсийн баяжмалын хэмжээ, түүнд агуулагдах алтны агууламж буурснаар уул уурхайн салбарын нэмэгдэл өртөг эхний хагас жилд 6.1 хувиар буурлаа. Экспорт болон хөрөнгө оруулалтын өсөлт нь импортыг дэмжиж, худалдаа, шууд бус татварын орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тээврийн салбарыг дэмжиж байна. Үүний үр дүнд уул уурхайн бус салбарын өсөлт эхний хагас жилийн байдлаар 9 орчим хувиар өсөөд байна. Түүнчлэн, барилгын салбар ихээхэн хэмжээний уналттай байгаа хэдий ч уналтын хурдац саарч байна.

График № 1. Салбаруудын өсөлт, хувиар



Эх сурвалж: УСХ, СЯ


Энэ оны сүүлийн хагаст эдийн засагт гарч байгаа эерэг өөрчлөлтүүд хадгалагдах бөгөөд 2016 оны сүүлчийн улирлын ДНБ-ий өндөр өсөлтөөс тооцож үзэхэд уул уурхайн бус ДНБ-ий хэмжээ 6.6 хувиар өсч, эдийн засгийн бодит өсөлт 3.3 хувьд хүрэхээр хүлээгдэж байна. Харин зэсийн баяжмал болон газрын тосны үйлдвэрлэл буурч байгаатай холбогдуулан уул уурхайн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 7 хувиар буурахаар байна.

Түүнчлэн, энэ зун хур тунадас бага унаснаас үүдэн Ургацын урьдчилсан балансын дүнгээр хураан авах үр тарианы хэмжээ 2017 оныг өмнөх онтой харьцуулахад 40 орчим хувиар буурах буурах эрсдэлтэй байна. Эдгээр эдийн засгийн дотоод нөхцөл байдал болон экспортын гол нэр төрлийн барааны үнийн хандлагыг тооцож үзэхэд нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 2017 онд 27.4 их наяд төгрөгт хүрэхээр байна.

2.1.1. Төлбөрийн тэнцэл

Өмнөх жилүүдэд төлбөрийн тэнцлийн урсгал данс их хэмжээний алдагдалтай гарч үүнийг гадаад зах зээлээс санхүүжилт босгох замаар шийдвэрлэж ирсэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 4 дүгээр сард 500.0 сая ам.долларын бонд гаргасан, Кредит Свисс банкнаас 250.0 сая ам.долларын арилжааны зээл авсанаар 2016 онд төлбөрийн тэнцэл 18.2 сая ам.долларын алдагдалтай болж буурсан.

График № 2. Монгол Улсын Төлбөрийн тэнцэл



ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсанаар манай улсад олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас нийтдээ 5.5 тэрбум орчим ам.долларын санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн бөгөөд эдгээр эх үүсвэрүүд нь төсвийн нөхцөл байдлыг сайжруулах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулахад чиглэгдэж байна.

Хөтөлбөрийн хүрээнд Монголбанк Хятадын Ардын банк хооронд байгуулсан юаны своп хэлцлийн хугацааг 3 жилээр сунгасан бөгөөд Засгийн газрын зүгээс 2017 онд төлөгдөх байсан Хөгжлийн банкны бондыг /580 сая ам.доллар/ 7 жилийн хугацаатай үнэт цаасаар солих ажиллагааг 2017 оны 3 дугаар сард амжилттай хийсэн ба 2017 оны 5 дугаар сарын 24-нд хөтөлбөр батлагдсанаар эхний санхүүжилт болох 38.4 сая ам.доллар, АХБ-ны 100 сая ам.доллар орж ирж гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлээд байна.

Түүнчлэн Худалдаа Хөгжлийн банкны 2014 онд олон улсын зах зээлд арилжаалсан 117.0 сая ам.долларын үнэт цаасны эргэн төлөлт төлөвлөгөөний дагуу 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр хийгдсэн ба Энержи Ресурс ХХК-ний 2010 онд олон улсад арилжаалсан 600.0 сая ам.долларын үнэт цаасны /senior notes/ үндсэн төлөлт 2017 онд хийгдэх хуваарьтай байсан ба хувьцаа эзэмшигчид өрийн бүтцийг дахин шинэчлэх гэрээг хүлээн зөвшөөрсний дагуу өрийн бүтцийг амжилттай шинэчилж чадсан тул санхүүгийн дансанд учрах эрсдэлийг бууруулсан байна.

ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдсанаар хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж, худалдааны нөхцөл мөн сайжирсны нөлөөгөөр 2017 онд төлбөрийн тэнцэлд хувийн хэвшлийн оролцоо өндөр байв.

2017 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 18.1 хувиар өсөж, 48.8 сая ам.долларын алдагдалтай гарсан. Данснуудаар авч үзвэл Урсгал данс 392.4 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс алдагдал 37.2 хувиар буурсан бол хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 50.4 хувиар буурч 346.5 сая ам.долларт хүрэв.


Урсгал тэнцлийн алдагдал ийнхүү буурахад экспорт /ф.о.б/ өмнөх оны мөн үеэс 30 хувиар, импорт /ф.о.б/ өмнөх оны мөн үеэс 24 хувиар өссөний улмаас барааны дэд данс 49 хувийн өсөлттэй байв. Түүнчлэн аялал, жуулчлалын орлого өмнөх оны мөн үеэс 46 хувиар өсөж, санхүүгийн үйлчилгээний алдагдал өмнөх оны мөн үеэс 87

хувиар, бизнесийн бусад үйлчилгээний алдагдал 19 хувиар буурсан нь үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 20 хувиар буурахад голлон нөлөөлсөн байна.

Харин хөрөнгө ба санхүүгийн дансны хувьд эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 346.5 сая ам.долларын ашигтай гарсан байна. Тайлант хугацаанд Монгол Улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 643.4 сая ам.долларт хүрсэн ба эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэн худалдаа, үйлчилгээний бусад үйл ажиллагаа дийлэнх хувийг бүрдүүлж байна.

2.1.2. Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2017 оны эхний 8 дугаар сарын байдлаар 6.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 33 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн үеэс 64.5 хувиар өссөн байна.



Эх үүсвэр: УСХ

Энэ оны эхний 8 сарын байдлаар 4.1 тэрбум ам.долларын бараа, түүхий эд экспортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 37.1 хувиар өссөн байна. Экспортын өсөлтөд эрдэс бүтээгдэхүүний нэгж үнийн өсөлт болон чулуун нүүрсний биет хэмжээ 1.7 дахин, үнийн дүн 3.7 дахин, төмрийн хүдрийн үнийн дүн 41.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Импортоор 2.8 тэрбум ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 26.7 хувиар өссөн байна. Импортын өсөлтөд автобензин, дизелийн түлш, машин, механик тоног төхөөрөмж, төмөрлөг бүтээгдэхүүн, бүх төрлийн автомашины өсөлт голлон нөлөөлсөн байна.

2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.3 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 1.8 тэрбум ам.долларын ашигтай гарахаар байна.

Экспортын хэмжээ 2017 онд 23 хувиар өсөж, 6 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Харин Оюу Толгойн далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажил хийгдэхээр байгаа нь тоног төхөөрөмж, барилгын материал, машин тоног төхөөрөмжийн импортын хэмжээ өсөхөд голлон нөлөөлөхөөр байгаа тул импортын хэмжээ 4.2 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

2.1.3. Инфляц

Улсын инфляцын түвшин 2014 онд 11.0 хувь байсан бол 2015 онд 1.9 хувь 2016 онд 1.1 хувь болж буурсан байна. Инфляцын түвшин буурч нам түвшинд хүрэхэд эдийн засгийн өсөлт саарч, дотоодын эрэлт хумигдсан нь голлон нөлөөлөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар өсөхөд тээврийн бүлгийн үнэ 9.4 хувь, боловсролын үйлчилгээний үнэ 5.5 хувь, хүнс бараа, ундаа ус бүлгийн үнэ 6.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн ба инфляцын түвшин оны эцэст зорилтот түвшинд байхаар байна.

2.1.4. Мөнгөний салбарын үзүүлэлт

2017 оны 8 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр нийт мөнгөний нийлүүлэлт 14.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 27.6 хувь, өмнөх сараас 3.7 хувиар тус тус өссөн байна. Үүнд, төгрөгийн харилцах өмнөх онтой харьцуулахад 51.5 хувиар өссөн, төгрөгийн хадгаламж 34.0 хувиар өссөн нь тус тус голлон нөлөөлөв.

2017 оны 8 дугаар сарын байдлаар нийт мөнгөний нийлүүлэлтийн 51.4 хувийг төгрөгийн хадгаламж, 16.6 хувийг гадаад валютын хадгаламж, 14.6 хувийг төгрөгийн харилцах, 12.9 хувийг гадаад валютын харилцах, үлдсэн 4.5 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө эзэлж байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.7 хувиар өсөж, 13.5 их наяд төгрөг боллоо. Нийт зээлийн өрийн үлдэгдлийг бүтцээр нь авч үзвэл хэвийн зээл 84.1 хувь, хугацаа хэтэрсэн зээл 7.1 хувь, чанаргүй зээл 8.8 хувийг тус тус бүрдүүлж байна.

3. УЛСЫН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

3.1. Төсвийн орлого

Монгол Улсын Засгийн газар, ОУВС хооронд тохирсон Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн орлогын

арга хэмжээ, 2017 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл зэрэг бусад үзүүлэлтэд үндэслэн Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлогыг 6,511.3 тэрбум төгрөг байхаар тооцож, төсөвт тусгасан. Тодруулбал, эдийн засгийн бодит өсөлтийг -0.2 хувь, 1.0 тн цэвэр зэсийн зах зээлийн үнийг 5,149.8 ам.доллар (1.0 тн цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 4,599.4 ам.доллар), коксжих нүүрсний үнийг 52.0-77.0 ам.доллар байхаар тооцсон.

Гэвч энэ оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн бодит өсөлт 5.3 хувьд хүрч, дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ 5,867.8 ам.доллар, нүүрсний үнэ 113.5-140.8 ам.доллар болж өссөний улмаас өнгөрсөн хугацаанд бизнесийн орчин харьцангуй идэвхжиж, аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаа нэмэгдэж байна. Уул уурхай, түүнийг дагасан эдийн засгийн бусад салбарын өсөлт нь хэрэглээний болон орлогын татвар төлөвлөсөн хэмжээнээс давж биелэхэд гол нөлөө үзүүлжээ.

Иймээс 2017 оны эхний хагас жилийн эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн орлогын гүйцэтгэл болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн цаашдын хандлага зэрэгт үндэслэн 2017 оны нэгдсэн төсвийн орлогын төсөөллийг шинэчлэн боловсрууллаа. Энэ 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 7,112.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 9.2 хувиар буюу 601.5 тэрбум төгрөгөөр, харин тэнцвэржүүлсэн нийт орлого төлөвлөснөөс 8.3 хувиар буюу 501.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

3.1.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны эхний 8 сарын орлогын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2017 оны эхний 8 сарын байдлаар төлөвлөсөн хэмжээнээс 9.8 хувь буюу 433.9 тэрбум төгрөгөөр, тэнцвэржүүлсэн нийт орлого 9.3 хувь буюу 379.5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна. Энэ нь жилийн нийт төлөвлөгөөний 75 орчим хувьтай тэнцэж байна.

Хүснэгт № 1 : Энэ оны эхний 8 сарын орлогын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

| Орлогын нэр төрөл | | Өмнөх оны мөн үе | Жилийн төлөвлөгөө | Эхний 8 сарын төлөвлөгөө | Эхний 8 сарын гүйцэтгэл | Зөрүү |
|-----------------------------------|--|------------------|-------------------|--------------------------|-------------------------|--------------|
| Нийт орлого | | 3,562.4 | 6,511.3 | 4,444.2 | 4,878.2 | 433.9 |
| Тэнцвэржүүлсэн нийт орлого | | 3,562.4 | 6,035.7 | 4,087.7 | 4,467.2 | 379.5 |
| Нэмэгдсэн | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 354.5 | 495.4 | 426.5 | 617.5 | 191.0 |
| | Нийгмийн даатгалын орлого | 761.4 | 1,194.5 | 692.9 | 813.2 | 120.3 |
| | Импортын барааны НӨАТ | 413.2 | 847.4 | 555.0 | 629.9 | 74.9 |
| | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | 159.5 | 611.9 | 472.9 | 537.7 | 64.8 |
| | <i>Үүнээс: Тэнцвэржүүлсэн орлого</i> | <i>159.5</i> | <i>145.8</i> | <i>116.4</i> | <i>126.7</i> | <i>10.3</i> |
| | Импортын барааны гаалийн албан татвар | 199.9 | 413.8 | 267.2 | 334.4 | 67.2 |
| | Дотоодын барааны НӨАТ | 342.9 | 579.5 | 393.0 | 447.2 | 54.2 |
| Буурсан | Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар | 217.2 | 155.8 | 111.2 | 51.9 | -59.2 |
| | Газрын тосны орлого | 79.7 | 233.5 | 165.8 | 126.4 | -39.4 |

Орлогын төлөвлөгөө ийнхүү давж биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ.
Үүнд:

Эдийн засгийн өсөлт 5.3 хувьд хүрч, төлөвлөсөн хэмжээнээс давсан. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс уул уурхайн олборлолтын салбарт 43.1 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 29.9 хувь тус тус өссөн. Улмаар эдийн засгийн бодит өсөлт эхний хагас жилийн байдлаар 5.3 хувьд хүрчээ. Ийнхүү макро эдийн засгийн нөхцөл байдал сэргэж, дотоодын хэрэглээ, худалдан авалтын хэмжээ сайжирч байгаа нь төсвийн орлогын хэмжээ нийт дүнгээр өсөхөд нөлөөлжээ.

Олон улсын зах зээл дээрх нүүрс, зэсийн үнэ өссөн. Энэ оны эхний 8 сарын байдлаар нүүрсний дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 160 орчим хувиар, зэсийн үнэ 24.2 хувиар нэмэгдсэнээс шалтгаалж, уул уурхайн томоохон аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн туслан гүйцэтгэгчдийн борлуулалт, ашигт ажиллагааг нэмэгдүүлжээ.

Үүнээс шалтгаалж уул уурхайн салбараас төвлөрөх нийт орлого эхний 8 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 531.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 983.7 тэрбум төгрөгт хүрсэн нь орлогын төлөвлөгөө давж биелэхэд голлох нөлөө үзүүлжээ. Үүнээс Тогтворжуулалтын санд 175.6 тэрбум, Ирээдүйн өв санд 235.4 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна. Түүнчлэн, зэс, нүүрсний салбарын сэргэлтийн дам нөлөөгөөр дотоодын аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, худалдан авалтын хэмжээ нэмэгдэж байгаа нь уул уурхайн бус салбарын орлогын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлсөн байна.

Түүнчлэн, экспортын үнэлгээ 2017 онд 4.9 тэрбум ам.доллар байхаар тооцсон ба эхний 8 сарын байдлаар 4.1 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 37.1 хувиар өссөн нь уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлогыг төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдүүлэхээр байна.

Дотоодын эдийн засгийн идэвхжилээс шалтгаалан импортын хэмжээ нэмэгдэж байна. Эдийн засгийн өсөлт, уул уурхайн салбарын идэвхжилээс шалтгаалан импортын хэрэглээ өнгөрсөн оны мөн үеэс 26.7 хувь буюу 580.7 сая ам.доллараар нэмэгджээ. Тухайлбал, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оны мөн үеэс 42.7 хувь, газрын тосны бүтээгдэхүүний импорт 73.6 хувиар өссөн байна. Ийнхүү уул уурхай болон боловсруулах үйлдвэрлэл сэргэж байгаатай холбогдуулан импортоос төвлөрүүлэх орлогын хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдэх төлөвтэй байна.

3.1.2 Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлого, хүлээгдэж буй гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2017 онд 7,112.9 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан хэмжээнээс 601.5 тэрбум төгрөгөөр буюу 9.2 хувиар өсөхөөр байна.

Хүснэгт № 2 : Төсвийн орлогын 2017 оны ХБГ /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2016 | 2017 | | |
|--|----------------|----------------|----------------|---------------|
| | Гүйц | Төл | Тод | ЗӨРҮҮ |
| НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 5,835.0 | 6,511.3 | 7,112.9 | 601.5 |
| ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН | 0.0 | 208.8 | 242.4 | 33.6 |
| ИРЭЭДҮЙН ӨВ САН | 0.0 | 266.8 | 333.3 | 66.5 |
| ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 5,835.0 | 6,035.7 | 6,537.1 | 501.4 |
| Татварын орлого | 4,951.0 | 5,049.6 | 5,661.3 | 611.8 |
| Орлогын албан татвар | 1,043.4 | 1,097.6 | 1,330.8 | 233.2 |
| Нийгмийн даатгалын орлого | 1,109.8 | 1,194.5 | 1,248.5 | 54.0 |
| Хөрөнгийн албан татвар | 104.7 | 98.6 | 98.6 | 0.0 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар | 1,140.7 | 1,284.7 | 1,448.5 | 163.8 |
| Онцгой албан татвар | 630.1 | 490.8 | 511.6 | 20.8 |
| Тусгай зориулалтын орлого | 10.8 | 11.9 | 11.9 | 0.1 |
| Гадаад үйл ажиллагааны орлого | 328.5 | 413.8 | 489.8 | 76.0 |
| Бусад татвар (Төлбөр, хураамж) | 583.1 | 457.7 | 521.6 | 63.9 |
| Татварын бус орлого | 884.1 | 986.2 | 875.8 | -110.4 |
| Нийтлэг бус татварын орлого | 805.4 | 832.1 | 799.7 | -32.4 |
| Хөрөнгийн орлого | 1.5 | 0.4 | 0.4 | 0.0 |
| Тусламжийн орлого | 77.2 | 153.7 | 75.7 | -78.0 |

Энэ оны эцсээр татварын орлого 5,661.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 611.8 тэрбум төгрөг буюу 12.1 хувиар өсөх бол татварын бус орлого 986.2 тэрбум төгрөгөөс 875.8 тэрбум төгрөгт хүрч 110.4 тэрбум төгрөгөөр буюу 11.2 хувиар буурахаар байна. Харин эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс хамаарч Тогтворжуулалтын сангийн орлого батлагдсан хэмжээнээс 33.6 тэрбум төгрөгөөр, Ирээдүйн өв сангийн орлого 66.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна.

Хүснэгт № 3. Төсвийн орлогод орж буй өөрчлөлтүүд /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2016 оны гүйцэтгэл | Жилийн төлөвлөгөө | 2017 оны ХБГ | Зөрүү |
|--|--------------------|-------------------|--------------|---------------|
| НИЙТ НЭМЭГДЭХ ОРЛОГО | | | | 739.0 |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 520.0 | 495.5 | 728.7 | 233.2 |
| Импортын барааны НӨАТ | 684.3 | 847.4 | 1,005.0 | 157.6 |
| Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | 288.7 | 611.9 | 762.5 | 150.6 |
| Импортын гаалийн албан татвар | 328.4 | 413.8 | 489.8 | 76.0 |
| Нийгмийн даатгалын орлого | 1109.8 | 1194.5 | 1,248.5 | 54.0 |
| Дотоодын барааны НӨАТ | 558.3 | 579.5 | 600.7 | 21.2 |
| Гаалийн хураамж | 49.1 | 50.2 | 59.4 | 9.2 |
| Агаарын бохирдлын төлбөр | 19.5 | 27.8 | 34.0 | 6.2 |
| Бусад | | | | 31.0 |
| НИЙТ ХАСАГДАХ ОРЛОГО | | | | -137.6 |
| Газрын тосны орлого | 134.2 | 233.5 | 191.8 | (41.7) |
| Хандив тусламж /Гадаад/ | 77.2 | 153.7 | 75.7 | (78.0) |
| Бусад | | | | (17.9) |
| ТӨСВИЙН ОРЛОГОД ОРОХ ЦЭВЭР ӨӨРЧЛӨЛТ | | | | 601.5 |


ТӨСВИЙН ТОДОТГОЛООР ӨӨРЧЛӨГДӨХ ОРЛОГУУД, ТЭДГЭЭРИЙН ҮНДЭСЛЭЛ, ШАЛТГААН:

Нэг. Уул уурхайн салбарын орлогын өсөлт

Энэ оны төсөвт дэлхийн зах зээл дээрх цэвэр зэсийн үнийг тонн тутамд 5,149.8 ам.доллар, нүүрсний үнийг тонн тутамд 52.0-77.0 ам.доллар байхаар тооцсон. Гэвч 2017 оны эхний 8 сард Лондоны металлын бирж дээрх цэвэр зэсийн үнэ дунджаар

5,867.8 ам.долларт, нүүрсний үнэ зах зээлийн байршил, чанарын үзүүлэлтээс хамаарч 60.1-140.8 ам.долларт хэлбэлзжээ. Дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрсний үнийг графикаар үзүүлбэл дараах байдалтай байна:

График № 4. Зэс, нүүрсний үнэ



Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын сүүлийн үеийн үнийн төсөөлөл, эдгээр бүтээгдэхүүний үнийн өнөөгийн түвшин зэргийг харгалзан үзэж, 2017 оны жилийн дунджаар нэг тонн зэсийн үнийг 6,030.0 ам.доллар, нүүрсний үнийг 65.0-100.0 ам.доллар байхаар шинэчлэн тооцлоо. Эдгээр бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс үүдэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого зэсийн баяжмалын борлуулалтаас 23.4 тэрбум төгрөг, нүүрсний борлуулалтаас 130.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Зэсийн үнэ 5,000 ам.доллараас давсан тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт заасны дагуу 11-15 хувийн нэмэлт төлбөр ногдож байгаа нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх томоохон шалтгаан болж байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээний өсөлтөөс шалтгаалан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 150.5 тэрбум төгрөгөөр өсөж 762.5 тэрбум төгрөгт, агаарын бохирдлын төлбөр 6.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 34.0 тэрбум төгрөгт, гаалийн тэмдэгтийн хураамжийн орлого 9.2 тэрбум төгрөгөөр өсөж 59.4 тэрбум төгрөгт тус тус хүрэхээр байна.

Хоёр. Эдийн засгийн өсөлттэй холбоотой орлогууд

Эдийн засгийн бодит өсөлт 5.3 хувьд хүрсэн нь нэгдсэн төсвийн орлого нийт дүнгээр төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна.


Мөн өмнөх оны мөн үеэс бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийн хэмжээ уул уурхайн, олборлох аж үйлдвэрийн салбарт 43.1 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 29.9 хувь тус тус өссөн нь төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Ийнхүү макро эдийн засгийн нөхцөл байдал сэргэж, дотоодын хэрэглээ, худалдан авалт сайжирч байгаа нь төсвийн орлого өсөхөд нөлөөлжээ. Улмаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 233.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 728.7 тэрбум төгрөгт, дотоодын барааны НӨАТ-ын орлого 21.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 600.7 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Гурав. Импортын татвартай холбоотой орлогын өсөлт

Дотоодын эдийн засгийн идэвхжил, уул уурхайн салбар, түүнийг дагасан бусад салбарын үйл ажиллагаа өссөнтэй холбогдуулан импортын барааны хэрэглээ төлөвлөсөн хэмжээнээс өсжээ. Энэ оны эхний 8 сарын байдлаар импортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.7 хувиар нэмэгдсэн байна. Улмаар гаалийн байгууллагаас төвлөрүүлдэг орлого төлөвлөсөн хэмжээнээс 11.2 хувь буюу 119.4 тэрбум төгрөгөөр давжээ.


График № 5: Импортын хэмжээ, импортын задаргаа (2006-2017* /тэрбум ам.доллар/)



Ийнхүү эдийн засгийн өсөлт, уул уурхайн салбарын идэвхжил болон боловсруулах үйлдвэрлэл сэргэж байгаагийн улмаас нийт импортын хэмжээ оны эцэст 4.2 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Иймд импортын барааны НӨАТ-ын орлогыг 157.6 тэрбум төгрөгөөр, гаалийн албан татварын орлогыг 76.0 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдүүлэхээр тооцлоо.

Газрын тосны орлого: Энэ оны эхний 8 сарын байдлаар газрын тосны орлого төлөвлөсөн хэмжээнээс 39.4 тэрбум төгрөг буюу 23.8 хувиар тасарсан. Ийнхүү орлогын гүйцэтгэл буурахад газрын тосны үнэ төлөвлөсөн хэмжээнээс 9.5 гаруй хувиар буурсан нь голлох нөлөө үзүүлжээ. Түүнчлэн, төгрөгийн ам.доллартай харьцах ханш 4 хувиар суларснаас шалтгаалж газрын тосны орлогын гүйцэтгэл буурч байгаа зэргийг харгалзан төсвийн тодотголоор газрын тосны орлогыг 41.7 тэрбум төгрөгөөр бууруулан тооцлоо.

График № 6: Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ, түүний өсөлт, бууралт /2013.01-2017.07/



Хандив тусламж /Гадаад/: Энэ онд гадаад хандив тусламжийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 78.0 тэрбум төгрөгөөр буурч 75.7 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

3.2. ТӨСВИЙН ЗАРЛАГА

3.2.1. Төсвийн урсгал зарлага

3.2.1.1. Нэгдсэн төсвийн урсгал зардлын 2017 оны эхний 8 сарын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2017 оны эхний 8 сарын байдлаар 6,279.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 5,044.8 тэрбум төгрөгийн буюу 80.3 хувийн, улсын төсвийн зарлага 4,752.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 4,021.1 тэрбум төгрөгийн буюу 84.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт № 4. Нэгдсэн төсвийн нийт зардлын эхний 8 сарын гүйцэтгэл, төсвийн бүрэлдэхүүнээр /тэрбум төгрөг/

| | Нэгдсэн төсөв | Улсын төсөв | ОН-ын төсөв | НДС-ийн төсөв |
|--------------------------|----------------|----------------|----------------|----------------|
| Жилийн төлөвлөгөө | 9,083.0 | 6,959.7 | 2,659.5 | 1,891.7 |
| ӨО-ы мөн үе | 5,371.4 | 4,014.1 | 1,399.7 | 1,112.6 |
| Төлөвлөгөө | 6,279.1 | 4,752.9 | 1,829.2 | 1,262.8 |
| Гүйцэтгэл | 5,044.8 | 4,021.1 | 1,350.0 | 1,220.4 |
| Хувь | 80.3 | 84.6 | 73.8 | 96.6 |

Орон нутгийн төсвийн зарлага 1,350.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 73.8 хувийн гүйцэтгэлтэй, Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 96.6 хувийн буюу 1,220.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт № 5. Нэгдсэн төсвийн нийт зардлын эхний 8 сарын гүйцэтгэл, /тэрбум төгрөг/

| Үзүүлэлт | ӨО-ы мөн үе | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | ӨО-ы мөн үетэй харьцуулсан зөрүү | |
|--|----------------|----------------|----------------|--------------|----------------------------------|--------------|
| | | | тэрб.төг | % | тэрб.төг | % |
| | .1. | .2. | .3. | 4=3/2 | 5=3-1 | 6=5/1 |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,371.4 | 6,279.1 | 5,044.8 | 80.3% | -326.6 | -6.1% |
| Нийт зарлага | 4,883.6 | 6,055.6 | 4,919.3 | 81.2% | 35.7 | 0.7% |
| Урсгал зардал | 4,131.4 | 4,822.1 | 4,261.9 | 88.4% | 130.5 | 3.2% |
| Хөрөнгийн зардал | 752.2 | 1,233.4 | 657.4 | 53.3% | -94.8 | -12.6% |
| Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | 487.8 | 223.6 | 125.5 | 56.1% | -362.3 | -74.3% |

Нэгдсэн төсвийн 2017 оны урсгал зардлыг 7,076.1 тэрбум төгрөг байхаар баталсан ба оны эхний 8 сард өссөн дүнгээр 4,822.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 4,261.9 тэрбум төгрөгт хүрч 88.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт № 6 . Нэгдсэн төсвийн урсгал зардлын эхний 8 сарын гүйцэтгэл, зардлын ангиллаар /тэрбум төгрөг/

| Үзүүлэлт | ӨО-ы мөн үе | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | ӨО-ы мөн үетэй харьцуулсан зөрүү | |
|----------------------|----------------|----------------|----------------|--------------|----------------------------------|-------------|
| | | | тэрб.төг | % | тэрб.төг | % |
| | .1. | .2. | .3. | 4=3/2 | 5=3-1 | 6=5/1 |
| Урсгал зардал | 4,131.5 | 4,822.1 | 4,261.9 | 88.4% | 130.5 | 3.2% |
| Цалин хөлс ба НДШ | 1,236.1 | 1,300.4 | 1,256.6 | 96.7% | 40.2 | 1.7% |


| | | | | | | |
|---------------------------------|---------|---------|---------|-------|--------|--------|
| Бараа үйлчилгээний бусад зардал | 908.7 | 1,037.7 | 726.6 | 70.3% | -205.9 | -13.7% |
| Хүүгийн зардал | 465.8 | 715.1 | 654.4 | 91.5% | 188.6 | 40.5% |
| Татаас | 129.2 | 199.9 | 162.1 | 81.1% | 32.9 | 25.5% |
| Урсгал шилжүүлэг | 1,494.0 | 1,677.6 | 1,565.5 | 93.3% | 71.5 | 4.8% |

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал урсгал зардал нийт 130.5 тэрбум төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн гүйцэтгэлтэй гарахад зээлийн хүүгийн зардал 188.6 тэрбум төгрөг, татаас болон урсгал шилжүүлгийн зардал 32.9 тэрбум төгрөгөөр, цалин НДШ 40.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол бараа үйлчилгээний бусад зардал 205.9 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

3.2.2. Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тодотголын төсөлд нийт зарлага ба цэвэр зээлийг 9,248.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 33.7 хувь байхаар тооцсон нь 2016 оны төсвийн гүйцэтгэлээс 246.7 тэрбум төгрөгөөр буурахаар харин 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээс 498.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

График № 7. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн, ДНБ-д эзлэх хувь /тэрбум төгрөг/



Төсвийн нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 33.7 хувьд хүрэхээр байна. Уг үзүүлэлт 2011 онд ДНБ-ий 46.1 хувьтай буюу хамгийн өндөр түвшинд хүрч байсан бол 2015 он хүртэл хугацаанд буурч, 2016 онд дахин 39.9 хувьд хүрч огцом нэмэгдсэн бол 2017 оны анх баталсан төсвөөр 32.3 хувьд хүрч мөн огцом буурсан байна.

Хүснэгт № 7. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл, /тэрбум төгрөг/

| | 2016 Гүйц | 2017 Бат | 2017 Тод 1 | 2017 Тод 2 | Зөрүү (2017 Тод2-2017 Тод 1) тэрб.төг | Хувь |
|--|----------------|----------------|----------------|----------------|--|-------------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 9,519.9 | 8,569.1 | 8,750.2 | 9,248.6 | 498.5 | 5.7% |
| А. УРСГАЛ ЗАРЛАГА | 6,613.8 | 6,948.0 | 6,843.6 | 6,948.8 | 105.2 | 1.5% |
| 1. Бараа, үйлчилгээний зардал | 3,133.3 | 3,045.1 | 3,075.9 | 3,091.2 | 15.3 | 0.5% |
| 2. Зээлийн үйлчилгээний төлбөр | 986.1 | 1,345.7 | 1,201.8 | 1,156.7 | -45.1 | -3.8% |

| | | | | | | |
|-------------------------------------|----------------|----------------|----------------|----------------|--------------|--------------|
| 3. Татаас ба урсгал шилжүүлэг | 2,494.4 | 2,557.2 | 2,566.0 | 2,700.9 | 135.0 | 5.3% |
| Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,360.2 | 1,483.9 | 1,579.8 | 1,887.8 | 308.1 | 19.5% |
| В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ | 521.3 | 137.2 | 326.7 | 411.9 | 85.2 | 26.1% |

Монгол Улсын 2017 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 498.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд хөрөнгийн зардал 308.1 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 85.2 тэрбум төгрөгөөр, бараа, үйлчилгээний зардал 15.3 тэрбум төгрөгөөр, татаас шилжүүлгийн зардал 135.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, зээлийн хүүгийн зардал 45.1 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

3.2.3 Төсвийн урсгал зарлагын тодотголын төсөл

Нэгдсэн төсвийн урсгал зардлын нийт хэмжээг 2017 оны тодотголд 6,948.8 тэрбум төгрөг буюу өмнөх тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулбал 105.2 тэрбум төгрөгөөр буюу 1.5 хувиар нэмэгдүүлэхээр тооцож төслийг боловсруулав.

Хүснэгт № 8. Нэгдсэн төсвийн урсгал зардал, /тэрбум төгрөг/

| | 2016 Гүйц | 2017 Бат | 2017 Тод 1 | 2017 Тод 2 | Зөрүү | |
|--------------------------------|----------------|----------------|----------------|----------------|--------------|-------------|
| | | | | | дүн | хувиар |
| А. УРСГАЛ ЗАРЛАГА | 6,613.8 | 6,948.0 | 6,843.7 | 6,948.8 | 105.2 | 1.5% |
| 1. Бараа, үйлчилгээний зардал | 3,133.3 | 3,045.1 | 3,075.9 | 3,091.2 | 15.3 | 0.5% |
| 1.1 Цалин, хөлс | 1,746.8 | 1,744.9 | 1,747.8 | 1,764.4 | 16.6 | 0.9% |
| 1.2 БҮ-ний бусад зардал | 1,386.5 | 1,300.2 | 1,328.1 | 1,326.8 | -1.3 | -0.1% |
| 2. Зээлийн үйлчилгээний төлбөр | 986.1 | 1,345.7 | 1,201.8 | 1,156.7 | -45.1 | -3.8% |
| 3. Татаас ба урсгал шилжүүлэг | 2,494.4 | 2,557.2 | 2,566.0 | 2,700.9 | 135.0 | 5.3% |

Төсвийн орлого эхний хагас жилд төлөвлөснөөс давж биелсэн, оны эцэст орлогын гүйцэтгэл давж биелэх хандлагатай байгааг харгалзан ОУВС-ын хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний явцад тохирсоны дагуу давсан орлогын тодорхой хэсгийг тухайн жилдээ өр барагдуулах, нэг удаагийн шинжтэй тулгамдсан зарим арга хэмжээг санхүүжүүлэх, цаашид алдаглыг бууруулахад ашиглахаар төлөвлөж байна.

Иймд улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, үүссэн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж төсвийн зарлагын тодотголын төслийг дараахь зарчмыг баримтлан боловсрууллаа. Үүнд:

1. Олон улсын валютын сангийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн эхний шатны үнэлгээний хүрээнд тохирсон өөрчлөлтүүдийг төсөвт тусгах;
2. Хууль тогтоомжийн өөрчлөлт, нийгмийн хамгааллын бодлогод орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд нэмж шаардагдах зардлыг төсөвт тусгах.
3. Өсөн нэмэгдэж байгаа эрэлт, хэрэгцээнд нийцүүлж төрийн үйлчилгээний хүртээмж, хамрагдах хүрээг нэмэгдүүлэх;
4. Төсөвт ирэх жилүүдэд дарамт үзүүлэхгүй бөгөөд нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой дор дурьдсан зориулалт бүхий нэг удаагийн шинжтэй зардлыг тусган хэрэгжүүлэх. Үүнд:
 - i. Өвөлжилт, цаг агаарын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгах;

- ii. 2015-2017 оны эхний хагас жилд тохиолдсон байгалын аюулт үзэгдэл, мал, амьтны гоц халдварт өвчний улмаас учирсан хохиролыг барагдуулах;
- iii. Орон нутаг болон улсын төсвийн байгууллагуудад хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх;
- iv. Шүүхийн шийдвэрийн дагуу төрөөс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад олгох төлбөрийг барагдуулах;
- v. ЖДҮ-ийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэхэд төсвөөс дэмжлэг үзүүлэх;

5. Төсвийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэл, хэрэгцээнд нийцүүлэн төсөвт нэмэлт дарамт үүсгэхгүй байх зарим зохицуулалтыг хийх.

Дээрх зарчмын дагуу төсвийн тодотголын төслийг боловсруулахад нэгдсэн төсвийн нийт зардал 498.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэх ба нийт өөрчлөлтийн 21.0 хувь буюу 105.2 тэрбум төгрөгийг урсгал зардал, 62.0 хувь буюу 308.1 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал, 17.1 хувь буюу 85.2 тэрбум төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн өөрчлөлт хамаарч байна.

Хүснэгт № 9. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлс, шалтгаан /тэрбум төгрөг/

| № | Зардал нэмэгдүүлж буй хүчин зүйлс, арга хэмжээ | Нийт өөрчлөлт | Үүнээс: | | |
|---|---|---------------|--------------|------------------|---------------------------|
| | | | Урсгал | Хөрөнгө оруулалт | Эргэж төлөгдөх цэвэр зээл |
| Нэгдсэн төсвийн нийт зарлагын өөрчлөлт | | 498.5 | 105.2 | 308.1 | 85.2 |
| 1. | Хууль, тогтоолын өөрчлөлтөөр нэмэгдэх зардал | 117.7 | 117.7 | 0.0 | 0.0 |
| 2. | Өвөлжилт, цаг үеийн тулгамдсан асуудал | 94.1 | 22.8 | 7.9 | 63.4 |
| 3. | Хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах | 39.0 | 39.0 | 0.0 | 0.0 |
| 4. | Эмнэлгийн тусламж үйлчилгээний хамрах хүрээ нэмэгдсэн | 19.0 | 19.0 | 0.0 | 0.0 |
| 5. | Шүүхийн шийдвэрийн дагуу иргэд, ААН-д олгох нөхөн олговор | 8.8 | 8.8 | 0.0 | 0.0 |
| 6. | ЖДҮ-ийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх болон бусад | 83.0 | 10.3 | 0.0 | 72.6 |
| 7. | Зээлийн хүүгийн зардлыг бууруулах | -45.1 | -45.1 | 0.0 | 0.0 |
| 8. | Батлагдсан төсвийн хүрээнд ТЕЗ-ын багцад зохицуулалт хийх | -31.5 | -0.5 | 3.0 | -34.0 |
| 9. | Улсын төсвийн хөрөнгө оруулалт, концессын төлбөр | 290.8 | 0.0 | 290.8 | 0.0 |
| 10. | Гадаад зээл, тусламжаас санхүүжих төслийн зардал | -78.0 | -67.1 | 6.0 | -16.8 |

Нийт зарлагын өөрчлөлт 59.8 хувь нь өвөлжилтийн бэлтгэл хангах, ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, шүүхийн шийдвэрийн дагуу иргэд аж ахуйн нэгжид төлөх төлбөр, хуримтлагдсан өр төлбөр барагдуулах зэрэг нэг удаагийн шинжтэй арга хэмжээнээс шалтгаалж байна. Харин нийт зардлын өөрчлөлтийн 27.3 хувь нь хууль тогтоомжийн өөрчлөлт, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ, орон нутагт дулаан, халаалтын үнэ тариф нэмэгдсэн, хөрөнгө оруулалтын үр дүнд төвлөрсөн халаалтын системд холбогдсон

зэрэг шалтгааны улмаас зардал нэмэгдэх, энэ нь дараагийн жилийн төсөвт зохих нөлөөлөл үзүүлэх арга хэмжээнүүд байна.

Нэг. Хууль, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах чиглэлээр

Монгол Улсын 2017 оны төсөв батлагдсанаас хойш хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотой зардал, түүнчлэн ОУВС-ын хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн тохирсон зарим арга хэмжээний зардлыг төсвийн тодотголд тусгахаар тооцлоо.

Тухайлбал, Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хяналт шалтгалт, зөрчил илрүүлэлтийг сайжруулах чиглэлээр цагдаа, гааль, татварын байгууллагуудад шаардлагатай байгаа зарим урсгал зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн ОУВС-ын хөтөлбөрийн хүрээнд харилцан тохиролцсоны дагуу хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2017 онд нийт өрхийн хүүхдэд олгохын сацуу орлого багатай, ядуу эмзэг хэсэгт хүргэх нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор Хүнс тэжээлийн дэмжлэг хөтөлбөрийн хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардагдах зардлыг тодотголд тусгахаар тооцлоо.

Хүснэгт № 10. Хууль, тогтоолын өөрчлөлтийн товчоо /тэрбум төгрөг/

| Арга хэмжээ, зориулалт | Өөрчлөлт |
|---|-----------------|
| НИЙТ | 117.7 |
| 1.Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг 2017 онд бүх хүүхдэд олгох | 104.5 |
| 2.Хүнс тэжээлийн дэмжлэг хөтөлбөрт нэмэгдэх зардал | 8.0 |
| 3.Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой Гааль, татварын байгууллагад нэмэгдэх чиг үүрэг, бүтэцтэй холбоотой урсгал зардал | 3.0 |
| 4.Зөрчлийн тухай хуулийн дагуу хууль, хяналтын байгууллагуудад шийтгэврийн хуудас-маягт хэвлэх зардал | 1.2 |
| 5.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх | 1.0 |

Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг он дуустал бүх хүүхдэд олгоно: Засгийн газраас ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт тохирсон бодлогын арга хэмжээг үндэслэн “хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ийг 2017 онд нийт хүүхдийн 60 хувьд олгох, 2018 оны 1 сарын 1-ээс эхлэн нийт өрхийн амьжиргааны түвшин доогуур 40 хувьд (эдгээр өрхөд нийт хүүхдийн 50 орчим хувь байдаг) хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэн үргэлжлүүлэн олгох, 2019 онд нөхөж олгохоор урьд гаргасан УИХ, ЗГ-ын шийдвэрүүдийг хүчингүй болгох саналыг боловсруулан УИХ-аар 2017 оны төсвийн тодотголын хамт шийдвэрлүүлсэн. Үүний дагуу 2017 оны төсөвт 161.5 тэрбум төгрөг батлагдсан.

2017 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр давхардсан тоогоор нийт 3802.9 мянган хүүхдэд сар бүр 20 мянган төгрөг олгосноор нийт 76.1 тэрбум төгрөг зарцуулсан. Энэ нь дунджаар сар тутамд 633.8 мянган хүүхдэд 12.7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Харин Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 201 дүгээр тогтоолоор Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн нийт өрхийн хүүхэд бүрд олгохоор тогтсон. Ингэхдээ 2017 оны 1 дүгээр

сараас эхлэн тооцох, хүүдийн мөнгө аваагүй 40 хувьд эхний 6 сард ногдох мөнгөн тэтгэмжийг нөхөн олгох, харин 7 дугаар сараас бүх хүүхдэд олгохоор шийдвэрлэсэн.

Үүний дагуу 2017 оны 1-6 дугаар сарын хүүхдүүдийн мөнгийг нөхөж олгоход нийт 48.4 тэрбум төгрөг, 7-р сард бүх хүүхдэд олгоход 21.7 тэрбум төгрөг буюу нийт 70.1 төгрөгийн хүүхдийн мөнгө олгоход зарцуулсан байна.

Хүснэгт № 11. Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн санхүүжилт (тэрбум төгрөг, мянган хүүхэд)

| Он сар | Зарцуулалтын төлөвлөгөө /2017.7.21-ний байдлаар / | Үүнээс | | | | Нэмж шаардагдах | | |
|----------------------|---|--------------|--------------|-----------------|------------|-----------------|--------------|--|
| | | Гүйцэтгэл | | Олгохоор ХБ дүн | | Хүүхэд | Дүн | |
| | | Хүүхдийн тоо | Дүн | Хүүхдийн тоо | Дүн | | | |
| 2017-01 | 12.5 | 622.0 | 12.4 | 16.8 | 0.3 | - | - | |
| 2017-02 | 13.4 | 655.6 | 13.1 | 16.8 | 0.3 | - | - | |
| 2017-03 | 13.4 | 635.7 | 12.7 | 17.0 | 0.3 | - | - | |
| 2017-04 | 14.3 | 641.0 | 12.8 | 17.9 | 0.4 | - | - | |
| 2017-05 | 13.4 | 626.0 | 12.5 | 19.9 | 0.4 | - | - | |
| 2017-06 | 13.4 | 622.3 | 12.4 | 21.7 | 0.4 | - | - | |
| 2017-07 | 70.1 | 2,420.6 | 48.4 | 29.7 | 0.6 | - | - | |
| | | 1,083.9 | 21.6 | 353.5 | 7.0 | - | - | |
| 2017-08 | 11.0 | - | - | - | - | 1,088.9 | 21.7 | |
| 2017-09 | - | - | - | - | - | 1,093.9 | 21.8 | |
| 2017-10 | - | - | - | - | - | 1,098.9 | 21.9 | |
| 2017-11 | - | - | - | - | - | 1,103.9 | 22.0 | |
| 2017-12 | - | - | - | - | - | 1,114.5 | 22.2 | |
| Дүн | 161.5 | - | 146.1 | 493.6 | 9.8 | 5,500.0 | 110.0 | |
| Дансны үлдэгдэл | | | | | | | 5.5 | |
| Нийт нэмэгдэх | | | | | | | 104.5 | |

Ингэснээр оны эхнээс өссөн дүнгээр хүүхдийн мөнгөн тэтгэмжид нийт 146.2 тэрбум төгрөг зарцуулж, оны сүүлийн хагаст хүүхдийн мөнгө олгохоор хуваарилагдсан хөрөнгөөс нийт 56.7 тэрбум төгрөгийг 7 дугаар сард шилжүүлэх хуваарилах зохицуулалт хийж санхүүжүүлтийг олгосон.

УИХ-аас 2017 оны 4 дүгээр сард хийсэн тодотголд хүүхдийн мөнгөн тэтгэмжид 161.5 тэрбум төгрөг зарцуулахаар батласан ба үүнээс эхний 7 сард 146.2 тэрбум төгрөг зарцуулж 15.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа тул 8 дугаар сард эхлэн хүүхдийн мөнгө бүрэн олгох боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Цаашид он дуустал хүүхдийн мөнгийг бүх хүүхдэд бүрэн олгоход нийт 104.5 тэрбум төгрөг шаардлагатай байгаа. Иймд 2017 оны төсвийн тодотголд дээрх эх үүсвэрийг нэмж тусгах замаар хүүхдийн мөнгийг олгохоор тооцов.

Хүнс тэжээлийн хөтөлбөрийн хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлнэ: ОУВС-гийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хийсэн хэлэлцээрийн хүрээнд нийгмийн халамжийн бодлогыг нийгмийн эмзэг бүлэгт түлхүү чиглүүлэх, тухайлбал Хүүхдийн мөнгийг зөвхөн зорилтот бүлэгт олгох, нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг нэгтгэх, оновчтой болгох зэргээр бий болох хэмнэлтийг зорилтот бүлгийн өрхөд олгодог “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр”-ийг өргөжүүлэхэд зарцуулахаар тохиролцсон.

Мөн Дэлхийн банкны хөгжлийн бодлогын зээлийн хүрээнд зээл олгох нөхцөлд одоогоор харьцангуй хязгаарлагдмал хүрээнд буюу 26 мянган өрхийн 140 мянга орчим иргэнд хүргэдэг “Хүнсний талон” хөтөлбөрийн хамрах хүрээ, мөнгөн тэтгэмжийг эрс нэмэгдүүлж орлого багатай эмзэг бүлгийн өрхийг хамгаалахад чиглүүлэх, энэ арга хэмжээг 2017 оноос эхлэхээр хэлэлцээрт тусгасан.

Нийгмийн халамжийн тухай хуульд заасан хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд зориулж 2017 оны төсөвт 17.9 тэрбум төгрөг төсөвлөсөн ба өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлох судалгаанд хамрагдсан, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай буюу хамгийн бага орлоготой 26,0 мянган өрхийн 138.0 мянган иргэн хамрагдаж сар тутамд том хүн 13000 төгрөг, хүүхэд 6500 төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг авч байна.

Дээрх зорилтыг хангах арга хэмжээг 2017 онд багтаан эхлэхийн тулд шаардагдах хөрөнгийг 2017 оны төсвийн тодотголд нийт 8.0 тэрбум төгрөг нэмж тусгаж байна. Ингэснээр 2017 оны 11,12 дугаар сараас хүнсний эрхийн үйлчилгээний хамрах хүрээг 2 дахин нэмэгдүүлж 52.3 мянган өрхийн 288.6 мянган иргэнд, мөнгөн дүнг 20 гаруй хувиар нэмэгдүүлж сар бүр том хүнд 16000 төгрөг, хүүхэд 8000 төгрөг тус тус хүнс тэжээлийн дэмжлэгт зориулан олгох боломж бүрдэнэ.

Хүснэгт № 11. Хүнсний талон хөтөлбөрийн хамрах хүрээний өргөжилт /сая төгрөг/

| Нийт өрх | Үүнээс: | | Төсвийн тооцоолол | | |
|----------|---------|---------|---------------------|------------|-------------------|
| | Том хүн | Хүүхэд | 2017 онд батлагдсан | Шинэчилсэн | Нийт нэмэгдэх дүн |
| 52,333 | 151,196 | 137,489 | 17,980.5 | 25,980.5 | 8,000.0 |

Энэхүү үйлчилгээ нь нийгмийн халамжийн туслалцаа хамгийн их шаардлагатай ядуу иргэдийн амьжиргаанд томоохон дэмжлэг үзүүлдэг бөгөөд цаашид хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулах зорилгоор үйлчилгээнд хамрагдсан хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн дэмжих арга хэмжээнд хамрагдсан байх, сургуулийн насны хүүхдүүдээ сургуульд бүрэн хамруулсан байх зэрэг нөхцөл тавьж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Мөн Нийгмийн халамжийн олон тусдаа хөтөлбөрүүдийг нэгтгэх, давхцалыг арилгах, хамрагдах шалгуур үзүүлэлтийг тодорхой нарийвчлан тогтоох зэргээр оновчтой, зорилтот түвшинд олгодог байх, ингэснээр зардлыг хэмнэх чиглэлээрх өөрчлөлтийг судалгаанд үндэслэн олон улсын түншлэгч байгууллагуудтай хамтран Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас үе шаттай хэрэгжүүлэхээр болсон ба одоо олгож байгаа тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээний хүртгэмжийн түвшнийг хадгалах, нийгмийн халамжийг эн тэргүүнд шаардлагатай хэсэгт буюу зорилтод бүлэгт чиглүүлэх бодлого, зарчим баримталж байна.

Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусгана: 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “Шийтгэлийн хуудасны маягт батлах тухай” Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 194 тоот тогтоолоор баталсан маягтыг хэвлүүлэх зардалд нийт 2,800,000 ширхгээр тооцож, 1,232.0 сая төгрөгийг хууль, хяналтын байгууллагуудын төсөвт тусгахаар тооцов.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Гааль, татварын байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг нэмэгдэж байгаа тул тус байгууллагуудын бүтэц, орон тоог шинэчлэн зохион байгуулах, үүнтэй холбоотойгоор гарах цалин хөлс болон урсгал зардлыг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсөлд тусгалаа.

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангуулах зардлыг төсөвт тусгана: Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 тоот “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” тогтоолын дагуу уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх Олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг 41 нэгжид байгуулахад шаардагдах 168 гишүүний урамшууллын зардалд нийт 499.6 сая төгрөгийг Авлигатай тэмцэх газрын 2017 оны төсвийн тодотголын төсөлд тусгав.

Түүнчлэн Авлигатай тэмцэх газрын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах цалин, нийгмийн даатгалын шимтгэл, шуудан холбооны зардал, байцаан шийтгэх ажиллагааны зардалд нийт 500.0 сая төгрөг нэмж тусгав.

Хоёр. Өвөлжилт, цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр

2017 оны 2 дугаар улирлын байдлаар нийт нутгийн 43 хувь нь гандуу, 34 хувь нь гантай байсны улмаас газар тариалангийн салбарт ургац алдах, мөн бэлчээрийн гарц багатайгаас шалтгаалж мал өвөлжилт хүндэрч болзошгүй тул төв суурин газрын болон хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэлийг хангах, энэ оны эхний 7 сарын байдлаар тохиолдсон байгалийн аюулт үзэгдэл, мал амьтын гоц халдварт өвчний улмаас учирсан хохирлыг барагдуулах зэрэг цаг үеийн тулгамдсан арга хэмжээг төсөвт тусган хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна. Эдгээр нь нэг удаагийн шинжтэй арга хэмжээ байх бөгөөд дараагийн төсвийн жилд зардал нэмэгдүүлэх нөлөөлөл үзүүлэхгүй юм.

Хүснэгт № 12. Өвөлжилт, цаг үеийн онцлогтой зарим арга хэмжээний товчоо /тэрбум төгрөг/

| # | Арга хэмжээ, зориулалт | Өөрчлөлт |
|-------------|--|-------------|
| НИЙТ | | 95.1 |
| 1 | Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх | 8.9 |
| 2 | Буудайн үрийн нөөц бэлтгэх | 23.4 |
| 3 | Тэжээл худалдаж авахад зээл олгох | 40.0 |
| 4 | Махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх дэмжлэг | 3.5 |
| 5 | Ойн хөнөөлт шавжтай тэмцэх арга хэмжээнд 2017 онд шаардагдах зардал | 3.5 |
| 6 | ЗГ-ын нөөц сангийн хөрөнгийг 2017 оны ХБГ-д үндэслэн нэмэгдүүлэх. Үүнд: | 14.8 |
| 6.1 | <i>Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураалтад зарцуулсан хэмжээгээр ЗГ-ын нөөц санг нэмэгдүүлэх</i> | 7.2 |
| 6.2 | <i>Ойн түймрийн хохирлыг арилгах, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, малын гоц халдварт өвчний улмаас устгасан малын нөхөн төлбөр</i> | 6.9 |
| 7 | Бусад | 0.8 |

Өвс тэжээл, буудайн үрийн нөөц бүрдүүлэх: Өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбогдуулан бүх аймгийн хэмжээнд нийтдээ 15.5 тонн өвс, тэжээлийн аюулгүй нөөц

бүрдүүлэхэд 1 аймагт дунджаар 204.0 сая төгрөгөөр тооцож нийт 4.5 тэрбум төгрөг, улсын нөөцөд дотоодын зах зээлээс болон гадаадаас импортоор 23.8 тонн өвс, тэжээлийн нөөц бэлтгэхэд зориулж 4.4 тэрбум төгрөг тусгалаа

Хүснэгт №13. 2017 онд аймгуудад хуваарилах өвс, тэжээлд зарцуулах дүн

| № | Аймаг | Сумын тоо | Малын тоо /мян.толгой/ | Дүн /сая төг/ |
|-------------|-------------|------------|---------------------------|------------------|
| 1 | Архангай | 19 | 5,490.0 | 400.8 |
| 2 | Баян-Өлгий | 13 | 2,369.5 | 136.6 |
| 3 | Баянхонгор | 20 | 4,379.7 | 414.6 |
| 4 | Булган | 16 | 3,791.9 | 327.1 |
| 5 | Говь-Алтай | 18 | 3,725.4 | 244.5 |
| 6 | Говь сүмбэр | 3 | 424.5 | 19.8 |
| 7 | Дархан-Уул | 4 | 356.1 | 15.0 |
| 8 | Дорноговь | 14 | 1,761.2 | 122.1 |
| 9 | Дорнод | 14 | 1,892.9 | 114.9 |
| 10 | Дундговь | 15 | 3,310.5 | 169.3 |
| 11 | Завхан | 24 | 3,628.5 | 229.7 |
| 12 | Орхон | 2 | 148.5 | 9.4 |
| 13 | Өвөрхангай | 19 | 5,573.8 | 423.4 |
| 14 | Өмнөговь | 15 | 2,304.4 | 156.3 |
| 15 | Сүхбаатар | 13 | 3,349.1 | 207.6 |
| 16 | Сэлэнгэ | 17 | 1,670.9 | 108.4 |
| 17 | Төв | 27 | 5,141.4 | 360.4 |
| 18 | Увс | 19 | 2,952.1 | 210.8 |
| 19 | Ховд | 17 | 3,517.1 | 307.5 |
| 20 | Хөвсгөл | 23 | 5,332.5 | 310.7 |
| 21 | Хэнтий | 18 | 4,364.6 | 211.1 |
| НИЙТ | | 330 | 65,484.4 | 4,500.00 |

Мөн 2017 оны 2, 3-р улиралын эхээр хур тундас бага орсноос ургац ихээр алдаж байгаа тул ирэх хаврын үрийн хэрэгцээний 50 хүртэлх хувийг Тариалан эрхлэлтийг дэмжих санд төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлтэй зээл олгох замаар улаанбуудайн үрийн нөөц бүрдүүлж, 2018 оны хавар тариаланчдад борлуулах замаар эргэн төлөлт хийх боломжтой гэж үзэж нийт 30.0 мянган тонн үр худалдан авч нөөцлөхөд зориулж 23.4 тэрбум төгрөг тусгалаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2017 оны 9 сарын 22-ны өдрийн 01/2840 дугаар албан бичгээр ирүүлсэн саналын дагуу дотоодоос өвс тэжээл бэлтгэхэд хүрэлцээ муу байгааг харгалзан өвс тэжээл импортолоход зориулж 40.0 тэрбум төгрөгийг төсвөлсөн бөгөөд өвс тэжээлийг малчдын хэрэгцээнд борлуулсан орлогоос эргэн төлөгдөхөөр тооцов.

Ихэнх нутгаар гандуу байгаатай холбогдуулан өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний хүрээнд малын тэжээлийн нөөц бэлтгэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Мал хамгаалах сангаас 40.0 тэрбум төгрөгийн зээл олгоно.

Хүснэгт № 14. 2018 оны хаврын тариалалтад үрийн нөөц бүрдүүлэх хэрэгцээ

| дд | Үзүүлэлт | хэмжих нэгж | Талбайн бэлэглэлт /га/ | | | Нийт хэмжээ |
|---------|--------------------------------------|-------------|------------------------|-----------------|----------------------|-----------------|
| | | | Жижиг аж ахуй | Дунд аж ахуй | Томоохон аж ахуй | |
| 1 | Тариалж буй талбайн хэмжээ | га | 0-500 | 501 -1400 | 1401 ба түүнээс дээш | |
| 2 | Тариаланчийн тоо | тоо | 899 | 194 | 67 | 1160.0 |
| 3 | Бүлэгт хамрагдах тариалангийн талбай | га | 115,528 | 139,660 | 124,812 | 380,000 |
| 4 | Га-гийн үрийн норм | тонн | 0.16 | | | |
| 5 | Нийт үрийн хэрэгцээ | тонн | 18,484.5 | 22,345.6 | 19,969.9 | 60,800.0 |
| Үүнээс: | Аж ахуйгаас хангах | тонн | 3,696.9 | 8,938.2 | 17,972.9 | 30,608.1 |
| | Дотоодын ургацаас бүрдүүлсэн нөөц | тонн | 14,787.6 | 13,407.4 | 1,997.0 | 30,191.9 |

Эх үүсвэр: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Үрийн нөөц бүрдүүлэх хэрэгцээг тооцоходоо газар тариалан эрхэлж буй томоохон аж ахуйн хувьд нийт хэрэгцээт үрийн нөөцийнхөө 90 хувийг, дунд зэргийн аж ахуйн хувьд 40 хувийг, жижиг аж ахуйн хувьд 20 хувийг тус тус өөрсдөө бүрдүүлэх, үлдсэн хэсгийг Тариалан эрхлэлтийг дэмжих санд дотоодоос нөөц бүрдүүлэхээр тооцов. Ингэснээр 2018 оны хаврын тариалалтад шаардагдах нийт 60.8 мянган тонн үрийн улаан буудайн 50 хувь буюу 30.6 мянган тонныг тариаланчид нөөцлөх, дутагдах 50 орчим хувь буюу 30.0 гаруй мянган тонныг Тариалан эрхлэлтийг дэмжих сан 2017 оны намрын ургацаас бүрдүүлэхээр тооцов.

Махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх: Цаг агаарын урьдчилсан төлөвөөр өвөлжилт хүндэрч болзошгүй байгаа тул махны нийлүүлэлт нэмэгдэх хандлагатай байна. Махны нийлүүлэлт огцом нэмэгдэх үед эрэлтийг дэмжих, дотоодын мах бэлтгэдэг аж ахуй нэгж үүдэд нөөц бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тэдгээрт эргэлтийн хөрөнгийн дутагдлыг нөхөх зориулалтаар авах зээлийн хүүгийн хөнгөлөлтийг төсвөөс олгох зарчим баримтлаж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн мэдээллээр 2017 оны намар мах бэлтгэх аж ахуйн нэгжүүдэд нийт 100 орчим тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай гэсэн судалгаа байна¹. Иймд хувийн хэвшлийн мах бэлтгэх аж ахуйн нэгжүүдэд дээрх зориулалтаар зээл авсан нөхцөлд 2017 оны 4-р улиралд 100 хүртэлх тэрбум төгрөгийн зээлийн хүүг 10 хувиар хөнгөлөхөд төсвөөс шаардагдах хөрөнгийн хэмжээг 3.5 тэрбум төгрөг байхаар тооцож төсөлд тусгасан ба цаашид шаардлагах хөрөнгийг 2018 оны төсвийн төсөлд тусгана.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх: Энэ оны 5-7 дугаар саруудад ихэнх нутгаар гантай болон гандуу, хуурайшилт ихтэй байснаас шавжийн хөгжлийн үе шатууд өмнөх жилүүдийнхээс 20-25 хоногийн урд эхэлсэн байна. Улаанбаатар хотын ногоон бүс, Богд-хан уулын Дархан цаазат газрын ойн сан 47.6 мянган га талбайд өрөөсгөл хүр эрвээхий, Архангай, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Булган, Орхон аймгуудын ойн санд 75.5 мянган га талбайд Сибирийн хүр эрвээхий тархаж байгаа нь Монгол Улсын ойн санд их хэмжээний хохирол учрах нөхцөл байдал үүсээд байна.

¹ Эх үүсвэр

Дээрх нөхцөл байдлыг харгалзан “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 200 дугаар тогтоолоор ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг 220.0 мянган га талбайд 6.6 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсэн.

Хүснэгт № 15. Ойн хөнөөлт шавжтай тэмцэхэд зарцуулах хөрөнгө /сая төгрөг/

| Д/д | Аймаг, нийслэл нэр | Хамрагдах талбай, мян.га | Зарцуулах хөрөнгө |
|-----|------------------------------|--------------------------|-------------------|
| | НИЙТ | 123.1 | 3,480.1 |
| 1 | Архангай | 5.0 | 190.0 |
| 2 | Хэнтий | 29.9 | 1,139.3 |
| 3 | Булган | 10.9 | 416.3 |
| 4 | Төв | 9.2 | 353.3 |
| 5 | Орхон | 9.0 | 343.7 |
| 6 | Сэлэнгэ | 11.1 | 424.3 |
| 7 | Улаанбаатар хотын ногоон бүс | 42.9 | 540.7 |
| 8 | Богдхан уулын ДЦГ | 4.6 | 72.5 |

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Дээрх шийдвэрийн дагуу “Ойн судалгаа хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газраас мэргэжлийн төрийн бус байгууллагуудтай хамтран эхний ээлжид ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулахад нэн шаардлагатай байгаа талбайн хэмжээг тогтоосон ба уг талбайн хөнөөлт шавж устгах арга хэмжээний зардалд он дуустал хугацаанд шаардагдах 3.5 тэрбум төгрөгийн зардлыг төсөлд тусгалаа.

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг 2017 хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн нэмэгдүүлэх: Монгол Улсын 2017 оны төсөвт Засгийн газрын нөөц санг нийт 19.8 тэрбум төгрөг байхаар баталсан. Оны эхний 8 сарын байдлаар Засгийн газраас нийт 20.7 тэрбум төгрөгийн зардал арга хэмжээг санхүүжүүлэхээр шийдвэрлэж, үүнээс 16.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон байна.

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийн гүйцэтгэл өндөр гарахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураалтыг улс орон даяар зохион байгуулахад 7.2 тэрбум төгрөгийн санхүүжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна. Мөн оны эхний 8 сард байгалийн аюулт үзэгдэл болох ой, хээрийн гал түймэр, үер, хүчтэй мөндөр болон салхи шуурга болон мал, амьтны гоц халдварт өвчний улмаас үүссэн хохирлыг барагдуулах, гамшгийн голомтод ажилласан иргэд, албан хаагчидад хууль тогтоомжид заасны дагуу томилолт, урамшууллын зардлыг нөхөн олгоход зориулж нийт 6.9 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэх шаардлага үүсээд байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн Засгийн газрын нөөц санг 14.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг төсвийн тодотголд тусгаж байгаа бөгөөд үүний 6.9 тэрбум төгрөг нь 2016-2017 онд гарсан гамшиг осол, малын гоц халдварт өвчний хохирол арилгахад, 7.2 тэрбум

төгрөгийг он дуусталх хугацаанд учирч болзошгүй байгаль цаг агаарын болон бусад гэнэтийн эрсдэлийг даван туулахад зарцуулагдах болно.

Гурав. Хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах чиглэлээр

Монгол Улсын 2017 оны төсөв батлагдсанаас хойш хугацаанд төсвийн захирагчаас үл хамаарах шалтгааны улмаас боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага болон бусад төсөвт байгууллагад үүссэн урсгал зардлын өр төлбөрийг шийдвэрлэх шаардлага гарч байгаа тул дор дурьдсан зориулалтаар нийт 38.9 тэрбум төгрөгийн өр, төлбөрийг барагдуулахаар тодотголын төсөлд тусгалаа.

Хүснэгт № 16. Хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах арга хэмжээний товчоо /тэрбум төгрөг/

| # | Арга хэмжээ, зориулалт | Өөрчлөлт |
|-----------------|---|-------------|
| НИЙТ ДҮН | | 38.9 |
| 1 | Төсвийн байгууллагуудад үүссэн өр, төлбөрийг барагдуулах | 11.8 |
| | 1.1. Боловсролын салбарын байгууллагуудын өр төлбөрийг барагдуулах | 5.6 |
| | 1.2. Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын өр, төлбөрийг барагдуулах | 3.2 |
| | 1.3. Төсвийн бусад байгууллагад үүссэн өр төлбөрийг барагдуулах | 3.0 |
| 2 | Батлан хамгаалах салбарын зарим байгууллагуудын цалингийн зардал | 11.2 |
| 3 | Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолборын НӨАТ, гаалийн татварын болон зээлийн хүүгийн өглөгийг барагдуулах | 5.2 |
| 4 | Орон нутгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад олгох тэтгэмж | 6.8 |
| 5 | Нийгмийн даатгалын байгууллагуудын НДШ, Татварын өр төлбөр | 1.5 |
| 6 | Цагдаагийн алба хаагчдын цалингийн сангийн дутагдаж байгаа эх үүсвэр | 2.4 |

Зарим төсвийн байгууллагад үүссэн өр, төлбөрийг барагдуулах: Тухайлбал, Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу шинээр нээгдсэн хувийн цэцэрлэгт улсын төсвөөс олгох хувьсах зардал, төсөв батлагдсаны дараа орон нутгийн эрчим хүчний үнэ тарифыг зохицуулах зөвлөлийн шийдвэрээр нэмсэн түлш, халаалтын үнэ тариф, шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийн ашиглалтын зардал зэрэгээс шалтгаалж орон нутаг үйл ажиллагаа явуулж буй төсвийн байгууллагуудын өр төлбөрийг барагдуулахад нийт 8,615.9 сая төгрөгийг төсвийн тодотголд тусгахаар тооцлоо.

Өр төлбөр үүссэн шалтгааныг судлаж үзэхэд 13.1 хувь нь 2016 оны эцэст үүссэн өглөг, 86.8 хувь нь 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр үүсч буй өр, төлбөр байна. Өр үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж үзэхэд боловсрол, соёл, спорт болон эрүүл мэндийн салбарт хувийн хэвшил, орон нутгийн хөрөнгө оруулалтаар барьсан шинэ барилга байгууламж ашиглалтад орсноор нэмэгдэх урсгал зардалд 44.3 хувь, сумдад төвлөрсөн халаалтад холбогдсоны улмаас төсвийн байгууллагад үүсч тогтмол зардлын өр төлбөр 29.5 хувь, эрүүл мэндийн салбарт эмийн үнэ болон тоног төхөөрөмжийн шинэчлэгдсэний үр дүнд оношилгоо, шинжилгээний тоо хэмжээ нэмэгдсэнээр эмийн зардал нэмэгдсэнээс 16.3 хувь, 2015 онд УИХ-аас жилийн төсөв хэлэлцэн батлах үед цалин хөлсний зардлыг улсын хэмжээнд 1 хувиар, 2016 онд мөн 10 хувиар, мөн 2017 онд бүх төсөвт байгууллагын урсгал зардлыг 1.0 хувиар тус ту бууруулсан зэрэг шийдвэрээс улбаатай 5.1 хувь, бараа үйлчилгээний бусад зардлын өр төлбөр 4.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт № 17. Төсөвт байгууллагын өр төлбөр, байгууллагын төрлөөр, шалтгаанаар /тэрбум төгрөг/

| БАЙГУУЛЛАГА | Ирүүлсэн санал | 2017 ТОД-д тусгасан дүн | Өр, төлбөр үүссэн шалтгаан, үндэслэл: | | | | | |
|---|-----------------|-------------------------|---------------------------------------|------------------------------|------------------------------|----------------------|----------------------|--------------|
| | | | 2016 оны жилийн эцэст үүссэн өр | Шинэ объект ашиглалтад орсон | Төвлөрсөн халаалт, үнэ тариф | Үнэ ханшийн өөрчлөлт | Цалин 1 хувь буурсан | Бусад |
| НИЙТ ДҮН | 10,151.5 | 8,779.9 | 1,135.3 | 3,331.6 | 2,228.0 | 1,220.9 | 558.0 | 306.0 |
| 1.СӨБ* | 2,434.7 | 2,307.3 | | 2,270.7 | 36.6 | - | - | - |
| 2.ЕБС* | 2,366.5 | 2,114.5 | 239.6 | 425.1 | 1,449.9 | - | - | - |
| 3.Соёлын төв, номын сан | 569.0 | 554.5 | 46.6 | 89.4 | 418.5 | - | - | - |
| 4.Спорт заал, цогцолбор | 543.5 | 543.5 | - | 527.5 | - | 16 | - | - |
| 5.Аймгийн нэгдсэн эмнэлэг | 2,765.8 | 1,982.3 | 385.8 | - | 109.1 | 1,013.8 | 368.2 | 105.2 |
| 6.Аймгийн эрүүл мэндийн бусад байгууллага | 821.5 | 653.9 | 449 | - | - | 130.5 | 69.2 | 5.2 |
| 7.Сумын эрүүл мэндийн төв | 421.8 | 428.3 | 18.9 | - | 213.9 | 120.6 | - | - |
| 8.Аймгийн ЗДТГ | 228.7 | 195.6 | - | - | - | - | - | 195.6 |

* СӨБ – Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ЕБС- Ерөнхий боловсролын сургууль

Харин төсвийн сахилга, хариуцлага алдсан, орон тоо нэмэгдүүлж ажилласнаас үүссэн өр, төлбөрийг төсвийн тодотголд тусгахгүй байх зарчим баримталсан болно.

Батлан хамгаалах салбарт үүссэн зарим өр төлбөрийг барагдуулах: Батлан хамгаалахын сайдын 2017 оны төсвийн багцыг нийтдээ 16.4 тэрбум төгрөгөөр нэмж тодотгохоор тооцов. “Цогцолборыг шилжүүлэх, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх тухай” Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 8-ний өдрийн 48 дугаар тогтоолоор “Төрийн орон сууц корпораци” ТӨҮГ-ын импортлон оруулж ирсэн барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг барагдуулахад 3,145.5 сая төгрөг, зээлийн хүүгийн өглөгийг барагдуулахад 2,031.5 сая төгрөг нэмэгдүүлэн тусгав. Түүнчлэн Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын зарим байгууллагуудад өмнөх онд үүссэн татварын өглөгийг тооцож, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд зэвсэгт хүчний жанжин штабт 10,802.5 сая төгрөг, Цэргийн төв эмнэлэгт 184.0 сая төгрөг, Үндэсний батлан хамгаалахын их сургуульд 230.6 сая төгрөг тус тус шаардлагатай байгааг хянаж тусгалаа.

Орон нутгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад олгох тэтгэмж: Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “*Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 6 сарын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.*” гэж заасныг үндэслэн 2016 оны Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох тэтгэмжийг төсвийн тодотголд нийт 6,790.2 сая төгрөгөөр тусгалаа.

Хүснэгт № 18. Орон нутгийн сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмж (сая төгрөг)

| Аймаг | Тэтгэмжийн хэмжээ | | Нийт чөлөөлөгдсөн хүний тоо /2016 онд/ |
|-------------|-------------------|-----------------|--|
| | 2012 онд | 2016 онд | |
| НИЙТ | 5,125.4 | 6,790.24 | 1,786 |
| Архангай | 355.2 | 394.83 | 108 |
| Баян-Өлгий | 273.6 | 310.80 | 86 |
| Баянхонгор | 339.2 | 469.06 | 117 |
| Булган | 248.6 | 329.84 | 85 |
| Говь-Алтай | 268.9 | 419.83 | 115 |
| Дорноговь | 137.6 | 362.12 | 94 |
| Дорнод | 190.0 | 236.81 | 63 |
| Дундговь | 189.8 | 227.64 | 59 |
| Завхан | 656.5 | 679.47 | 181 |
| Өвөрхангай | 274.9 | 329.56 | 89 |
| Өмнөговь | 150.3 | 239.01 | 58 |
| Сүхбаатар | 218.8 | 282.55 | 72 |
| Сэлэнгэ | 95.6 | 303.82 | 72 |
| Төв | 229.5 | 401.49 | 102 |
| Увс | 367.9 | 514.92 | 140 |
| Ховд | 322.2 | 373.56 | 101 |
| Хөвсгөл | 429.9 | 368.03 | 102 |
| Хэнтий | 226.6 | 359.13 | 93 |
| Дархан-уул | 62.4 | 70.63 | 19 |
| Орхон | 75.1 | 45.13 | 11 |
| Говь сүмбэр | 12.9 | 72.00 | 19 |

Дөрөв. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хамрах хүрээний өргөжилтөөс үүдэлтэй зардлыг шийдвэрлэх чиглэлээр

Хот суурин газрын хүн амын өсөлт, нягтаршил, эрүүл мэндийн даатгалын хүртээмж нэмэгдсэн зэрэг шалтгааны улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт жил бүр өсөн нэмэгдэж байгаа нь эрүүл мэндийн салбарт хөрөнгө нэмж зарцуулах шаардлагыг бий болгож байна. Иймд 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, хэрэгцээг харгалзан эрүүл мэндийн үйлчилгээ хүргэдэг байгууллагуудад 18.3 тэрбум төгрөгийн урсгал зардлыг төсвийн тодотголд тусгалаа. Энэ хүрээнд өндөр өртөгтэй мэндийн мэс заслын хүлээгдэж байгаа хагалгааны тоо хэмжээний өсөлтийг санхүүжүүлэх зардал, элэгний С вирусын идэвхжил тодорхойлох шинжилгээний зардал зэргийг ЭМД-ын сангаас, Амгалан амаржих газар, Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлгийн үйлчилгээг өргөжүүлсэнтэй холбогдох урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээ багтаж байна.

Хүснэгт № 19. Эрүүл мэндийн салбарын арга хэмжээний товчоо /тэрбум төгрөг/

| # | Арга хэмжээ, зориулалт | Өөрчлөлт |
|-------------|--|-------------|
| НИЙТ | | 19.0 |
| 1. | Өндөр өртөгт мэс заслын зардлын болон тусламж үйлчилгээний хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн ЭМД-ыг сангаас санхүүжих зардлыг нэмэгдүүлэх. Үүнд: | 11.6 |
| | Өндөр өртөгт мэс заслын зардлын болон тусламж үйлчилгээ | 8.5 |
| | Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих эмнэлгийн бусад тусламж үйлчилгээ | 3.2 |
| 2. | Амгалан амаржих газар 50 ор нэмэгдүүлсэнтэй холбоотой зардал | 0.2 |

| | |
|---|-----|
| 3. Элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд нэмэгдэж буй зардал | 3.7 |
| 3. ТТАХНЭ-ийн хэвтүүлэн эмчлүүлэх хэсэг ашиглалтад орохтой холбоотойгоор шаардагдах урсгал зардал | 2.1 |
| 4. Эрхтэн шилжүүлэх мэс заслын зардал | 0.7 |
| 5. Цэргийн төв эмнэлгийн ТТАХНЭ-т шилжүүлсэн орон тоо, цалингийн сан | 0.7 |

Өндөр өртөгт мэс заслын зардлын болон тусламж үйлчилгээ: Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 9.1.6, 9.1.8-д зааснаар эрүүл мэндийн даатгалд хамаарах тусламж, үйлчилгээний багцад өртөг өндөр бүхий зарим тусламж, үйлчилгээ, түүнд шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх зарим төрлийн хиймэл эрхтэн, протезийн зардлыг үнийн тодорхой хэсгийг эрүүл мэндийн даатгалын сангаас 2015 оны 07 дугаар сарын 01-ээс эхлэн олгож эхэлсэн. Тухайлбал, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 248/161/А88 тоот хамтарсан тушаал, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор дээр дурдсан мэс засал, тэдгээрт хэрэглэгдэх эмнэлгийн хэрэгсэл, жишиг үнэ, даатгалаас төлөх төлбөрийн хэмжээ, зардлыг санхүүжүүлэх болон хяналт тавих журам зэргийг баталж хэрэгжүүлсэн.

Ингэснээр өндөр өртөгтэй мэс засалд хэрэглэгдэх 80 гаруй нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн 75 хүртэл хувийг Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцаж, энэ хэмжээгээр даатгуулагчийн санхүүгийн ачааллыг бууруулах алхам хийгдсэн. Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуулиар уг үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас 10.4 тэрбум төгрөг зарцуулж байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр батлагдсан төсөвт нийт 35.4 тэрбум төгрөг зарцуулахаар байна.

Хүснэгт № 20. Өндөр өртөгт мэс заслын тусламж үйлчилгээний зардал, ЭМ-ийн байгууллагаар

| № | Эрүүл мэндийн байгууллага | 2017 онд батлагдсан төсөв | | 2017 оны ХБГ нийт хагалгаа | | 2017 оны төсөвт тусгагдаагүй ХБ хагалгаа | |
|---|------------------------------------|---------------------------|-----------------|----------------------------|---------------|--|----------------|
| | | Хагалгааны тоо | Дүн | Хагалгааны тоо | Дүн | Хагалгааны тоо | Дүн |
| | ДҮН | 14,520 | 26,905.6 | 18,363 | 35,356 | 3,843 | 8,450.4 |
| 1 | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | 2,967 | 4,110.5 | 3,458 | 5,110.5 | 491 | 1,000.0 |
| 2 | Улсын гуравдугаар төв эмнэлэг | 4,449 | 9,340.6 | 6,478 | 13,940.5 | 2,029 | 4,599.9 |
| 3 | Гэмтэл согог судлалын үндэсний төв | 4,961 | 9,767.5 | 5,905 | 11,968.0 | 944 | 2,200.5 |
| 4 | Хавдар судлалын үндэсний төв | 2,143 | 3,687.0 | 2,522 | 4,337.0 | 379 | 650.0 |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

Монгол улсад анх удаа зүрхний хэм алдагдлын электрофизиологийн шинжилгээ, эмчилгээ, радио давтамжит катетраблаци эмчилгээ, тархины судсан дотуурх оношилгоо, эмчилгээ, үе болон эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааг өөрийн эх орондоо нутагшуулж Монгол хүн эх орондоо тусламж үйлчилгээ авах боломж, нөхцөлийг бүрдүүлэн иргэдийн эмнэлгийн зарим тусламж үйлчилгээг авахын тулд гадаад улс руу явах урсгалыг багасгах чухал ач холбогдолтой үйл ажиллагаа юм.

Үүнтэй уялдаж, эх орондоо өндөр өртөгтэй эмнэлгийн тусламж авах иргэдийн тоо, хэрэгцээ шаардлага нэмэгдэж, байгаатай холбоотойгоор мэс заслын тусламж үйлчилгээний зардлыг 2017 оны төсвийн тодотголын төсөлд **8,450.4 сая** төгрөгөөр нэмэгдүүлж төсөвлөлөө.

Хүснэгт № 21. Өндөр өртөгт мэс заслын тусламж үйлчилгээний төрөл, тоо хэмжээ, зардал /сая төгрөг/

| Эрүүл мэндийн байгууллага | № | Мэс заслын нэр | Хагалгааны тоо | 2017 онд батлагдсан төсөв | Нэгжийн үнэ | 2017 оны ХБГ | | 2017 онд нэмж шаардагдах | |
|---------------------------|-----------------|--|----------------|---------------------------|----------------|--------------|-----------------|--------------------------|----------------|
| | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| УГТЭ | 1 | Зүрхний гажгийн мэс засал | 156 | 508.4 | 3,259 | 236 | 769.2 | 80 | 260.7 |
| | 2 | Зүрхний ишемит өвчин | 1,643 | 2,749.7 | 1,674 | 2499 | 4,182.3 | 856 | 1,432.6 |
| | 3 | Зүрхний хэм алдагдах өвчин | 158 | 1,930.5 | 12,218 | 242 | 2,956.8 | 84 | 1,026.3 |
| | 4 | Зүрхний дутагдал | 3 | 38.4 | 12,791 | 7 | 89.5 | 4 | 51.2 |
| | 5 | Судасны эмгэгүүдийн үеийн мэс засал | 26 | 35.0 | 1,348 | 38 | 51.2 | 12 | 16.2 |
| | 6 | Тархи мэдрэлийн мэс засал | 634 | 560.2 | 884 | 950 | 839.3 | 316 | 279.2 |
| | 7 | Тархины судсан дотуур хийгдэх мэс засал | 551 | 2,200.6 | 3,994 | 841 | 3,358.8 | 290 | 1,158.2 |
| | 8 | Бүдүүн шулуун гэдэсний мэс засал | 37 | 47.2 | 1,276 | 55 | 70.2 | 18 | 23.0 |
| | 9 | Чих хамар хоолойн мэс засал | 18 | 10.6 | 587 | 30 | 17.6 | 12 | 7.0 |
| | 10 | Ерөнхий мэс засал | 594 | 396.4 | 667 | 795 | 530.6 | 201 | 134.1 |
| | 11 | Нүдний мэс засал | 579 | 804.5 | 1,389 | 709 | 985.1 | 130 | 180.6 |
| | 12 | Уян дурангийн мэс ажилбар | 50 | 59.2 | 1,183 | 76 | 90.0 | 26 | 30.9 |
| | Нийт дүн | | | 4,449 | 9,340.6 | - | 6478 | 13,940.6 | 2,029 |
| ГССҮТ | 1 | Өвдөгний хиймэл үе солих хагалгаа | 372 | 2,578.0 | 6,930 | 440 | 3,049.2 | 68 | 471.2 |
| | 2 | Түнхний хиймэл үе солих хагалгаа | 466 | 2,306.7 | 4,950 | 578 | 2,861.1 | 112 | 554.4 |
| | 3 | 2 туйлт хиймэл үе солих хагалгаа | 172 | 479.1 | 2,785 | 242 | 674.1 | 70 | 195.0 |
| | 4 | Мөрний хиймэл үе солих хагалгаа | 39 | 202.8 | 5,200 | 69 | 358.8 | 30 | 156.0 |
| | 5 | Үений дурангийн хагалгаа | 248 | 661.8 | 2,669 | 348 | 928.7 | 100 | 266.9 |
| | 6 | Бөөр давсаг уушгины язралт урагдалыг оёх хагалгаа, пневмоторакс | 170 | 41.0 | 241 | 224 | 54.1 | 54 | 13.0 |
| | 7 | Ясны гэмтлийн хагалгаа | 1,665 | 1,780.9 | 1,070 | 1915 | 2,048.3 | 250 | 267.4 |
| | 8 | Гэмтлийг шалгах боох сэтгүүрдэх залгаж оёх хиймэл судсаар орлуулах өөрийн судсаар нөхөн сэргээх хагалгаа | 25 | 36.1 | 1,443 | 37 | 53.4 | 12 | 17.3 |
| | 9 | Шөрмөс холбоосыг оёх шилжүүлэх нөхөн сэргээх хиймэл шөрмөс холбоос залгах | 20 | 95.4 | 4,770 | 30 | 143.1 | 10 | 47.7 |
| | 10 | Түлэгдсэн хөлдсөн арьсны үхжил хэсгийн мэс засал | 1,784 | 1,585.7 | 889 | 2022 | 1,796.8 | 238 | 211.0 |
| Нийт дүн | | | 4,961 | 9,767.5 | - | 5905 | 11,967.5 | 944 | 2,200.0 |
| ХСҮТ | 1 | Толгой хүзүүний мэс засал | 24 | 22.2 | 925 | 28 | 25.9 | 4 | 3.7 |

| | | | | | | | | | |
|-----------------|-------------|-------------------------------------|---------------|-----------------|----------------|---------------|-----------------|----------------|----------------|
| | 2 | Нарийн, бүдүүн гэдэсний мэс засал | 242 | 531.3 | 2,195 | 288 | 632.3 | 46 | 101.0 |
| | 3 | Бөөрний мэс засал | 83 | 165.2 | 1,990 | 102 | 203.0 | 19 | 37.8 |
| | 4 | Ходоодны мэс засал | 214 | 318.9 | 1,490 | 263 | 391.9 | 49 | 73.0 |
| | 5 | Уушги, голтын мэс засал | 100 | 269.0 | 2,690 | 116 | 312.0 | 16 | 43.0 |
| | 6 | Эмэгтэйчүүдийн мэс засал | 180 | 177.0 | 983 | 220 | 216.4 | 40 | 39.3 |
| | 7 | Элэг цөс, нойр булчирхайн мэс засал | 216 | 493.6 | 2,285 | 262 | 598.7 | 46 | 105.1 |
| | 8 | Уян дурангийн мэс ажилбар | 45 | 57.8 | 1,284 | 64 | 82.2 | 19 | 24.4 |
| | 9 | Дүрсийн хяналттай мэс ажилбар | 1,039 | 1,652.1 | 1,590 | 1179 | 1,874.7 | 140 | 222.6 |
| | Нийт | | | 2,143 | 3,687.0 | - | 2522 | 4,337.0 | 379 |
| УНТЭ | 1 | Зүрхний ишемит өвчин | 8 | 8.0 | 1,000 | 10 | 10.0 | 2 | 2.0 |
| | 2 | Зүрхний хэм алдагдах өвчин | 8 | 64.0 | 8,000 | 10 | 80.0 | 2 | 16.0 |
| | 3 | Тархи, мэдрэлийн мэс засал | 15 | 39.7 | 2,645 | 20 | 52.9 | 5 | 13.2 |
| | 4 | Бүдүүн, шулуун гэдэсний мэс засал | 154 | 130.9 | 850 | 190 | 161.5 | 36 | 30.6 |
| | 5 | Бөөрний мэс засал | 1,310 | 377.5 | 288 | 1437 | 414.1 | 127 | 36.6 |
| | 6 | Гэмтэл, бэртлийн мэс засал | 438 | 2,631.4 | 6,008 | 548 | 3,292.3 | 110 | 660.9 |
| | 7 | Ерөнхий мэс засал | 782 | 157.2 | 201 | 932 | 187.3 | 150 | 30.1 |
| | 8 | Нүдний мэс засал | 190 | 152.0 | 800 | 230 | 184.0 | 40 | 32.0 |
| | 9 | Уян дурангийн мэс ажилбар | 22 | 2.5 | 116 | 28 | 3.2 | 6 | 0.7 |
| | 10 | Эрхтэн шилжүүлэн суулгах | 40 | 547.3 | 13,683 | 53 | 725.2 | 13 | 177.9 |
| Нийт | | | 2,967 | 4,110.5 | - | 3458 | 5,110.5 | 491 | 1,000.0 |
| НИЙТ ДҮН | | | 14,520 | 26,905.6 | - | 18,363 | 35,355.7 | 3,843 | 8,450.0 |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих эмнэлгийн бусад тусламж үйлчилгээ:
 Эмнэлгийн тусламж үйлчилгээ оны эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдэж байгааг харгалзан Улсын 1 дүгээр төв эмнэлэгт 703.2 сая төгрөг, Улсын гуравдугаар нэгдсэн эмнэлэгт 150.0 сая төгрөг, Гэмтэл согог судлалын үндэсний төвд 846.8 сая төгрөг, Халдвар судлалын үндэсний төвд 150.0 сая төгрөг, Дорноговь, Сэлэнгэ, Төв, Булган, Дорнод, Увс зэрэг аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд нийт 1,060.0 сая төгрөгийн зардал нийт 3.150.0 сая төгрөгийн эмчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр тооцож тодотголын төсөлд тусгалаа.

Хүснэгт № 22. Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих тусламж үйлчилгээний хэрэгцээ /сая төгрөг/

| Байгууллага | Б-лагын тоо | 2017 оны батлагдсан төсөв | Нэгж тусламж үйлчилгээний өртөг | 2017 оны ХБГ | | Зөрүү | |
|------------------------------|-------------|---------------------------|---------------------------------|--------------------------|-----------------|--------------------------|----------------|
| | | | | Тусламж үйлчилгээний тоо | Зардал | Тусламж үйлчилгээний тоо | Зардал |
| НИЙТ | 13 | 57,534.8 | 4,200 | 202,283 | 60,684.8 | 10,500 | 3,150.0 |
| Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг | 4 | 32,193.7 | 1,200 | 113,479 | 34,043.7 | 6,167 | 1,850.0 |
| Аймгийн нэгдсэн эмнэлэг | 6 | 18,124.1 | 2,100 | 63,947 | 19,184.1 | 3,533 | 1,060.0 |
| Дүүргийн эмнэлэг | 3 | 7,216.9 | 900 | 24,856 | 7,456.9 | 800 | 240.0 |

Мөн Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвд мэс заслын тасгийг шинээр ажиллуулах шийдвэр гарч үйл ажиллагаа нь эхэлсэнтэй холбогдуулан нэмж шаардагдах 200.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр тусгалаа.

Нийслэлийн “Амгалан” амаржих газрын үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ: Нийслэлийн “Амгалан” амаржих газар үйлчлүүлэх иргэдийн ачаалал нэмэгдэж, эмнэлгийн орны хүрэлцээ багассантай холбогдуулан орны тоог 10 дугаар сараас эхлэн 50-иар нэмэгдүүлэн ажиллуулахад шаардагдах үйл ажиллагааны урсгал зардалд 180.6 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгав.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт нэмж шаардагдах зардлыг тусгана: Элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамрагдах иргэдийн тоо нэмэгдэж байна. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн мэдээллийн санд бүртгэгдсэнээр 2017 оны 08 дугаар сарын 17-ны байдлаар нийт 44.7 мянган даатгуулагч шинжилгээнд хамрагдаад байгаа бөгөөд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 5,450.0 сая төгрөг зарцуулагдахаар байна. Иймд энэхүү хөтөлбөрийн үр дүнг сайжруулах зорилгоор 3.7 тэрбум² төгрөгийг шинжилгээний зардалд нэмж тусгалаа.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааг тогтворжуулж, хэвийн үйл ажиллагааг хангана: Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн хэвтүүлэн эмчлүүлэх хэсэг 2017 оны 9 сард ашиглалтад орж, үйл ажиллагаагаа явуулж эхлэхтэй холбогдуулан орон тоог нэмэгдүүлэхгүйгээр эмч, сувилагч нарыг илүү цагаар ажиллуулах, үйлчилгээний ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр тооцож, 58 эмч, сувилагч нарыг илүү цагаар ажиллуулах цалингийн зардал, улсын мэдээллийн маягт, бичиг хэрэг, шуудан холбоо, нормын хувцас, багаж хэрэгсэл, тавилга /өвчтөний ор, тумбочка/, тээвэр шатахуун, эмнэлгийн цахим мэдээллийн систем худалдан авах, урсгал засвар, хөдөлмөр хамгаалал, өвчтөний хоолны зардал, эмнэлгийн өргөтгөлийг ашиглалтад оруулах үед Улсын нэгдүгээр төв эмнэлэг болон ТТАХНЭ-ийн хооронд үүссэн өглөгийг барагдуулах зэрэгт нийт 2,090.9 сая төгрөгийг нэмэгдүүлэн тусгав.

Тав. Шүүхийн шийдвэрийн дагуу олгох нөхөн олговор

Шүүхийн шийдвэрийн дагуу төрийн байгууллага, албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас³ иргэд, аж ахуйн нэгжид олгох нөхөн төлбөрийн өр барагдуулахад зориулж нийт 25,711.9 сая төгрөг, үүнээс 8,817.8 сая төгрөгийг урсгал зардалд тусган олгохоор тооцлоо. Харин төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө оруулалтын төсөл

² “Нэмэлт санхүүжилт хүсэх тухай” Эрүүл мэндийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 1а/3229 дугаар албан бичгээр нийт 3.7 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцоо ирүүлсэн болно.

³ Иргэний хуулийн 498.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана.”, мөн хуулийн 498.4-т “Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг мөрдөгч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана.” гэж заасан байна.

арга хэмжээг хэрэгжүүлсний улмаас үүссэн хохирлыг хөрөнгө оруулалтын зардалд тусгахаар тогтов.

Хүснэгт № 23. Шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс олгох төлбөр-урсгал зардал /сая төгрөг/

| # | Шалтгаан | Олгох төлбөр | Эзлэх хувь | Төлбөр хүлээн авагч этгээд | | |
|---|---|----------------|-------------|----------------------------|----------------|--------------|
| | | | | Иргэд | Компани | *Бусад |
| НИЙТ ДҮН | | 8,817.8 | 100% | 2,679.5 | 5,323.1 | 815.2 |
| 1. | Ажлаас үндэслэлгүйгээр халагдсаны улмаас олгох хохирлын нөхөн төлбөр | 1,282.2 | 14.5% | 1,281.9 | - | 0.3 |
| 2. | Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд алдаа гаргасны улмаас бусдад учруулсан хохирол | 4,365.8 | 49.5% | 405.7 | 3,931.8 | 28.3 |
| 3. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учруулсан хохирол | 293.8 | 3.3% | 293.8 | - | - |
| 4. | Хууль тогтоомжийн дагуу олгох ёстой байснаас олгогдоогүй тэтгэмж, зардал | 31.6 | 0.4% | 31.6 | - | - |
| 5. | Гэрээний үүрэг биелүүлээгүйгээс бий болсон хохирол | 2,844.4 | 32.3% | 666.5 | 1,391.3 | 786.6 |
| Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо | | 277 | | 214 | 45 | 18 |

Нийт төлбөрийн 14.5 хувь нь ажлаас үндэслэлгүй халах шийдвэр гаргасны улмаас, 49.5 хувь нь төрийн албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад алдаа гаргасны улмаас, 32.3 хувь нь гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан байна. Хохирлын хэмжээг мөнгөн дүнгээр авч үзвэл 30.4 хувь нь иргэд, 60.4 хувь нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, 9.2 хувь нь төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагууд байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийг хэрхэн шийдвэрлэгдсэн байдлыг судалж үзвэл нийт хэргийн 89.0 хувь буюу 7,853.1 сая төгрөгийн хохирлыг анхан шатны шүүхээр, 2 хувь буюу 170.2 сая төгрөгийг давах шатны, 9 хувь буюу 794.5 сая төгрөгийг хяналтын шатны шүүхээр тус тус шийдвэрлүүлсэн байна.

Шүүхийн шийдвэртэй, нэг удаагийн шинж чанартай өр төлбөрийг барагдуулахтай холбогдуулан төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналтыг сайжруулах, төрийг шүүхэд төлөөлж буй этгээд тухайн хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх давах, хянах зэрэг бүх шатны шүүхэд хуульд заасан нөхцөл журмын дагуу оролцох, цаашид шүүхийн шийдвэртэй, нэг удаагийн шинж чанартай өр төлбөрийг бууруулах талаар санал боловсруулах зэрэг шат дараалсан арга хэмжээ авахаар төлөвлөж байна. Үүнд:

1. Төрийн албан хаагч ажлын хариуцлага алдсан, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсаны улмаас шүүхийн шийдвэрийн дагуу олгох нөхөн олговрын зохих хэсгийг тухай албан тушаалтнаар төлүүлдэг байх;
2. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтны гаргасан буруутай шийдвэрийн хохирлыг улсын болон орон нутгийн төсвөөс бус тухайн албан тушаалтан эсхүл компаниар нь төлүүлдэг байх;

3. Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг шүүхэд төрийн нэрийн өмнөөс нэхэмжлэх байгууллагыг хуулиар тодорхой зааж, хохирол барагдуулах процесст оролцох чиг үүргийг нь тодорхой болгох зэрэг болно.

Зургаа. Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх болон бусад арга хэмжээ

ЖДҮХСанд 2012 оноос хойш давхардсан тоогоор нийт 1,818.4 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэр хүссэн 5,482 төсөл ирснээс нийт эрэлтийн 12% буюу 1,299 төсөлд 220.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Өнгөрсөн 2016 оны 11 дүгээр сарын байдлаар 704 аж ахуйн нэгж иргэн 494.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн төсөл ирүүлсэн боловч төсвийн хөрөнгийн боломжид багтаан зохих шалгуур хангасан 199 иргэн, хуулийн этгээдэд 79,7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна. Цаашид эдийн засгийн хямралыг даван туулах, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд ажлын байрыг хадгалах, шинээр бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээлийн хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

Иймд 2017 оны төсвийн тодотголын төсөлд Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэлтийн санг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвөөс 72.6 тэрбум төгрөгийг нэмж олгохоор төсөвлөлөө.

Мөн Иргэдийн гадаад паспортын хэрэгцээ шаардлага өссөний улмаас нэмж шаардагдаж буй үндэсний энгийн гадаад паспортын 70,000 ш бэлдцээс 26,500 ширхгийн зардалд 288.6 сая төгрөгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад зохицуулалт хийх замаар шийдвэрлэж, 43,500 ширхэг бэлдцийн зардалд 474.4 сая төгрөгийг төсөвт нэмж тусгав.

Долоо. Зардал бууруулах санал

2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр төсвийн орлогын давсан хэсгийг хуримтлал үүсгэх буюу шинээр гаргах өрийн хэмжээг бууруулах, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд ашиглах, мөн ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд бага хүүтэй эх үүсвэр бүрдүүлэх зэргээр зээлийн үйлчилгээний төлбөрийг бууруулахаар ОУВС-ийн хөтөлбөрийн үнэлгээний хүрээнд тохирсоны дагуу 45.1 тэрбум төгрөг бууруулахаар төсөвлөв.

Найм. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөвт хийх зарим зохицуулалт

Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангах зарчимд нийцүүлэн төсвийн 2017 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл, салбарын яамдаас бодлого, хөтөлбөрөө хэрэгжүүлэх бодит хэрэгцээ, шаардлага байгааг харгалзан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын батлагдсан төсөвт зарим зохицуулалтын шинжтэй өөрчлөлтийг төсвийн тодотголд тусгахаар тооцсон болно.

| Арга хэмжээ, зориулалт | | Өөрчлөлт |
|------------------------|--|--------------|
| НИЙТ | | -31.5 |
| ХНХЯ | НДС-ын жирэмсэн амаржсаны тэтгэмж | -7.2 |
| | НДС-ын ажилгүйдлийн тэтгэмж | 5.7 |
| БСШУЯ | Боловсролын зээлийн сангийн оюутны хөгжлийн зээлийг 2017 оны төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн бууруулах | -34.0 |
| | Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламжийн арга, хэмжээний зардлыг 2016-2017 оны хичээлийн жилийн гүйцэтгэлд үндэслэн нэмэгдүүлэх | 4.0 |
| | Хууль зүйн сайдын багцын урсгал зардлыг бууруулж, мөн хэмжээгээр хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлж дор дурдсан зориулалтаар тоног төхөөрөмж худалдан авах. | -4.6 |
| ХЗДХЯ | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, автомашины зардал | 3.0 |
| | ТТАХНЭ-ийн хэвтүүлэн эмчлүүлэх хэсэг ашиглалтад орохтой холбоотойгоор эмчилгээ үйлчилгээ явуулахад шаардагдах эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, багаж, хэрэгслийн зардал /ТТАХНЭ-ийн хөрөнгө оруулалтын зардалд тусгах/ | 1.6 |
| СЯ | Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах | -1.6 |
| | Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн ХО дээр тусгасан зардлыг бууруулж, урсгал зардалд тусгах | 1.6 |

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж болон Ажилгүйдлийн тэтгэмж хооронд хийх зохицуулалт: Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн жилийн эцсийн тайлан, сарын мэдээ, судалгаа зэргээс сүүлийн 2 жилд ажилгүйдлийн тэтгэмж авах даатгуулагчдын тоо төлөвлөснөөс харьцангуй хурдацтай нэмэгдэж байна. Тухайлбал, тэтгэмж авагчдын тоо 2015 онд 18.7 мянга байсан бол 2016 онд 23.2 мянгад хүрч өссөн, 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 24.3 мянгад хүрэх төлөвтэй байна Энэ нь эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл, байдалтай холбоотой байна. Иймд ажилгүйдлийн тэтгэмжийн зардлын 2017 оны төсвийг 5.7 тэрбум төгрөгөөр нэмж тодотгох шаардлагатай байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаанаас үзэхэд төрсөн эхчүүдийн тоо 2014 онд 80.0 мянга, 2015 онд 80.4 мянган хүнд хүрч нэмэгдсэн боловч 2016 онд 77.6 мянга болж буурсан, 2017 онд мөн буурахаар байна. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжид 2017 оны эхний хагас жилийн байдлаар 40.8 тэрбум төгрөг олгохоос 32.8 тэрбум төгрөг олгож, сангийн зарлага хэмнэлттэй байгаа тул тэтгэмжийн даатгалын сангийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн зардлын төсвийг 7.3 тэрбум төгрөгөөр бууруулж, ажилгүйдлийн тэтгэмжийн зардлын төсвийг 5.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх зохицуулалт хийхээр тусгалаа.

Боловсролын зээлийн сангийн төсөвт хийх зохицуулалт: “Боловсролын зээлийн сан байгуулах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 111 дүгээр тогтоол, “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын дагуу одоогийн байдлаар дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа нийгмийн халамж, туслалцаа

зайлшгүй шаардлагатай оюутанд, түүнчлэн нэг өрхийн 3 болон түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын зэргийн боловсрол эзэмшихээр зэрэг суралцаж байгаа тохиолдолд 1 хүүхдийн сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийг төрөөс олгох зохицуулалттай байна. Боловсролын зээлийн санд дээрх нөхцөлийг хангасан буцалтгүй тусламжид хамрагдах хүсэлтэй оюутны тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4.0 тэрбум төгрөгийн өглөг үүсэхээр байна. Иймд Боловсролын зээлийн сангийн 2017 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр хэмнэлт үүсэж байгаа оюутны хөгжлийн зээлээс 4.0 тэрбум төгрөгийг буцалтгүй тусламжийн зардалд шилжүүлэхээр тооцож төсвийн тодотголын төсөлд тусгалаа. Зээл олголтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж үзэхэд зээлийн эрэлт, банкны шаардлага хангах байдал зэргээс шалтгаалж хөтөлбөр анх эхлэх үед төлөвлөж байсан зээлийн эх үүсвэр 30.0 орчим тэрбум төгрөгөөр хэмнэгдэхээр байгааг харгалзан мөн хэмжээгээр бууруулах тодотгол хийхээр тусгалаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцын зохицуулалт:

Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хар тамхи, мансууруулах бодис, тэсэрч дэлбэрэх бодис, химийн бодисыг илрүүлэх тоног төхөөрөмж, автобус, албаны нохойн зардалд 3.0 тэрбум төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн яамны урсгал зардлаас хөрөнгийн зардалд шилжүүлэн тусгалаа.

Мөн Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн хэвтүүлэн эмчлүүлэх хэсгийн Б блокны барилга ашиглалтад орохтой холбогдуулан эмчилгээ, үйлчилгээ явуулахад нэн тэргүүний ээлжид шаардагдах эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нийт 1.6 тэрбум төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн яамны урсгал зардлаас хөрөнгө оруулалтын зардалд шилжүүлэн тусгалаа.

Хөгжлийн хөтөч-дэд бүтцийн төслийн хөрөнгийн болон урсгал зардлын хооронд хийх зохицуулалт:

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, Улаанбаатар хот, аймаг, томоохон суурин газрын дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор шинээр өөрчлөн байгуулагдсан “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” (хуучнаар “Гудамж” төсөл) төсөл 2017 оны 4 дүгээр сард УИХ-аар батлагдсан төсвийн тодотголоор Хөгжлийн банкнаас Сангийн сайдын төсвийн багцад хөрөнгийн зардалд шилжиж ирсэн. Гэвч уг төслийн зардлын дийлэнх хувь нь төслийн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх шинж чанартай тул хэрэгцээ шаардлагыг үндэслэн 1.6 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардлаас бууруулж урсгал зардалд шилжүүлэхээр төсөлд тусгалаа.

3.2.4. Төсвийн хөрөнгө оруулалтын тодотголын тухай

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар 563.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр батлагдсан бол энэ оны

төсвийн орлогын биелэлт, гүйцэтгэлтэй уялдуулан өргөн барьж буй хуулийн төсөлд 290.8 тэрбум төгрөгийг нэмж тусгаад байна.

Хүснэгт № 24. Төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын товчоо /тэрбум төгрөг/

| Д/д | Хөрөнгө оруулалтын ангилал | УИХ-аас баталсан | | 2017 ТОД 2 төсөл | | ӨӨРЧЛӨЛТ |
|-----|--------------------------------|---------------------------|---------------|---------------------------|---------------|--------------|
| | | төсөл, арга хэмжээний тоо | санхүүжих дүн | төсөл, арга хэмжээний тоо | санхүүжих дүн | |
| 1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалт | 342 | 492.9 | 381 | 644.3 | 151.4 |
| 2 | Концессын эргэн төлөлт | 12 | 70.9 | 19 | 210.3 | 139.4 |
| | НИЙТ | 354 | 563.8 | 400 | 854.6 | 290.8 |

Хөрөнгө оруулалт нь төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зарчмыг хангахын зэрэгцээ ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд макро эдийн засгийн тооцоолол, төсвийн орлого, зарлага, алдагдлын тооцоонд суурилсан хөрөнгө оруулалтын зардлын хэмжээг тус тус харгалзан үзлээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өөрчлөлтийг дараах байдлаар тусгалаа. Үүнд:

1. Засгийн газрын хөрөнгө оруулалтын дотоод өр төлбөрийг барагдуулах нэг удаагийн арга хэмжээ авах;
2. УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолд зааснаар өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн, 2016 онд санхүүжилт нь бүрэн олгогдоогүй зарим төсөл, арга хэмжээнд шаардагдах үлдэгдэл санхүүжилтийг тусгах;
3. Шинээр батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад зайлшгүй шаардлагатай зарим хөрөнгө оруулалтыг тусгах;
4. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр батлагдсан зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тэдгээрийн гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг бууруулж 2018 онд шилжүүлэх;
5. Өвөлжилтийн бэлтгэл, цаг үеийн шинжтэй Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх зарим ажлыг нэмж тусгах;

Дээрх зарчим, тооцооллын дагуу хөрөнгө оруулалтын зардалд дараах өөрчлөлт орохоор байна.

1. Улсын төсөв

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжсэн төслийн гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг 2018 онд шилжүүлсэн нийт 29.4 тэрбум төгрөг байна. Түүнчлэн, гадаадын зээл тусламжаар 2017 онд шинээр хэрэгжиж эхлэх төсөл, арга хэмжээний Монголын талын хариуцах 8.8 тэрбум төгрөг, шүүхийн шийдвэртэй буюу Засгийн газрын тогтоол шийдвэрийн дагуу төлөгдөх хөрөнгө оруулалтын шинжтэй дотоод өр төлбөрийг барагдуулах нэг удаагийн 57.9 тэрбум төгрөгийн төлбөр,

өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгын хүрээнд эрчим хүч, эрүүл мэнд, барилга, хот байгуулалт, зам, тээврийн салбарт 85.4 тэрбум төгрөг, шинээр батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон эрүүл мэнд, нийгмийн салбарт зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмж зэрэгт 49.8 тэрбум төгрөгийг тус тус нэмэгдүүлж улсын төсвийн нийт хөрөнгө оруулалт 644.3 тэрбум төгрөг болсон байна.

2. Концессын эргэн төлөлт

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгагдаж “барих-шилжүүлэх” концессын гэрээгээр хэрэгжсэн нийт 12 төслийн эргэн төлөлтөд 70.9 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд барилга угсралтын ажил нь бүрэн дууссан төслүүдийн гэрээний дагуу олгох санхүүжилтийг нэмж, нийт 210.3 тэрбум төгрөг болохоор тооцож тусгалаа.

Концессын “барих-шилжүүлэх” гэрээгээр 2017 онд зам, тээврийн салбарт “Алтай-Дарви чиглэлийн 263 км хатуу хучилттай авто зам”, “Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам” төслийн хүрээнд нийт 285.2 км авто замыг ашиглалтад оруулаад байна. Мөн Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгонд Хараа голын 72.8 м төмөр бетон гүүр, Хөвсгөл аймгийн Галт сумын Идэр голын хөвдөг гүүрний 90 м байгууламжийг тус тус ашиглалт орууллаа.

Түүнчлэн, Улаанбаатар хотод 4 сургууль, аймаг орон нутагт 7 цэцэрлэгийн барилгын төсөл, арга хэмжээ хэрэгжихээс Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургууль, Баянгол дүүргийн 73 дугаар сургуулийн барилга бүрэн ашиглалтад орсон байна. Мөн, Хан-Уул дүүргийн 32 дугаар сургууль, 38 дугаар сургуулийн барилга 70-90 хувийн гүйцэтгэлтэй 2017 онд багтан ашиглалтад орох төлөвлөгөөтэй байна. Баянхонгор, Хөвсгөл, Дархан-Уул аймгуудад 7 цэцэрлэгийн барилга төлөвлөгдсөнөөс 4 барилга ашиглалтад орж үлдсэн 3 барилга энэ ондоо багтан ашиглалтад орно.

3.2.5. Гадаад зээлийн ашиглалт, эргэж төлөгдөх цэвэр зээл болон бусад зардлууд

Монгол Улсын Засгийн газар 2017 оны төсвийн жилд гадаад орон, олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нийт 878.6 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бол тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд 75.7 тэрбум төгрөгийн ашиглалт гарахаар байна.

Хүснэгт № 25. Гадаад зээлийн хөрөнгийн ашиглалт /сая төгрөг/

| ГАДААД ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ | 878,585.2 |
|---|-----------|
| 1. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга | 5,215.8 |
| 2. Сангийн сайд | 86,554.4 |
| 3. Эрүүл мэндийн сайд | 28,160.4 |
| 4. Орон нутгийн засаг захиргаа | 47,692.4 |
| 5. Монгол улсын шадар сайд | 1,350.8 |
| 6. Хууль зүй, дотоод хэргийн сайд | 14.1 |
| 7. Барилга, хот байгуулалтын сайд | 23,659.7 |
| 8. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд | 71,392.1 |

| | |
|--|-----------|
| 9.Зам, тээврийн хөгжлийн сайд | 498,437.9 |
| 10.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | 5,507.6 |
| 11.Эрчим хүчний сайд | 101,223.9 |
| 12.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 9,376.1 |

Хүснэгт № 26. Гадаад тусламжийн хөрөнгийн ашиглалт /сая төгрөг/

| ГАДААДЫН ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ | 75,732.7 |
|--|-----------------|
| Монгол улсын их хурлын дарга | 2,717.8 |
| Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга | 753.0 |
| Гадаад харилцааны сайд | 777.1 |
| Сангийн сайд | 9,796.9 |
| Эрүүл мэндийн сайд | 11,253.3 |
| Монгол улсын ерөнхий аудитор | 720.9 |
| Үндэсний статистикийн хорооны дарга | 979.6 |
| Орон нутгийн засаг захиргаа | 1,247.0 |
| Монгол улсын шадар сайд | 2,080.9 |
| Авлигатай тэмцэх газрын дарга | 105.8 |
| Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | 14,096.4 |
| Барилга, хот байгуулалтын сайд | 819.4 |
| Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд | 5,003.4 |
| Зам, тээврийн хөгжлийн сайд | 1,004.3 |
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | 1,352.3 |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | 8,880.1 |
| Эрчим хүчний сайд | 3,065.9 |
| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 11,078.9 |

4. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

Орон нутагт сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох нөхөн олговор, өвс тэжээлийн нөөц, хоол тэжээлийн тусламж зэрэг арга хэмжээний үр дүнд 2017 оны төсвийн тодотголоор суурь зарлага 18.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа бөгөөд үүний үр дүнд санхүүгийн дэмжлэг батлагдсанаас 11.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Хүснэгт № 27. Аймгуудын санхүүгийн дэмжлэг /сая төгрөг/

| Аймаг | 2017 год-1 | 2017 Тод-2 | Зөрүү |
|---------------------|-----------------------|-----------------------|-----------------|
| 1 Архангай | 11,706.1 | 12,501.8 | 795.7 |
| 2 Баян-Өлгий | 10,646.2 | 11,934.4 | 1,288.2 |
| 3 Баянхонгор | 11,082.6 | 12,027.3 | 944.7 |
| 4 Говь-Алтай | 8,170.0 | 8,877.5 | 707.5 |
| 5 Дорнод | 2,497.5 | 3,009.4 | 511.9 |
| 6 Дундговь | 5,719.0 | 6,138.1 | 419.1 |
| 7 Завхан | 9,356.2 | 10,369.2 | 1,013.1 |
| 8 Өвөрхангай | 11,415.4 | 12,214.7 | 799.3 |
| 9 Сүхбаатар | 5,086.5 | 5,658.7 | 572.2 |
| 10 Сэлэнгэ | 3,041.5 | 3,612.9 | 571.4 |
| 11 Төв | 7,568.7 | 8,529.4 | 960.7 |
| 12 Увс | 11,071.4 | 12,148.2 | 1,076.7 |
| 13 Ховд | 7,725.5 | 8,517.2 | 791.7 |
| 14 Хөвсгөл | 17,661.4 | 18,341.5 | 680.1 |
| 15 Хэнтий | 8,435.7 | 9,097.0 | 661.3 |
| Нийт | 131,183.7 | 142,977.4 | 11,793.7 |

Мөн Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу үндсэн тэнцлийн ашигтай аймгуудын хувьд үндсэн тэнцлийн ашгаасаа Улсын төсөвт төвлөрүүлэх дүн 8.3 тэрбум төгрөгөөр буурч орон нутгаас нийт дүнгээрээ 198.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тус тус тооцогдлоо.

Хүснэгт № 28. Орон нутгийн төсвөөс Улсын төсөвт төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

| Аймаг | 2017 год-1 | 2017 Тод-2 | Зөрүү |
|---------------|------------------|------------------|-----------------|
| 1 Булган | 692.4 | 367.8 | -324.6 |
| 2 Дорноговь | 1,103.5 | 889.4 | -214.1 |
| 3 Өмнөговь | 30,204.0 | 29,493.3 | -710.7 |
| 4 Дархан-Уул | 408.1 | 328.5 | -79.5 |
| 5 Улаанбаатар | 159,705.5 | 153,089.7 | -6,615.9 |
| 6 Орхон | 13,971.7 | 13,632.3 | -339.4 |
| 7 Говь-Сүмбэр | 223.2 | 176.9 | -46.3 |
| Нийт | 206,308.3 | 197,977.9 | -8,330.5 |

5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны тодотголоор нийгмийн даатгалын сангийн нийт орлого 1,467.9 тэрбум төгрөг, нийт зарлага 1,907.1 тэрбум төгрөг, төрөөс тэтгэврийн даатгалын санд олгох татаасны хэмжээ тэтгэврийн даатгалын сангийн орлого нэмэгдэж алдагдал буурснаас шалтгаалан 17 тэрбум төгрөгөөр буурч 570.2 тэрбум төгрөг байхаар тооцов.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2017 оны төсөвт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага дараах хүчин зүйлсийн нөлөөллөөр үүсэж байна.

Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангийн орлогын талаар:

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нийгмийн даатгалын санд 1,412.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 1,891.8 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд зарцуулахаар баталсан.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар 40.3 мянган аж ахуйн нэгж, байгууллага, 694.7 мянган даатгуулагч албан журмын даатгалд, 171.3 мянган даатгуулагч сайн дурын даатгалд, 1,899.6 мянган иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан нь урд оны мөн үетэй харьцуулахад даатгуулагчдын тоо 3.0 хувиар, Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаанаас үзэхэд ажиллагчдын дундаж цалин 959.0 мянган төгрөгт хүрч 7.0 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Эхний хагас жилд нийгмийн даатгалын санд төлөвлөсөн орлогын 50.6 хувийг буюу 715.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь энэ оны эцэст сангийн орлого 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 11.3 хувиар өсөхөөр байна.

Нийгмийн даатгалын хамрах хүрээ нэмэгдэн орлого өссөнөөр сангийн 2017 оны урьдчилсан гүйцэтгэл нь батлагдсан орлогын төсвөөс 55.3 тэрбум төгрөгөөр давж 1,467.9 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

2. Ажилгүйдлийн тэтгэмжийн талаар:

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн жилийн эцсийн тайлан, сарын мэдээ, эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудаас ирүүлсэн санал, судалгаанаас үзэхэд ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжид 2017 онд 29.6 тэрбум төгрөг зарцуулахаас эхний 6 сарын байдлаар 63.5 хувийг зарцуулаад байна.

Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл, байдлын улмаас ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 2015 онд 18.7 мянга байсан бол 2016 онд 23.2 мянгад хүрч өссөн, 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 24.3 мянгад хүрэх төлөвтэй байна. Иймд ажилгүйдлийн тэтгэмжийн зардлын 2017 оны төсвийг 5.7 тэрбум төгрөгөөр нэмж тодотгох шаардлагатай байна.

Харин Үндэсний статистикийн хорооны судалгаанаас үзэхэд төрсөн эхчүүдийн тоо 2014 онд 80.0 мянга, 2015 онд 80.4 мянган хүнд хүрч нэмэгдсэн боловч 2016 онд 77.6 мянга болж буурсан, 2017 онд мөн буурахаар байна.

Иймд тэтгэмжийн даатгалын сангаас олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжид 2017 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 40.8 тэрбум төгрөг олгохоос 32.8 тэрбум төгрөг олгож, сангийн зарлага хэмнэлттэй байгаа тул тэтгэмжийн даатгалын сангийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн зардлын төсвийг 7.3 тэрбум төгрөгөөр бууруулж, ажилгүйдлийн тэтгэмжийн зардлын төсвийг 5.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн зохицуулалт хийсэн.

3. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийн талаар:

Нийгмийн даатгалын үйлчилгээний хамрах хүрээ жил бүр өсөн нэмэгдсээр байна. Тухайлбал, нийгмийн даатгалд 2012 онд 30.5 мянган ажил олгогч, 2.3 сая даатгуулагч хамрагдан 800.0 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, сангаас 918.7 тэрбум төгрөг зарцуулсан бол 2017 онд 43.1 мянган ажил олгогч, 3.0 орчим сая даатгуулагч хамрагдан сангийн орлого 1,412.6 тэрбум төгрөгт хүрч 2012 онтой харьцуулахад 1.6 дахин, сангийн зарлага 1,891.8 тэрбум төгрөгт хүрч 1.9 дахин нэмэгдсэн байна.

Харин нийгмийн даатгалын сангийн 2016, 2017 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын ажилтан, албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн төсвийг 2016 онд 2015 оны батлагдсан төсвөөс 871.3 сая төгрөгөөр, 2017 онд 2016 оны батлагдсан төсвөөс 205.9 сая төгрөгөөр, нийт дүнгээр 1,077.2 сая төгрөгөөр бууруулан баталсан.

Ингэснээр эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын хэмжээнд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 503.0 сая төгрөгийн цалин, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй гарсан бөгөөд 2017 оны 06 дугаар сарын 31-ний байдлаар энэхүү өглөг 1,072.8 сая төгрөгт хүрч, энэ оны эцэст хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,575.4 сая төгрөгт хүрэхээр байна.

Нийгмийн даатгалын хамрах хүрээ, үйлчилгээний нэр төрөл жил бүр өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын ажилтан, албан хаагчдын ажлын ачаалал нэмэгдэж, нэг ажилтанд тогтоосон норм, норматив хэтэрч байгаа үед цалингийн сангийн төсвийг нэмэхгүй бууруулснаас иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэхэд хүндрэл үүсэж, татварын албадаас эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын харилцах дансны гүйлгээг хаах хүртэл арга хэмжээ авах, нийгмийн даатгалын санд ихээхэн хэмжээний өглөгтэй улмаас энэ салбарын ажилтан, албан хаагч нь Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд нийгмийн даатгалын үйлчилгээ авах боломжгүй болох зэрэг сөрөг үр дагавар үүсээд байна.

Иймд эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг дээрх өглөгийг барагдуулах зорилгоор 1,500.0 сая төгрөгөөр нэмж тодотгохоор тооцов.

4. Эрүүл мэндийн даатгалын сангийн талаар:

Улсын эмнэлэгт олгох санхүүжилт:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.6, 9.1.8 дахь хэсэгт зааснаар даатгуулагчдад үзүүлэх өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн үнийн тодорхой хэсгийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлж байна. 2017 оны эхний хагас жилийн байдлаар өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчийн 6 эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэл батлагдсан төсвийн сарын хуваариас хоёр дахин хэтэрч үйлчлүүлэгчдийн тоо, мэс засал хийлгэх даатгуулагчдын хэрэгцээ шаардлага цаашид өсөх хандлагатай байна.

Мөн Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага болон орон нутгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээ, тоног төхөөрөмж болон барилга байшин, орны тоо зэрэг хүчин зүйлүүд нэмэгдсэнтэй холбоотой гүйцэтгэл нэмж гарах тул төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын 2017 оны хагас жилийн гүйцэтгэл, урьдчилсан тооцоогоор төсвийг 11.6 тэрбум төгрөгөөр нэмж тусгав.

Элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээ

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын 2017 оны төсөвт насны ангилал харгалзахгүйгээр элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох зориулалтаар 4.9 тэрбум төгрөг буюу 30.0 мянган даатгуулагчийн /хоёр хүртэлх удаагийн/ шинжилгээний зардлын төлбөрийг санхүүжүүлэхээр тооцон төсөвлөсөн.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн мэдээллийн санд 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 40-65 насны 44.7 мянган даатгуулагч С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамрагдан бүртгүүлсэн бөгөөд дээрх

даатгуулагчдын нэг удаагийн вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд 8.6 тэрбум төгрөг зарцуулахаар байгаа тул 3.7⁴ тэрбум төгрөгийг нэмж тусгахаар тооцов.

6. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА

6.1. Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагын 2016 оны гүйцэтгэл, 2017 оны төсөөллийн талаар

Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулан өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д харьцуулсан харьцааг 2016 оны төсвийн жилд 88.0 хувиас, 2017 оны төсвийн жилд 85.0 хувиас, 2018 оны төсвийн жилд 80.0 хувиас, 2019 оны төсвийн жилд 75.0 хувиас, 2020 оны төсвийн жилд 70.0 хувиас, 2021 оны төсвийн жилээс эхлэн 60.0 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан. Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагын 2016 оны гүйцэтгэл, 2017 оны төсөөлөл дараах байдалтай байна.

Хүснэгт № 29. Төсвийн тусгай шаардлагын тооцоолол /тэрбум төгрөг/

| ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ | 2016.12.31 | 2017.06.30 | 2017 ХБГ |
|--|-----------------|-----------------|-----------------|
| I. Засгийн газрын дотоод өр | 6,464.9 | 5,402.5 | 5,369.3 |
| 1.1 Үнэт цаас | 5,488.8 | 4,596.6 | 4,402.6 |
| 1.2 Концесс | 668.9 | 805.9 | 966.7 |
| II. Засгийн газрын гадаад өр | 12,363.8 | 13,606.7 | 17,693.1 |
| 2.1 Үнэт цаас | 5,380.5 | 6,486.7 | 8,565.6 |
| 2.2 Зээл | 6,983.3 | 7,119.9 | 9,127.4 |
| III. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг | 3,451.5 | 1,777.9 | 1,852.5 |
| 3.1 Засгийн газрын өрийн баталгаа | 3,451.5 | 1,777.9 | 1,852.5 |
| ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III) | 22,280.1 | 20,787.0 | 24,914.8 |
| ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ) | 18,861.0 | 18,478.6 | 20,513.9 |
| Хуулнар тогтоосон өрийн хязгаар | 88.0% | 85.0% | 85.0% |
| Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ - ХБГ | 78.8% | 70.9% | 74.8% |

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 22,280.1 тэрбум төгрөг байгаа ба өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 78.8 хувьтай тэнцэж хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан.

Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл 2017 оны эцэст 24,914.8 тэрбум төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн өрийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 74.8 хувьд хүрэх төсөөлөлтэй байгаа нь хуульд заасан тусгай шаардлагыг хангахаар байна.

⁴ “Нэмэлт санхүүжилт хүсэх тухай” Эрүүл мэндийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 1а/3229 дугаар албан бичгээр нийт 3.7 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцоо ирүүлсэн болно.

Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагад тусгагдсан үзүүлэлтүүд нь тайлант хугацааны эцсийн төгрөгтэй харьцах гадаад валютын албан ханш, оны үнээр илэрхийлсэн ДНБ-ний хэмжээ, Засгийн газрын шинээр хийх зээллэг, зээллэгийн эргэн төлөлт болон өрийн удирдлагын бодлого, зохицуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарч өөрчлөгдөх магадлалтай.

6.2. Засгийн газрын 2017 оны гадаад, дотоод зээллэгийн үйлчилгээний төлбөр

Засгийн газрын зээллэгийн хүүгийн төлбөрт 2017 оны батлагдсан төсвийн тодотголын хүрээнд 1,201.8 тэрбум төгрөгийг төлөхөөр тооцсон бол төсвийн тодотголоор 1,156.7 тэрбум төгрөг болж, 45.1 тэрбум төгрөгөөр зардлыг бууруулж байна.

Хүснэгт № 30. Засгийн газрын зээллэгийн үйлчилгээний төлбөрийн тооцоолол /тэрбум төгрөг/

| № | ҮЗҮҮЛЭЛТҮҮД | 2017 год 1 | 2017 год 2 | Зөрүү |
|---|--|----------------|----------------|--------------|
| | Засгийн газрын зээллэгийн үйлчилгээний төлбөр | 1,201.8 | 1,156.7 | -45.1 |
| 1 | Засгийн газрын гадаад зээллэгийн үйлчилгээний төлбөр | 593.1 | 574.0 | -19.1 |
| 2 | Засгийн газрын дотоод зээллэгийн үйлчилгээний төлбөр | 608.7 | 582.6 | -26.0 |

Засгийн газрын богино хугацаат дотоод үнэт цаасны анхдагч зах зээлийн хүүгийн хувь оны эхнээс 6-6.3 хувиар, дунд хугацаат үнэт цаасны анхдагч зах зээлийн хүүгийн хувь оны эхнээс 2.9-4.3 хувиар буурснаас шалтгаалан Засгийн газрын дотоод зээллэгийн үйлчилгээний төлбөр төлөвлөснөөс 26.0 тэрбум төгрөгөөр хэмнэгдэж, 582.6 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөхөөр байна.

Засгийн газрын гадаад зээллэгийн үйлчилгээний төлбөрийн хувьд гадаад валютын ханшийн бууралт, ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд хоёр болон олон талт зээлдүүлэгчид (гадаад орон, олон улсын банк санхүүгийн байгууллага)-ээс төсвийн дэмжлэг хэлбэрээр олгогдох хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийн ашиглалт хойшилсонтой холбоотойгоор 19.1 тэрбум төгрөгөөр буурч, 574.0 тэрбум төгрөгийн төлбөр төлөгдөхөөр байна.

6.3. Засгийн газрын өрийн удирдлагын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Засгийн газраас 2017 оны төсвийн жилд өрийн удирдлагын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Олон Улсын Валютын Сантай хамтарч хэрэгжүүлэх Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд бусад гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас хөнгөлөлттэй нөхцөлтэй төслийн болон хөтөлбөрийн зээлийн эх үүсвэрийг түлхүү авч ашиглах, тэрхүү хэмжээгээр төсвийн алдагдлыг санхүүжүүлэх;
- Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүй болох, гадаад валютын нөөц багассанаас үүдэн төгрөгийн ханшийн огцом унах зэрэг эрсдэлүүдээс сэргийлэн Засгийн газрын гадаад үнэт цаасыг эргэн төлөгдөх хугацаанаас өмнө дахин санхүүжүүлэх;

- Дотоодын болон олон улсын зах зээлд гаргах үнэт цаасны арилжааг тогтмолжуулах замаар үнэт цаасны жишиг хүүгийн түвшнийг тогтоох, тогтсон өгөөжийн муруйг бий болгох;
- Хөрөнгө оруулагч нарт тогтмол мэдээлэл хүргэж, хоорондын харилцааг идэвхжүүлэх замаар шинээр хийх зээллэгийн хүүгийн түвшнийг бууруулан, тогтвортой түвшинд барих, хөрөнгө оруулагчдын талаар мэдээллийн санг бүрдүүлэх;
- Өрийн зохицуулалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, зээлжих зэрэглэл, төлөвийг сайжруулах;
- Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудыг мэдээллээр тогтмол хангаж, нягт хамтран ажиллах.

7. ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

Монгол Улсын 2017 оны төсвийн тодотголын дээр дурдсан өөрчлөлтүүдийг тусгахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 501.4 тэрбум төгрөгөөр өсөж 6,537.1 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн 498.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 9,248.6 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн нийт алдагдал - 2,711.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -9.9 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт № 31. Тодотголоор орж буй өөрчлөлтүүд /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | ӨӨРЧЛӨЛТ |
|--------------------------------------|----------|
| НИЙТ ОРЛОГЫН ДҮН | 601.5 |
| Тогтворжуулалтын сангийн орлого | 33.6 |
| Ирээдүйн өв сангийн орлого | 66.5 |
| ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО | 501.4 |
| НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 498.5 |
| Урсгал зардал | 105.2 |
| Хөрөнгийн зардал | 308.1 |
| Эргэж төлөгдөх цэвэр зээл | 85.2 |
| ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ | 2.9 |

Хүснэгт № 32. Тодотгол 1, тодотгол 2-ын харьцуулалт /тэрбум төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2017 Тод 1 | 2017 Тод 2 | Өөрчлөлт |
|-----------------------------------|---------------|---------------|----------|
| НИЙТ ОРЛОГО | 6,511.3 | 7,112.9 | 601.5 |
| НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО | 6,035.7 | 6,537.1 | 501.4 |
| НИЙТ ЗАРЛАГА | 8,750.1 | 9,248.6 | 498.5 |
| НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ | -2,714.4 | -2,711.5 | 2.9 |
| ДНБ-д эзлэх хувь | -10.4% | -9.9% | 0.5% |
| ДНБ | 26,052.0 | 27,438.0 | 1,386.0 |

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагын дагуу Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь ДНБ-ий -10.4 хувиас хэтрэх ёсгүй. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь 2017 оны 4 дүгээр сарын 14-нд батлагдсан төсвийн тодотголоор ДНБ-ий -10.4 хувь байсан бол ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн эхний шатны үнэлгээний

хүрээнд тохиролцсон өөрчлөлтүүдийг төсөвт тусгаснаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ДНБ-ий -9.9 хувь болж төлөвлөгөөнөөс даруй 0.5 пунктээр сайжрахаар байна.

o O o

**3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ,
ТАНИЛЦУУЛГА**



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34.1.4-т Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх тохиолдолд тодотголын төслийг боловсруулна гэж заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик шаардлага

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр сангуудын нийт орлого төлөвлөснөөс 4.0 орчим хувиар давж биелэхээр байгаа нь нийгмийн даатгалын сангийн төсвийг нэмж тодотгох шаардлагыг бий болгож байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний эрэлт нэмэгдсэн, эмнэлгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй холбоотой хөрөнгө оруулалттай холбоотой урсгал зардлыг санхүүжүүлэх хэрэгцээ өссөн зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай болсон байна.

Түүнчлэн “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хамрагдах иргэдийн тоо төлөвлөж байснаас нэмэгдсэн зэргээс шалтгаалан элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээний зардал урьдчилсан гүйцэтгэлээр нэмэгдэхээр байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь нэг зүйлтэй байна.

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан орлогын хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарлагын хэмжээг тус тус өөрчилнө.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар 2017 онд Нийгмийн даатгалын сангаас олгох улсын болон хувийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын даатгуулагчдад үзүүлэх үйлчилгээ, нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийг цаг тухайд нь санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хууль, тогтоомжийн төсөл боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар сарын ...ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн дараахь зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3, 4 дүгээр зүйл:

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын санд 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

| Д/д | Орлогын төрөл | Дүн /сая төгрөгөөр/ |
|----------|---|---------------------|
| 1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 1,467,914.4 |
| | 1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл | 546,617.8 |
| | 1.2 Ажиллагсдаас төлөх шимтгэл | 525,603.0 |
| | 1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл | 160,668.7 |
| | 1.4 Нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл | 0.3 |
| | 1.5 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл | 52.0 |
| | 1.6 Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл | 58,680.5 |
| | 1.7 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл | 59,352.7 |
| | 1.8 Эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл | 27,326.8 |
| | 1.9 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл | 3,078.2 |
| | 1.10 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл | 978.0 |
| | 1.11 Бусад орлого | 85,556.5 |
| 2 | Сангийн сайд | 570,232.4 |
| | 2.1 Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 570,232.4 |
| | Нийт орлого | 2,038,146.8 |

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

| Д/д | Зарлагын төрөл | Дүн /сая төгрөгөөр/ |
|----------|--|---------------------|
| 1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | |
| | 1.1 Тэтгэврийн даатгалын сан | 1,404,356.2 |
| | 1.2 Тэтгэмжийн даатгалын сан | 101,996.3 |
| | 1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан | 31,495.4 |
| | 1.4 Ажилгүйдлийн даатгалын сан | 35,433.0 |
| | 1.5 Эрүүл мэндийн даатгалын сан | 312,767.8 |
| | 1.6 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны төлбөр | 117.6 |
| | 1.7 Үйл ажиллагааны урсгал зардал | 20,916.4 |
| | Нийт зарлага | 1,907,082.8 |

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТУХАЙ

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нийгмийн даатгалын санд 1,412.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,891.8 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд зарцуулж, төрөөс нийгмийн даатгалын санд олгох татаасын хэмжээг 587.3 тэрбум төгрөгөөр баталсан.

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 1,467.8 тэрбум төгрөг, нийт зарлага 1,907.1 тэрбум төгрөг, төрөөс тэтгэврийн даатгалын санд олгох татаасын хэмжээ тэтгэврийн даатгалын сангийн орлого нэмэгдэж алдагдал буурснаас шалтгаалан 17 тэрбум төгрөгөөр буурч 570.2 тэрбум төгрөг байхаар тооцов.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2017 оны төсөвт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага дараах хүчин зүйлсийн нөлөөллөөр үүсч байна.

Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангийн орлогын талаар:

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нийгмийн даатгалын санд 1,412.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 1,891.8 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд зарцуулахаар баталсан.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар 40.3 мянган аж ахуйн нэгж, байгууллага, 694.7 мянган даатгуулагч албан журмын даатгалд, 171.3 мянган даатгуулагч сайн дурын даатгалд, 1,899.6 мянган иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан нь урд оны мөн үетэй харьцуулахад даатгуулагчдын тоо 3.0 хувиар, Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаанаас үзэхэд ажиллагчдын дундаж цалин 959.0 мянган төгрөгт хүрч 7.0 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Эхний хагас жилд нийгмийн даатгалын санд төлөвлөсөн орлогын 50.6 хувийг буюу 715.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь энэ оны эцэст сангийн орлого 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 11.3 хувиар өсөхөөр байна.

Нийгмийн даатгалын хамрах хүрээ нэмэгдэн орлого өссөнөөр сангийн 2017 оны урьдчилсан гүйцэтгэл нь батлагдсан орлогын төсвөөс 54.0 тэрбум төгрөгөөр давж 1,467.8 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

2. Ажилгүйдлийн тэтгэмжийн талаар:

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн жилийн эцсийн тайлан, сарын мэдээ, эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудаас ирүүлсэн санал, судалгаанаас үзэхэд ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжид 2016 онд 27.5 тэрбум төгрөг олгохоос 31.6 тэрбум төгрөг олгож төсөв 4.1 тэрбум төгрөгөөр хэтэрсэн, 2017 оны 06 дугаар сарын 31-ний байдлаар 17.4 тэрбум төгрөг олгохоос 18.8 тэрбум төгрөг олгож 1.4 тэрбум төгрөгөөр тус тус хэтэрсэн болно. 2017

онд 29.6 тэрбум төгрөг зарцуулахаас эхний 6 сарын байдлаар 63.5 хувийг зарцуулаад байна.

Энэ нь эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл, байдал болон сонгуулийн жилтэй холбоотойгоор ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 2015 онд 18.7 мянга байсан бол 2016 онд 23.2 мянгад хүрч өссөн, 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 24.3 мянгад хүрэх төлөвтэй байна. Иймд ажилгүйдлийн тэтгэмжийн зардлын 2017 оны төсвийг 5.7 тэрбум төгрөгөөр нэмж тодотгох шаардлагатай байна.

Харин Үндэсний статистикийн хорооны судалгаанаас үзэхэд төрсөн эхчүүдийн тоо 2014 онд 80.0 мянга, 2015 онд 80.4 мянган хүнд хүрч нэмэгдсэн боловч 2016 онд 77.6 мянга болж буурсан, 2017 онд мөн буурахаар байна.

Иймд тэтгэмжийн даатгалын сангаас олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмжид 2017 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар 40.8 тэрбум төгрөг олгохоос 32.8 тэрбум төгрөг олгож, сангийн зарлага хэмнэлттэй байгаа тул тэтгэмжийн даатгалын сангийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн зардлын төсвийг 7.3 тэрбум төгрөгөөр бууруулж, ажилгүйдлийн тэтгэмжийн зардлын төсвийг 5.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн зохицуулалт хийсэн.

3. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийн талаар:

Нийгмийн даатгалын үйлчилгээний хамрах хүрээ жил бүр өсөн нэмэгдсээр байна. Тухайлбал, нийгмийн даатгалд 2012 онд 30.5 мянган ажил олгогч, 2.3 сая даатгуулагч хамрагдан 800.0 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, сангаас 918.7 тэрбум төгрөг зарцуулсан бол 2017 онд 43.1 мянган ажил олгогч, 3.0 орчим сая даатгуулагч хамрагдан сангийн орлого 1,412.6 тэрбум төгрөгт хүрч 2012 онтой харьцуулахад 1.6 дахин, сангийн зарлага 1,891.8 тэрбум төгрөгт хүрч 1.9 дахин нэмэгдсэн байна.

Харин нийгмийн даатгалын сангийн 2016, 2017 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын ажилтан, албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн төсвийг 2016 онд 2015 оны батлагдсан төсвөөс 871.3 сая төгрөгөөр, 2017 онд 2016 оны батлагдсан төсвөөс 205.9 сая төгрөгөөр, нийт дүнгээр 1,077.2 сая төгрөгөөр бууруулан баталсан.

Ингэснээр эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын хэмжээнд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 503.0 сая төгрөгийн цалин, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгтэй гарсан бөгөөд 2017 оны 06 дугаар сарын 31-ний байдлаар энэхүү өглөг 1,072.8 сая төгрөгт хүрч, энэ оны эцэст хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,575.4 сая төгрөгт хүрэхээр байна.

Нийгмийн даатгалын хамрах хүрээ, үйлчилгээний нэр төрөл жил бүр өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын ажилтан, албан хаагчдын ажлын ачаалал нэмэгдэж, нэг ажилтанд тогтоосон норм, норматив хэтэрч байгаа үед цалингийн сангийн төсвийг нэмэхгүй бууруулснаас иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэхэд хүндрэл үүсэж, татварын албадаас эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын харилцах дансны гүйлгээг хаах хүртэл арга хэмжээ авах, нийгмийн даатгалын санд ихээхэн хэмжээний өглөгтэй

улмаас энэ салбарын ажилтан, албан хаагч нь Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд нийгмийн даатгалын үйлчилгээ авах боломжгүй болох зэрэг сөрөг үр дагавар үүсээд байна.

Иймд эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг дээрх өглөгийг барагдуулах зорилгоор 1.5 тэрбум төгрөгөөр нэмж тодотгох шаардлагатай байна.

4. Эрүүл мэндийн даатгалын сангийн талаар:

Улсын эмнэлэгт олгох санхүүжилт:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.6, 9.1.8 дахь хэсэгт зааснаар даатгуулагчдад үзүүлэх өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн үнийн тодорхой хэсгийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлж байна. 2017 оны эхний хагас жилийн байдлаар өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчийн 6 эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэл батлагдсан төсвийн сарын хуваариас хоёр дахин хэтэрч үйлчлүүлэгчдийн тоо, мэс засал хийлгэх даатгуулагчдын хэрэгцээ шаардлага цаашид өсөх хандлагатай байна.

Мөн Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага болон орон нутгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээ, тоног төхөөрөмж болон барилга байшин, орны тоо зэрэг хүчин зүйлүүд нэмэгдсэнтэй холбоотой гүйцэтгэл нэмж гарах тул төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын 2017 оны хагас жилийн гүйцэтгэл, урьдчилсан тооцоогоор төсвийг 11.6 тэрбум төгрөгөөр нэмж тусгав.

Элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээ

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын 2017 оны төсөвт насны ангилал харгалзахгүйгээр элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох зориулалтаар 4.9 тэрбум төгрөг буюу 30.0 мянган даатгуулагчийн /хоёр хүртэлх удаагийн/ шинжилгээний зардлын төлбөрийг санхүүжүүлэхээр тооцон төсөвлөсөн.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн мэдээллийн санд 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 40-65 насны 44.7 мянган даатгуулагч С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд хамрагдан бүртгүүлсэн бөгөөд дээрх даатгуулагчдын нэг удаагийн вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд 8.6 тэрбум төгрөг зарцуулахаар байгаа тул 3.7 тэрбум төгрөгийг нэмж тусгах шаардлагатай байна.

4. ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД

| | НЭГДСЭН ТӨСӨВ | УЛСЫН ТӨСӨВ | НДС | ОРОН НУТАГ |
|---|---------------------|---------------------|---------------------|---------------------|
| НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 25.9 | 19.3 | | |
| ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН | 0.9 | 0.9 | | |
| ИРЭЭДҮЙН ӨВ САН | 1.2 | 1.2 | | |
| ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 23.8 | 17.2 | 7.4 | 8.0 |
| 1. Татварын орлого | 20.6 | 12.9 | 5.3 | 3.2 |
| 1.1. Орлогын албан татвар | 4.9 | 2.7 | 0.0 | 2.2 |
| 1.1.1 Хувь хүний орлогын албан татвар | 2.2 | 0.0 | 0.0 | 2.2 |
| 1.1.2 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар | 2.7 | 2.7 | 0.0 | 0.0 |
| 1.1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж | 4.6 | 0.0 | 5.3 | 0.0 |
| 1.3. Хөрөнгийн албан татвар | 0.4 | 0.0 | 0.0 | 0.4 |
| 1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар | 5.3 | 5.3 | 0.0 | 0.0 |
| 1.5. Онцгой албан татвар | 1.9 | 1.9 | 0.0 | 0.0 |
| 1.6. Тусгай зориулалтын орлого | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 1.7. Гаалийн албан татвар | 1.8 | 1.8 | 0.0 | 0.0 |
| 1.8. Бусад татвар (төлбөр, хураамж) | 1.9 | 1.2 | 0.0 | 0.7 |
| 2. Татварын бус орлого | 3.2 | 4.4 | 2.1 | 4.8 |
| 2.1. Нийтлэг бус татварын орлого | 2.9 | 2.7 | 0.0 | 0.2 |
| 2.2. Хөрөнгийн орлого | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 2.3. Тусламжийн орлого | 0.3 | 0.3 | 0.0 | 0.0 |
| 2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 1.4 | 2.1 | 4.5 |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 33.7 | 27.4 | 7.0 | 8.2 |
| А. УРСГАЛ ЗАРЛАГА | 25.3 | 20.5 | 7.0 | 6.8 |
| 1. Бараа, үйлчилгээний зардал | 11.3 | 7.3 | 0.1 | 4.5 |
| 1.1. Цалин, хөлс | 6.4 | 3.7 | 0.0 | 2.7 |
| 1.2. Нийгмийн даатгалын шимтгэл | 0.0 | 0.3 | 0.0 | 0.3 |
| 1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал | 4.8 | 3.3 | 0.0 | 1.5 |
| 2. Зээлийн үйлчилгээний төлбөр | 4.2 | 4.2 | 0.0 | 0.0 |
| 3. Татаас ба урсгал шилжүүлэг | 9.8 | 8.9 | 6.9 | 2.3 |
| 3.1. Татаас | 0.7 | 2.4 | 0.2 | 0.3 |
| 3.2. Урсгал шилжүүлэг | 9.1 | 6.6 | 6.7 | 2.0 |
| Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 6.9 | 5.5 | 0.0 | 1.3 |
| 1. Барилга байгууламж | 3.9 | 3.8 | 0.0 | 0.2 |
| 2. Их засвар | 0.3 | 0.3 | 0.0 | 0.0 |
| 3. Тоног төхөөрөмж | 0.4 | 0.4 | 0.0 | 0.0 |
| 4. Бусад хөрөнгө | 2.2 | 1.0 | 0.0 | 1.1 |
| 5. Стратегийн нөөц хөрөнгө | 0.1 | 0.1 | 0.0 | 0.0 |
| В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ | 1.5 | 1.4 | 0.0 | 0.1 |
| 1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл | 0.8 | 0.8 | 0.0 | 0.0 |
| 2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл | 0.7 | 0.6 | 0.0 | 0.1 |
| ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН) | -9.9 | -10.2 | 0.5 | -0.2 |
| ДНБ | 27,438,000.0 | 27,438,000.0 | 27,438,000.0 | 27,438,000.0 |

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨСӨЛ

| | /сая төгрөг/ | | | | | | | | | | | |
|--|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|--------------------|-------------------|
| | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | | | | |
| | Гүйц | Гүйц | Гүйц | Гүйц | Гүйц | Гүйц | Төл | Гүйц | Төл | Тод 1 | Тод 2 | ЗӨРҮҮ |
| . 1 . | . 2 . | . 3 . | . 4 . | . 5 . | . 6 . | . 7 . | . 8 . | . 9 . | . 10 . | . 11 . | . 11 - 10 . | |
| НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,488,490.4 | 3,351,389.0 | 3,481,171.9 | 4,057,257.2 | 4,244,274.3 | 3,834,039.9 | 3,566,591.4 | 3,894,443.3 | 4,608,938.7 | 4,751,976.7 | 5,305,390.6 | 553,414.0 |
| ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН | 0.0 | 241,019.9 | 94,656.5 | 46,858.6 | 39,913.8 | 2,333.7 | 0.0 | 0.0 | 8,397.8 | 208,800.7 | 242,417.9 | 33,617.2 |
| ИРЭЭДҮЙН ӨВ САН | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 221,651.0 | 266,808.4 | 333,345.1 | 66,536.7 |
| ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,488,490.4 | 3,110,369.1 | 3,386,515.4 | 4,010,398.6 | 4,204,360.5 | 3,831,706.2 | 3,566,591.4 | 3,894,443.3 | 4,378,889.9 | 4,276,367.5 | 4,729,627.7 | 453,260.1 |
| 1. Татварын орлого | 1,937,917.2 | 2,461,688.9 | 2,585,587.0 | 3,196,869.1 | 3,119,620.7 | 2,943,409.5 | 2,533,795.9 | 2,854,078.6 | 2,965,565.3 | 2,969,853.4 | 3,527,622.4 | 557,769.0 |
| 1.1. Орлогын албан татвар | 814,026.3 | 601,481.6 | 524,381.8 | 863,754.0 | 621,237.0 | 688,496.8 | 433,900.0 | 519,958.7 | 495,450.9 | 495,450.9 | 728,674.7 | 233,223.8 |
| 1.1.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 390,854.5 | 545,631.1 | 524,325.9 | 863,754.0 | 621,237.0 | 688,496.8 | 433,900.0 | 519,958.7 | 495,450.9 | 495,450.9 | 728,674.7 | 233,223.8 |
| 1.1.2 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | 423,171.8 | 55,850.6 | 55.9 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | 423,171.8 | 55,850.6 | 55.9 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 1.2 Нэмэгдсэн өртгийн албан татвар | 579,119.6 | 1,114,382.5 | 1,296,450.9 | 1,435,091.6 | 1,371,725.4 | 1,049,588.7 | 1,081,358.1 | 1,140,721.4 | 1,273,946.8 | 1,284,731.1 | 1,448,504.9 | 163,773.8 |
| 1.2.1 Дотоодын архины барааны | 207,721.9 | 365,840.0 | 496,619.7 | 574,150.1 | 550,613.7 | 485,186.5 | 520,000.0 | 558,329.9 | 584,790.9 | 579,547.7 | 600,702.5 | 21,154.8 |
| Үүнээс: Улсын төсвийн орлого | 207,721.9 | 365,840.0 | 496,619.7 | 574,150.1 | 550,613.7 | 485,186.5 | 520,000.0 | 558,329.9 | 584,790.9 | 579,547.7 | 600,702.5 | 21,154.8 |
| 1.2.2 Импортын барааны | 422,804.7 | 809,538.9 | 862,361.3 | 937,479.0 | 916,570.1 | 671,863.8 | 663,358.1 | 684,254.3 | 859,155.9 | 847,420.7 | 1,005,039.7 | 157,619.0 |
| 1.2.3 НӨАТ-ын буцаан олголт | -51,407.0 | -60,996.4 | -62,530.0 | -76,537.5 | -95,458.5 | -107,461.5 | -102,000.0 | -101,862.8 | -170,000.0 | -142,237.3 | -157,237.3 | -15,000.0 |
| 1.3 Онцгой албан татвар | 268,526.7 | 293,967.0 | 312,384.2 | 449,410.3 | 454,390.3 | 592,323.6 | 531,836.1 | 630,124.8 | 547,208.2 | 490,781.4 | 511,577.7 | 20,796.3 |
| 1.3.1 Дотоодын архины онцгой албан татвар | 68,046.8 | 67,954.9 | 92,659.8 | 148,204.4 | 160,352.8 | 128,999.3 | 114,179.6 | 138,430.4 | 123,142.5 | 136,142.5 | 136,142.5 | 0.0 |
| 1.3.2 Импортын архины онцгой албан татвар | 24,791.8 | 34,891.9 | 49,152.3 | 79,946.5 | 100,149.5 | 80,462.1 | 3,889.8 | 83,818.4 | 3,799.2 | 5,697.1 | 5,697.1 | 0.0 |
| 1.3.3 Импортын тамхины онцгой албан татвар | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 63,701.6 | 0.0 | 62,427.6 | 74,347.7 | 74,493.9 | 146.2 |
| 1.3.4 Импортын пивоны онцгой албан татвар | 5,090.8 | 5,734.1 | 7,397.3 | 10,101.0 | 7,909.5 | 4,688.9 | 3,383.3 | 4,879.3 | 3,417.2 | 4,928.1 | 2,032.4 | -2,895.7 |
| 1.3.5 Суудлын автомашины онцгой албан татвар | 54,525.2 | 112,347.3 | 112,271.0 | 104,393.9 | 90,272.9 | 43,460.0 | 24,002.6 | 27,064.3 | 23,522.5 | 57,343.1 | 80,889.0 | 23,545.9 |
| 1.3.6 Автобензин, дизель түлшний онцгой албан татвар | 92,546.4 | 48,637.1 | 17,634.2 | 45,357.0 | 22,094.2 | 279,142.4 | 271,024.2 | 320,745.0 | 274,420.8 | 155,844.4 | 155,844.4 | 0.0 |
